

Лүгэжана

Түүний гайхамшигтай
ач ивээл, х. 10, 12

Яагаад бид семинарт явдаг вэ?
х. 20, 46, 48

Эцэг эхчүүд ээ, хүүхдүүдтэйгээ
ярилцах цаг гаргаж бай, х. 34

Хүүхдүүд ээ, аав ээжтэйгээ
ярилцаж бай, х. 58





МИННЕАПОЛИСЫН УРЛАГИЙН ИНСТИТУТЫН ПАТНАМ ДАНА МКМИЛПАНЫ САНГИЙН (МИННЕСОТА, АНУ) ЗӨВШӨӨРЛӨӨР НИЙТЛЭВ, ХУЛБАРТАЖ БОЛОХГҮЙ

Гэгээнтэн Петр юуны учир үгүйсгэсэн бэ? Геррит ван Хонфорст

“Нэгэн зарц охин Петрийг галын дэргэд суухыг хараад,

. . . Энэ хүн бас [Есүстэй] хамт байсан гэхэд

“Петр үүнийг үгүйсгэж, Эмэгтэй, Түүнийг чинь би танихгүй гэв.

Удалгүй өөр нэг нь түүнийг хараад, Чи бас тэдний нэг шүү дээ гэхэд Петр,

Хүн гуай, би биш ээ гэв.

“Дараа нь . . . өөр нэг нь, Энэ хүн бас Түүнтэй хамт байсан нь мэдээж гэлээ. . . .

“Петр, Хүн гуай, таны юу яриад байгааг би мэдэхгүй байна шүү гэв.

Гэнэт . . . тахиа донгодов. . . .

“Петр гадагшаа гарч, гашуудан уйлав” (Лук 22:56–60, 62).



ЗАХИАСУУД

4 Тэргүүн Зөвлөлийн захиас бичиг: “Тэр Амилсан”
—Бошиглогчийн гэрчлэл
Ерөнхийлөгч Томас С.Монсон

7 Айлчлагч багшийн захиас бичиг: Хайрла, хамгаал, хүчирхэгжүүл

ОНЦЛОГ ӨГҮҮЛЛҮҮД

12 Цагаатгал ба бидний амьдрал дахь аян
Ахлагч Давид А.Беднар
Бид өөрсдийн хүсэл, чадвараас илүү дээгүүр ажиллан, илүү сайн хүн болж, улам сайн үйлчлэхэд Цагаатгал бидэнд хүч чадал өгдөг.

20 Семинарын адислалууд

Бриттани Бийтти
Сүмд ирэхэд нь семинар тэдэнд хэрхэн тусалсан тухай дэлхий даяарх залуучууд өгүүлж байна.

26 Хөрвөгчийн дуудлага

Хелена Ханнонен
Салбарын төгөлдөр хуурчийн дуудлагаа биелүүлэхэд би гэрийнхэнтэйгээ хамт олон золиослол хийсэн ч, үүндээ баяртай байдаг.

30 Тойргийн зөвлөлийн ажил

ЛаРийн Гаунт
Тойргийн зөвлөлийг ямар хүмүүс бүрдүүлдэг болон тэд юу хийдэг вэ?

ХАВТСАН ДЭЭР

Нүүрэн талд: *Надад бүү хүр*, Минерва Тейчерт, Бригам Янгийн Их Сургуулийн Урлагийн Музейн зөвшөөрлөөр нийтлэв.
Ар талд: *Миний мутрыг болгоогтун*, Жефф Вард.

ХЭСГҮҮД

8 Дөрөвдүгээр сарын Чуулганы тэмдэглэлээс: Ерөнхий чуулганаас улам ихийг сурч мэдэх нь
Майкл Барбер, Давид Марш нар

10 Бид Христийн тухай ярьж байна: Гайхамшигтай ач ивээл
Кристен Николе Кардон

34 Бидний гэр орон, гэр бүл: Ярилцах болон сонсох цаг гаргаж бай
Роземари М.Виксом

38 Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн дуу хоолой

74 Сүмийн мэдээ

79 Гэр бүлийн үдшийн санаанууд

80 Биднийг дахин уулзалт: Цагаатгалд найдах нь
Бишоп Ричард К.Эйжли



42 Хүн болгон Блекийг танина
Адам К.Өүлсон
Сагсан бөмбөг Блекийн дуртай зүйл бөгөөд сорилт болон адислалыг хоёуланг нь түүнд авчирчээ.



Энэ дугаарт
нуусан Лиахонаг
олоорой.
Санамж: Зөв
хуудсыг сонго.

46 Асуулт, хариулууд
Би судруудыг бие даан судалж чадах байтал яагаад семинарт явах хэрэгтэй юм бэ?

48 Бид яагаад семинарт явах ёстой юм бэ?
Долоон бошиглогч семинараас ирдэг адислалуудын тухай өгүүлж байна.

50 Эквадорын ширэнгэн ой дахь семинар
Жошуа Ж.Перки

Салбарын гишүүдийн олонх нь саяхныг хөрвөгчид болох нэгэн шинэ салбарт семинар залуучуудыг хэрхэн гэрчлэл, мэдлэг, итгэлтэй болгосон тухай.


52 Семинарын дараа яах вэ?
Давид А.Эдвардс
Таныг институтэд урьж байна.

53 Шат шатаар:
2 Тимот 3:16-17

54 Сүйрэлд бүү хүр
Адам К.Өүлсон
Одоо багахан хүч чармайлт гаргаж, бэлтгэлтэй байснаар хожмын том асуудлуудаас урьдчилан сэргийлж чадна.

57 Үзүүлэн: Судруудыг шимтэн судал

48



58 Ярилцах цаг
Хилари Уоткинс Лемон
Сургууль дээр болсон нэг явдал Жосигийн урмыг хугалсан ч, энэ тухай ярилцсан нь түүний сэтгэлийг сэргээжээ.

61 Тэр үхлийн хүлээсийг эвдсэн юм
Далын Ахлагч
Бид болон бидний гэр бүлүүд зөв шударга амьдарч, Тэнгэрлэг Эцэгтэйгээ дахин амьдарч болохын тулд Аврагч үхээд дахин амилсан билээ.

62 Хүүхдийн Хэсгийг гэртээ авчрах нь: Есүс Христ надад зөвийг сонгохыг заадаг

64 Дуу хөгжим:
Би Есүс шиг байхыг хичээдэг
Жанис Капп Перри

66 Нэр нэгтэй, итгэл нэгтэй эгч дүү хоёр
Хетер Вригли

68 Онцгой гэрч: Надад зориулсан Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг дагахын тулд би юу хийж болох вэ?
Ахлагч Ричард Г.Скотт

69 Миний сайн мэдээний жишгүүд

70 Бага насны хүүхдүүдэд зориулав

81 Мормоны Номны баатрууд

**2012 ОНЫ 4-Р САРЫН ДУГААР 13 NO. 2
ЛИАХОНА 10484 363**

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн
Сүмийн олон улсын сэтгүүл

Тэргүүн Зөвлөл: Томас С.Монсон, Хенри Б.Айринг,
Диетер Ф.Угдорф

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга: Боид К.Пакер,
Л.Том Перри, Рассел М.Нелсон, Даллин Х.Укс,
М.Рассел Баллард, Ричард Г.Скотт, Роберт Д.Хейлс,
Жеффри Р.Холланд, Давид А.Беднар, Квинтин Л.Кук,
Д.Тодд Кристоферсон, Нийл Л.Андерсен

Эрхлэгч: Пол Б.Пайпер

Зөвлөхүүд: Кейт Р.Эдвардс, Кристоффел Голден Бага,
Пер Ж.Малм

Гүйцэтгэх захирал: Давид Л.Фричнхет

Редакцийн захирал: Винсент А. Вон

Зургийн дарга: Аллан Р.Лоиборг

Гүйцэтгэх редактор: Р.Вал Жонсон

Гүйцэтгэх туслах редактор: Женифер Л.Грийнвүүд,
Адам К.Өүлсон

Туслах редактор: Сюзан Баррет, Раян Карр

редакцийн ажилтнууд: Бриттани Бетти, Давид А.
Эдвардс, Маттью Д.Флиттон, Ларина Портер Гаунт,
Карри Кастен, Женнифер Медди, Лиа МакКаллахан,
Меллиса Меррил, Майкл Р.Моррис, Салли Ж.Өдүкэр,
Жошуа Ж.Пөрки, Чад И.Фарес, Жан Пинбороу, Паул
Ванденберг, Мариса А. Виддисон, Мелиса Зентено

Гүйцэтгэх Зургийн захирал: Ж.Скотт Нудсен

Зургийн захирал: Скот Ван Кампен

Уран бүтээлийн менежер: Жейн Анн Петерс

Ахлах дизайнерууд: К. Кимбалл Ботт, Коллин Хинкли,
Эрик П.Жонсен, Скотт М.Моёо

Уран бүтээлийн ажилтнууд: Коллетт Небекер Аун,
Конни Бавторф Бридж, Ховард Ж.Браун, Жюли Бёрдетт,
Брайн В.Жихи, Катлийн Ховард, Денис Көрби, Жинни Ж.
Нилсон, Гейл Тейт Рафферти

Хэвлэлийн эх бэлтгэгч: Жефф Л.Мартин

Хэвлэлийн захирал: Крейг К.Седвик

Хуваарилалт хариуцсан захирал: Эван Ларсен,
Нэгдсэн Улс, Канадаас бусад орнууд дахь захиалга
болон үнийн талаар орон нутгийн Сүмийн хангамжийн
төв болон тойрог, салбарынхаа удирдагчтай холбоо
барина уу.

**Гар бичмэл болон асуултаа интернэт вебсайт
liahona.lds.org руу; шуудангаар Liahona, Rm. 2420,
50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0024,
USA хаягаар; эсвэл э-мэйлийн: liahona@ldschurch
.org хаягаар ирүүлнэ үү.**

Лиахона нь (Мормоны Номон дахь утгаараа бол
"луужин" буюу "залагч") албани, англи, армен,
бислам, болгар, вьетнам, гаити, герман, грек, дани,
индонез, ирланд, испани, итали, камбож, кирибати,
латви, литва, малагаш, маршалл, монгол, нидерланд,
норвеги, орос, польш, португали, румын, самоа,
себуано, солонгос, тагалог, тай, тахити, тонга, украин,
унгар, урду, фижи, фин, франц, хорват, хятад,
хятад (хялбаршуулсан), чех, швед, эстони, япон хэлээр
нийтлэгддэг. (Жилд нийтлэгдэх дугаарын тоо улс бүрд
өөр байна.)

© 2012 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх
хамгаалагдсан. Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Лиахона дахь сэдэв, үзүүлэн, материалуудыг онцгой
тохиолдолд арилжааны бус зорилгоор сүм болон
гэрт ашиглахын тулд хувилж болно. Урлагийн
бүтээлийг хуулбарлахыг хориглосон бол үзүүлэнг
хувилан олшруулж болохгүй. Зохиогчийн эрхийн
талаарх асуултаа Intellectual Property Office, 50 E.
North Temple St., Salt Lake City, UT 84150, USA хаягаар;
эсвэл электрон шуудангийн: cor-intellectualproperty@
ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.


For Readers in the United States and Canada:

April 2012 Vol. 13 No. 2. LIAHONA (USPS 311-480)
Mongolian (ISSN 1525-7584) is published six times a
year (January, April, June, July, October, and December)
by The Church of Jesus Christ of Latter-day Saints,
50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150. USA
subscription price is \$5.00 per year; Canada, \$6.00
plus applicable taxes. Periodicals Postage Paid at Salt
Lake City, Utah. Sixty days' notice required for change
of address. Include address label from a recent issue;
old and new address *must* be included. Send USA and
Canadian subscriptions to Salt Lake Distribution Center
at address below. Subscription help line: 1-800-537-
5971. Credit card orders (Visa, MasterCard, American
Express) may be taken by phone. (Canada Poste
Information: Publication Agreement #40017431)

POSTMASTER: Send address changes to Salt Lake
Distribution Center, Church Magazines, PO Box 26368,
Salt Lake City, UT 84126-0368.

Дэлгэрэнгүй мэдээллийг ОНЛАЙНААС үзэж болно

Liahona.lds.org



НАСАНД ХҮРЭГЧДЭД ЗОРИУЛАВ

Энэ дугаарт нэлээд хэдэн өгүүлэл
Аврагчийн тухай зааж, гэрчилж байна.
Түүний тухай дэлгэрэнгүй мэдээллийг
JesusChrist.Lds.org-аас үзнэ үү.

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

Энэ дугаарт нэлээд хэдэн өгүүлэл
семинараас ирдэг адислалуудын тухай
өгүүлж байна (хуудас 20–25, 46–53-ыг
үз). Энэ тухай нэмэлт мэдээллийг
seminary.Lds.org-аас үзнэ үү.

ХҮҮХДЭД ЗОРИУЛАВ

"Бие биенээ хайрла" дууг
сонсохын тулд (хуудас 64–65-ыг үз),
liahona.Lds.org-хаягаар орно уу.

ЭНЭ ДУГААР ДАХЬ СЭДВҮҮД

*Тоонууд нь өгүүллийн эхний
хуудсыг зааж байгаа болно.*

**Амилуулалт, Амилалт, 4, 61,
62, 70**

Гэр бүл, 34, 42, 58, 66

Дуулгавартай байдал, 54

Дуу хөгжим, 26, 64

Есүс Христ, 4, 10, 12, 61, 64, 70

Жишгүүд, 69

Залбирал, 41

Институт, 52

Мормоны Ном, 38

Номлолын ажил, 42

Семинар, 20, 46, 48, 50

Судар судлах, 53, 57, 68

Сүмийн дуудлагууд, 26, 30

Сүнслэг нөлөө, 39, 40

**Харилцаа, хэлхээ холбоо,
34, 58**

Цагаатгал, 4, 12, 61, 62, 80

ач ивээл, 10, 12

бэлтгэл, 54

ерөнхий чуулган, 8

зөвлөлүүд, 30

найдвар, 80

ТӨРӨЛХ ХЭЛЭЭРЭЭ

Лиахона болон Сүмийн бусад
материалуудыг олон хэлээр **www
.languages.Lds.org** —аас үзэж болно.

Тэр Амилсан БОШИГЛОГЧИЙН ГЭРЧЛЭЛ

Ерөнхийлөгч
Томас С.Монсон



Назарын Есүс үхэгсдээс амилсан нь Христийн ертөнцийн ихэд хүсэн хүлээсэн агуу үйл явдал байлаа” хэмээн Ерөнхийлөгч Томас С.Монсон мэдэгджээ. “Амилалтын үнэн бодит байдал нэг хүнд ч, бүх хүмүүст ч бидний ойлгодгоос илүү дээгүүр амар амгаланг өгдөг юм” (Филиппой 4: 7-г үз).¹

Ерөнхийлөгч Монсон дараах хэсгүүдэд Аврагчийн Амилалтын тухай өөрийн гэрчлэл, талархлыг хуваалцан, Хүү үхлийг ялсан учраас дэлхийд ирсэн Бурхан Эцэгийн бүх хүүхэд дахин амьдрах болно хэмээн тунхаглажээ.

Мөнх бус байдлын дараах амьдрал

“Бидний хэн нь ч бидний төлөө Христийн Гетсеманид хийсэн зүйлийн ач холбогдлыг бүрэн ойлгож чадахгүй ч, бидний төлөө хийсэн Түүний цагаатгагч золиослолын төлөө миний бие өдөр бүр баярлан талархаж явдаг билээ.

“Эцсийн мөчид Тэр эргэн буцаж болох байсан шүү дээ. Гэвч тэгээгүй юм. Тэрбээр бүх зүйлийг аврахын тулд бүх зүйлээс доогуур амьсгалаа хураасан юм. Тэрбээр ингэснээрээ мөнх бус энэхүү оршихуйн дараах амьдралыг бидэнд өгч, биднийг Адамын Уналтаас буцаан авчирсан юм.

“Миний бие сэтгэл зүрхнийхээ гүнээс Түүнд баярлан талархаж явдаг билээ. Тэр бидэнд хэрхэн амьдрахыг бас хэрхэн үхэхийг заасан юм. Тэр бидний авралыг баттай болгосон юм.”²

Үхлийн харанхуй ангалыг зайлуулсан нь

“Зарим тохиолдолд, жишээ нь, их гай зовлон, өвчин эмгэг, үхэл хагацал нь нигүүлслийн тэнгэр элч лүгээ ирдэг. Гэвч бид ихэнх тохиолдолд үүнийг хүмүүний аз жаргалын дайсан хэмээн үздэг.

“Үхлийн харанхуй ангал нь илчлэгдсэн үнэний гэрлээр эгнэгт зайлуулагдана. ‘Би бол амилалт ба амь мөн’. ‘Надад итгэдэг хүн үхэвч амьдарна. Амьд бөгөөд Надад итгэгч бүхэн хэзээ ч үхэхгүй.’ хэмээн Эзэн хэлсэн билээ.

“Үхлийн дараах амьдралын тухай энэхүү баталгаа, бүр энэхүү ариун баталгаа нь: ‘Амар амгаланг би та нарт үлдээнэ. Би Өөрийн амар амгаланг та нарт өгнө. Ертөнцийн өгдгөөс өөр юмыг би та нарт өгч байна. Та нар зүрхээ бүү зовоо. Бүү ай’ хэмээн шавь нартаа Аврагчийн амласан тэрхүү амгаланг өгч чадна.’³

Тэр энд байхгүй

“Бидний Аврагч дахин амьдарсан юм. Хүн төрөлхтний түүхийн бүх үйл явдлаас хамгийн гайхамшигтай, хамгийн их тайтгаруулагч, хамгийн их итгэл найдвар төрүүлсэн үйл явдал бол үхлийг даван туулсан ялалт мөн. Гетсемани, Калвари хоёрт болсон тэсэхийн аргагүй бэрх өвдөлт, шаналал ард үлдэж, хүн төрөлхтний аврал баталгаатай болсон билээ. Адамын Уналтаас биднийг эргүүлсэн юм.

Христийн Амилалтын өглөө хоосон байсан булш, ‘Хэрэв хүн үхвэл тэрээр амьдрах уу?’ гэсэн Иовын асуултын хариу болсон билээ. Хэрэв хүн үхвэл тэр дахин амьдарна гэдгийг би бүх дуу хоолойгоороо тунхаглаж байна. Бид үүнийг мэдэж байна, учир нь бидэнд илчлэгдсэн үнэний гэрэл байгаа. . . .

“Хайрт ах, эгч нар минь ээ, Христийн Амилалтын эхний өглөө: ‘Тэр энд байхгүй. Учир нь Тэр амилсан’ хэмээн хэлсэн тэнгэр элчийн үгсээс бид гүнзгий уй гашууд автсан үедээ агуу амар амгаланг мэдэрдэг билээ.’⁴

Бүх хүмүүс дахин амьдарна

“Бид инээж, уйлан, ажил хийж, тоглон, хайрлаж амьдардаг. Эцэст нь үхдэг. . . .



“Хэрэв нэгэн Хүн болон Түүний үүрэг зорилго байгаагүй бол, Назарын Есүс байгаагүй бол бид үхэлд үлдэх байсан. . . .

“Бурхан амьд гэдгийг миний бие онцгой гэрчийн хувьд бүх зүрх сэтгэл, оюун санааныхаа эрч хүчээр дуу хоолойгоо өргөн гэрчилж байна. Есүс бол Түүний Хүү, махан биеэр төрсөн Эцэгийн Ганц Хүү мөн. Тэр бол бидний Гэтэлгэгч; Тэнгэрлэг Эцэгийн өмнө бидний Зууч билээ. Тэрбээр бидний гэм нүглийг цагаатгахын төлөө загалмай дээр амьсгалаа хураасан юм. Тэрбээр Амиалтын анхны үр жимс болсон билээ. Тэр амиа өргөсөн учраас бүх хүмүүс дахин амьдрах болно.”⁵

Хувийн гэрчлэл

“Үхэл дийлэгдэж, булш ялагдсан гэдэг хувийн гэрчлэлээ би тунхаглаж байна. Эдгээр зүйлсийг хэрэгжүүлсэн Түүтээр ариун болгогдсон үгс бүх хүмүүст үнэн бодит мэдлэг болох болтугай. Эдгээр үгсийг санагтун. Эдгээр үгст баярлагтун. Эдгээр үгсийг хүндэтгэгтүн. *Тэр Амилсан.*”⁶ ■

ЭШЛЭЛ

1. “Тэр Амилсан,” *Лиахона*, 2003 оны 4-р сар, 7.
2. “At Parting,” *Лиахона*, 2011 оны 5-р сар, 114.
3. “Now Is the Time,” *Лиахона*, 2002 оны 1-р сар, 68; мөн Иохан 11:25–26; 14:27-г үз.
4. “Тэр Амилсан,” *Лиахона*, 2010 оны 5-р сар, 89, 90; мөн Иов 14:14; Матай 28:6-г үз.
5. “Гэтэлгэгч минь амьдыг би мэднэ!” *Лиахона*, 2007 оны 5-р сар, 24, 25.
6. *Лиахона*, 2003 оны 4-р сар, 7.

ЭНЭ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Ерөнхийлөгч Монсонгийн захиас дахь эшлэлүүдээс хуваалцсаны дараа Христийн Амиалтын баярын жинхэнэ утга учрын талаарх түүний гэрчлэлийг ажигла. Гэр бүлийн гишүүдээс дараах асуултуудыг асуу: “Амьд бошиглогч эдгээр үнэнүүдийн талаар гэрчилсэн нь та нарын хувьд ямар учир холбогдолтой вэ? Та эдгээр үнэнүүдийг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлж болох вэ?” Та үүн дээр өөрийн гэрчлэлийг нэмж болно.

Би Түүнийг дахин харна

Морган Вебек

Аав бидний хүүхэд нэг бүрийг онцгой гэдгийг мэд-рүүлж, биднийг хайрлан, ямагт уучилдаг байлаа. Хүүхэд бүрийнхээ аз жаргалын төлөө, бидний сайн сайхны төлөө аав минь чадах бүхнээ хийдэг байлаа. Би аавдаа маш их хайртай байсан.

Намайг зургадугаар ангид байхад аав минь машины ослоор нас барсан юм. Манай гэрийнхэн бүгд өнчрөл, ха-гацлын гашуун зовлон амсаж, гэрийн хойморт том хоосон зай гараад ирж билээ. Аав минь юм болгонд миний өмөг түшиг болдог байсан болохоор ямар нэг асуудал гарвал аав уруугаа л очдог байлаа. Би аавыгаа өөд болсноос хойш хэн нэгнээс тусламж хүсэхийн оронд уур, бухимдлаа дотроо хадгаладаг болж билээ. Бурхан үүнд буруутай юм шиг санадаг байсныг яана. Судар уншихаа, бас залбирахаа ч болив. Зөвхөн ээж л хүсдэг байсан учраас би сүмд явдаг

байлаа. Тэнгэрлэг Эцэгээсээ хол хөндий байхыг хичээдэг болов.

Тэгээд Залуу Эмэгтэйчүүдийн аялал зугаалгад анх удаа явлаа. Шинэ найз нөхөдтэй болсон нь таалагдсан ч, судраа уншсангүй. Бид сүүлчийн үдэш гэрчлэлийн цуглаан хийлээ. Удаан хугацаанд өөртөө байгаагүй нэг зүйлийг мэдэрсэн нь Сүнс байлаа. Босч зогсон гэрчлэлээ хуваалцсан охидыг хараад биширсэн ч, надад гэрчлэл байхгүй юм чинь гэж бодоод, суусаар байж билээ. Тэгтэл гэнэт босмоор санагдаад болсонгүй. Юу хэлэх билээ хэмээн бодлогоширсноо, Залуу Эмэгтэйчүүд аялал зугаалгын үйл ажиллагаа зохион байгуул-санд баяртай байна гэв. Тэгээд Есүс Христ миний төлөө нас барсныг, Тэнгэрлэг Эцэг минь надад хайртайг, бас Сүм үнэн гэдгийг мэднэ хэмээн хэлчихлээ.


Гайхалтай амар амгалан цээжинд бялхан байлаа. Би Аврагчийн Цагаатгал болон Амилалтын ачаар аавтайгаа дахин уулзана гэдгийг мэднэ хэмээн хэлэхэд энэ туршлага надад тусалсан юм.

ХҮҮХДЭД ЗОРИУЛАВ

Тэр амьд!

Есүс Христ нас бараад амилсан учраас бид бүгд дахин амьдрах болно гэж Ерөнхийлөгч Монсон сургасан билээ. Доорх зургийг хар. Эдгээр үйл явд-луудын болсон дэс дарааг харуулахын тулд хайрцаг бүр дээр тоо бич.

Есүс Христ амьд учраас гэр бүлүүд үүрд хамт байж чадна. Гэр бүлийнхээ зургийг доод талын хайрцганд зур.





Энэ материалыг залбиран судалж, үүний талаар айлчилж очдог эгч нартайгаа аль болох ойлгомжтойгоор харилцан ярилц. Эгч нарыг бэхжүүлэх болон Нийгмийн Халамжийн Бүлэг амьдралд чинь идэвхтэй үүрэг гүйцэтгэхэд туслах асуултуудыг асуу.

Хайрла, хамгаал, хүчирхэгжүүл

Айлчлагч багш нар Аврагч шиг нэг нэгээр нь үйлчилдэг (3 Нифай 11:15-ыг үз). Хэрэв манай эгч нар: (1) миний айлчлагч багш надад сүнслэг байдлаараа өсч хөгжихөд тусалдаг; (2) айлчлагч багш надад болон манай гэр бүлд байнга анхаарал тавьдаг; (3) хэрэв надад асуудал гарвал айлчлагч багш намайг хүлээлгүйгээр арга хэмжээ авна гэдгийг би мэднэ хэмээн хэлдэг байвал эгч нартаа үйлчлэх бидний ажил сайн байгаа нь тэр.¹

Айлчлагч багш бид эгч нараа хэрхэн хайрлаж, хамгаалан, хүчирхэгжүүлэх вэ? *Daughters in My Kingdom: The History and Work of Relief Society* товхимлын 7-р бүлэгт эгч нартаа үйлчлэхэд нь айлчлагч багш нарт туслах дараах есөн зөвлөмж байдаг:

- Айлчилдаг эгчийнхээ төлөө, гэр бүлийнх нь төлөө өдөр бүр залбир.
- Түүнийг болон гэр бүлийг нь мэдэхийн төлөө сүнсний удирдамжийг эрж хай.
- Ажил амьдрал нь ямар байгааг мэдэж, тайтгаруулан, хүч чадал өгөхийн тулд түүнтэй тогтмол уулзаж бай.
- Очиж уулзах, утсаар ярих, захидал, э-мэйлээр харилцах, зурвас (мессеж) бичих, нинжин сэтгэлийн энгийн үйлдэл зэргээр түүнтэй байнга холбоотой бай.
- Сүмийн цуглаанууд дээр түүнтэй мэндэлж бай.
- Онцгой үйл явдал, өвчин зовлон, тулгамдсан аливаа асуудал тохиолдсон үед нь түүнд тусалж бай.
- Сайн мэдээг судруудаас болон айлчлагч багшийн захиасуудаас заа.
- Сайн үлгэр дууриал үзүүлснээр түүнд сүнслэгээр нөлөөл.



- Айлчилж очдог эгчийнхээ сүнслэг болон материаллаг байдлын талаар Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагчид мэдээлж бай.

Судруудаас

Лук 10:38–39; 3 Нифай 11:23–26; 27:21

ЭШЛЭЛ

1. Жюли Б. Бек, “What I Hope My Granddaughters (and Grandsons) Will Understand about Relief Society,” *Лианахона*, 2011 оны 11-р сар, 113-ыг үз.
2. *Daughters in My Kingdom: The History and Work of Relief Society* (2011), 112.
3. *Daughters in My Kingdom*, 119–20.
4. Бригам Янг, “Remarks,” *Deseret News*, 1856 оны 10-р сарын 15, 252.
5. *Daughters in My Kingdom*, 36–37-г үз.

Би юу хийж чадах вэ?

1. Эгч нарт маань юу хэрэгтэйг би яаж мэдэх вэ?
2. Намайг эгч нарынхаа төлөө ихэд санаа тавьдгийг тэд яаж мэдэх вэ?

Итгэл, Гэр бүл,
Халамж

Бидний түүхээс

“Айлчлагч багшийн үйл ажиллагаа нь дэлхий даяарх Хожмын Үеийн Гэгээнтэн эмэгтэйчүүдийн хувьд, ‘Бурхан [бидний] зүрх сэтгэлд суулгасан өрөвч нинжин сэтгэлээр’ үйлдэх ёстой хэмээн Иосеф Смитийн сургасны дагуу хайрлан халамжилж, үйлчлэх арга хэрэгсэл болсон юм.”²

Саяхан бэлэвсэрсэн нэг эгч айлчлагч багш нарынхаа талаар: “Тэд намайг анхааралтай сонсож, тайтгаруулдаг байсан. Надтай хамт уйлж, намайг чанга тэвэрдэг байлаа. . . . Ганцаардлын эхний хэдэн сард өгүүлшгүй уй гашуу, сэтгэл санааны зовлонг даван туулахад [тэд] надад тусалсан юм” хэмээн дурсчээ.³

Материаллаг асуудлыг шийдэхэд туслах нь бас үйлчлэлийн нэг хэлбэр мөн. Ерөнхийлөгч Бригам Янг 1856 оны аравдугаар сарын ерөнхий чуулган дээр гар тэрэгтэй анхдагчууд 435–595 км хол хээр талд зузаан хунгар цасанд боогдон явж чадахгүй болсон тухай мэдэгджээ. Тэднийг аврахын тулд тэрбээр Солт Лейк хот дахь Хожмын Үеийн Гэгээнтнүүдэд хандан, “материаллаг зүйлс хэмээн бидний нэрлэдэг юмс дээр бүх анхаарлаа төвлөрүүлхийг” уриалан дуудсан ажээ.⁴

Эмэгтэйчүүд бүр табернекл дотор дулаахан дотуур даашинз, оймсоо тайлж хээр талд осгож үхэх аюул нүүрлээд байгаа анхдагчуудад илгээхээр морин тэргэнд ачсан тухай Люси Мизерв Смит өгүүлжээ. Тэгээд тэд өөрсдөдөө ганц нэгхэнийг үлдээгээд ор, хөнжлийн даавуугаа ч авчирсан гэнэ. Гар тэрэгтэй багийнхныг хүрч ирэхэд хотын нэг байшин “тэдэнд зориулсан эд агуурсаар дүүрсэн” байжээ.⁵

Дөрөвдүгээр сарын чуулганы ТЭМДЭГЛЭЛЭЭС

“Их Эзэн миний бие ярьснаа би ярилаа, . . . харин миний өөрийн дуу хоолой байна уу, эсвэл миний үйлчлэгчдийн дуу хоолой байна уу, энэ нь яг адил, бүгд биелэгдэх болно” (С ба Г 1:38).

Ерөнхий чуулганаас улам ихийг сурч мэдэх нь

Майкл Барбер, Давид Марш нар

Сургалтын хөтөлбөрийн хэлтэс

Бид ерөнхий чуулганы сүүлчийн хуралдаан дээр “амен” гэж хэлдэг ч, сүнслэг байдлын найр үүгээр дуусдаггүй. Энэ нь чуулган дээр заагдсан сургаалуудыг судалж, амьдралд хэрэгжүүлэх явцад цааш үргэлжилдэг. Бошиглогчид чухам үүнийг хийхэд л олон жилийн турш биднийг хөхүүлэн дэмжсээр ирсэн билээ. Жишээ нь, чуулган дээр хэлсэн үгсийг гишүүд дараагийн зургаан сарын турш ажил үйлс, хэл яриандаа удирдамж болгож байхыг” Ерөнхийлөгч Харольд Б.Лий (1899–1973) уриалан дуудсан юм. “Энэ бол өнөө үед энэ хүмүүст иачлэх ёстой чухал зүйлс хэмээн Их Эзэн үзэж байна” гэж тэр тайлбарлажээ.¹

1988 онд Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон (1899–1994) “Дараагийн зургаан сард та *Ensign* сэтгүүлийн чуулганы дугаарыг жишиг бүтээлүүдтэйгээ хамт байлгаж, байнга уншиж байх хэрэгтэй” хэмээн дээрх зөвлөгөөг давтан өгчээ.²

Ерөнхийлөгч Томас С.Монсон 2008 оны Аравдугаар сарын ерөнхий чуулганы төгсгөлд чуулган дээр хэлсэн үгсийг судлахын ач холбогдлыг дахин нотолсон билээ. Тэрбээр хэлсэн нь: “Энэ ерөнхий чуулганы үеэр сонссон зүйлсээ урт удаан хугацаанд санацгаая. Захиасуудыг *Ensign*, *Луахона* сэтгүүлүүдэд нийтлэх болно. Захиасуудыг судалж, тэдгээрт агуулагдсан сургаалуудыг тунгаан бодохыг



би та бүхэнд уриалж байна.”³

Чуулганы захиасуудыг судалж тунгаан бодоод, амьдралдаа хэрэгжүүлэхийн тулд та юу хийж болох вэ? Сүнсээр нөлөөлөгдсөн үгсийг хүлээж аван, амьдралдаа хэрэгжүүлэхэд тань туслахын тулд зарим зөвлөмжийг доор өгөв:

Сүнсний удирдамж хүлээн авахад бэлтгэ.

Та чуулган дээр хэлсэн үгсийг зурагтаар харж, сонсож, уншиж байна уу, ялгаагүй бурханлаг сүнсний нөлөөнд зүрх сэтгэл, оюун ухаанаа нээгтүн. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Давид А.Беднар сургахдаа, үг хэлэгч хэр зэрэг үр өгөөжтэй заасан нь хамаагүй, “гагцхүү хүлээн авагч нь захиасын агуулга хийгээд Ариун Сүнсний гэрчлэлийг зүрх сэтгэлдээ нэвчтэл шингээх хүсэлтэй байх хэрэгтэй” гэжээ. Сүнсний нөлөөг хүлээн авах нь “өөртөө ирсэн бүхнийг зүгээр аваад байх биш, харин сэтгэл санаа, оюун ухаан, бие бялдрын хүч чармайлт шаарддагийг тэрээр тайлбарласан юм.”⁴

Дараах санаанууд Сүнсээр сурахад бэлтгэхэд тань тусалж чадна:

1. Сүнсний өдөөлтүүдийг хүлээн авахын тулд цаг гаргахын сацуу анхаарал сарниулахгүй байх орчныг бүрдүүл.
2. Залбирлаар дамжуулан бурханлаг удирдамж эрэлхийл.
3. Хариуг нь эрж буй асуултууд буюу асуудлуудаа жагсаан бич.

Захиасуудыг ойлго. Амьд бошиглогчид, төлөөлөгчид зааж, сануулан, тайлбарлаж, ухуулан гэрчилдэг. Тэдний хэлсэн үгсийг анхааралтай судлах нь захиасуудыг илүү бүрэн дүүрэн ойлгоход тань тусална. Үр өгөөжтэй судлах зарим арга гэвэл:

- **Асуултууд асуу.** Жишээ нь: Энэ захиасаас юуг сурч мэдэхийг Их Эзэн надаас хүсэх бол? Энэ хэлсэн үг сайн мэдээний аль нэг зарчмын тухай эсвэл судрын аль нэг шүлгийн тухай миний ойлголтыг хэрхэн өргөжүүлэх вэ? Сайн мэдээний зарчмуудыг дүрслэхийн тулд ямар түүхүүдийг ашигласан байна вэ? Эдгээрээс би юу сурч болох вэ?



БИЧЭЭД ТУНГААН БОД

“Бидний сонссон бүх зүйлээс гоц

гойд бөгөөд онцгой анхаарал татсан нэг өгүүлбэр эсвэл нэг догол мөр байж болно. Хэрэв тийм өгүүлбэр, догол мөр байвал, тэмдэглэж аваад, тунгаан бодож, утгыг нь бүрэн ойлгон, амьдралынхаа хэсэг болгох хэрэгтэй гэж би боддог.”

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли (1910–2008), “An Humble and a Contrite Heart,” *Лиакхона*, 2001 оны 1-р сар, 103.

Сурч мэдсэн зүйлээ амьдралд хэрэгжүүл.

Хэрэв та чуулган дээр хэлсэн үгсийг залбирч судалбал, захиасууд нь амьдралд тань хэрхэн хэрэгжиж байгааг харах болно. Сурч мэдсэн зүйлээ амьдралд хэрэгжүүлэхийг Их Эзэн надаас хүсэх үү? Гэр бүл, ажил төрөл, Сүмийн дуудаагад туслах юуг би сурч мэдэв? гэх мэтийн асуултууд чухал өөрчлөлт гаргаж чадахыг та мэдэх болно. Санал бодлоо мартагчгүйн тулд тэмдэглэж ав. Та ингэснээр сургаалын дагуу амьдрахад сүнсээр нөлөөлөгдөж, амлагдсан адислалуудыг авах болно.

Ерөнхий чуулган бол Их Эзэн үйлчлэгчдээрээ дамжуулан хүсэл бодлоо илчиддэг цаг үе юм. Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл (1895–1985), “Мөнх амьдралд хүрэх замыг заадаг үзэл баримтлал болох Сүмийн жишиг бүтээлүүд биш бол, хэчнээн ч уран цэцэн үг хэллэгтэй, яруу сайхан дүрслэлтэй ном зохиол, өгүүлэл таны хувийн номын санд дээгүүр байр эзлэх ёсгүй” хэмээн сургажээ.⁵ ■

ЭШЛЭЛ

1. Харольд Б.Лий, Conference Report, 1946 оны 4-р с ар, 68.
2. Эзра Тафт Бенсон, “Come unto Christ, and Be Perfected in Him,” *Ensign*, 1988 оны 5-р сар, 84.
3. Томас С.Монсон, “Until We Meet Again,” *Лиакхона*, 2008 оны 11-р сар, 106.
4. Давид А.Беднар, “Seek Learning by Faith,” *Лиакхона*, 2007 оны 9-р сар, 17, 20.
5. Спенсер В.Кимбалл, *In the World but Not of It*, Brigham Young University Speeches of the Year (1968 оны 5-р сарын 14), 3.

- **Захиасын тоймыг бич.** Үг хэлэгч юуг тоймлон өгүүлснийг анхаар. Хэлсэн үгийг хэсгүүд болгон хувааж, товч тоймыг бичин, хэсэг бүрийн гол санааг тайлбарла.
- **Хэлсэн үгэнд ямар хэсгүүд байгааг тогтоо.** Сургаал, судар, түүх, сэрэмжлүүлэг, жагсаалт, гэрчлэл, ямар нэг зүйл хийх урилга, зөвлөгөөг дуулавартай дагаснаас ирэх амлагдсан адислалуудыг ажигла.
- **Хэлсэн үгийг нэгээс дээш удаа уншиж судал.** Сайн мэдээний үнэнүүдийн утга учир, ач холбогдлыг бүрэн ойлгохын тулд тэдгээрийг нэгээс дээш удаа уншиж судлах шаардлагатай. Судлах бүрдээ шинээр ойлгож мэдсэн зүйлээ тэмдэглэж бай.



Ерөнхий чуулганы үгсийг conference.lids.org-оос уншиж, үзэж, сонсох боломжтой.





ИХ ЭЗЭНИЙ ХҮЧ ЧАДЛААР

“Бид Их Эзэн Есүс Христэд итгэн, түүний сайн мэдээнд дуулгавартай байж, нэг удаа нэг алхам ахин, хүч чадлыг гуйж, зан төлөв, санаа бодлоо төгөлдөржүүлснээр Сайн Хоньчны хашаанд аз жаргалтай байгаага мэдэрх болно. Энэ нь биднээс сахилга бат, сургалт, ажил хөдөлмөр, хүч чадлыг шаардах болно. Төлөөлөгч Паулын хэлсэнчлэн, ‘Надад хүч өгөгч Түүгээр би бүгдийг хийж чадна.’ (Филиппой 4:13).”

Ерөнхийлөгч Ховард В.Хантер (1907–95), “Developing Spirituality,” *Ensign*, 1979 оны 5-р сар, 26.

ГАЙХАМШИГТАЙ АЧ ИВЭЭЛ

Кристен Николе Кардон

Би Христийн ач ивээлээс өдөр бүр хамааралтай байдаг.

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүд бид Сүмийн цуглаанууд дээрээ ач ивээлийн тухай төдийлөн ярьдаггүй хэрнээ ач ивээлд *итгэдэг*” хэмээн Бригам Янгийн Их Сургуульд надад хичээл заадаг байсан шашны нэг багш хэлж билээ.

Үнэндээ, ач ивээлийн тухай заасан Залуу Эмэгтэйчүүдийн эсвэл Ням гарагийн хичээлийг би санасангүй, харин миний сурч байсан ахлах сургуулийн найрал дуу “Гайхамшигтай ач ивээл” гэдэг дуу дуулдаг байсныг эргэн саналаа.

*Гайхамшигтай ач ивээл! (хэчнээн сайхан сонсогдож байна вэ!)
Над шиг муу хүнийг тэр аварсан юм!
Нэгэн үе би алдагдсан байлаа.
Харин одоо олоод байна.
Нэгэн үе би сохор байлаа. Харин одоо хардаг боллоо.¹*

“Ач ивээл бол Есүс Христийн Цагаатгалаас ирдэг Бурханы хүч юм. Би ач ивээлийг амилуулалт, гэтэлгэл, эдгээлт, хүч чадалтай болгох гэсэн дөрвөн хүч болгон хуваадаг” гэж багш минь тайлбарлаж билээ. Тэгээд дараа нь тэрээр хүч тус бүрийг тайлбарласан

ч, миний бодол өөрийн ой дурсамж уруу дахин эргэв.

Ахлах сургуулийн тэдгээр найрал дуучид нэг удаа хөгжмийн тэмцээнд оролцохоор АНУ-ын Калифорни руу явж билээ. Найрал дуучдыг тийшээ явахын өмнөхөн миний хоолой өвдсөн нь хөгжмийн тэмцээнд найрал дуундаа дуулах боломжгүй болж мэдэхээс гадна явлаа гэхэд өвчний улмаас муу дуулах байв. Би ааваасаа санваарын адислал өгөхийг гуйж, маргааш нь эдгэрэхийн төлөө өдөржингөө залбирав.

Тэгээд би тэмцээнд “Гайхамшигтай ач ивээл” дууг дуулахаар явах асаа ганцхан өдрийн өмнө бүрмөсөн эдгэрч, хоолойныхоо дээд хүч чадлаар дуулснаа яагаад ч ойлгоогүй юм. Тэр өдөр Аврагчийн Цагаатгал намайг адисалж, ач ивээл нь миний эдгэрэлтийн эх сурвалж болсон юм.

“Мөн тэрээр бүх төрлийн өвчин мөн зүдгүүрүүд мөн уруу таталтуудыг тэвчих болно; мөн энэ нь тэр өөрийн хүмүүсийн шаналал мөн өвчнүүдийг өөр дээрээ авах болно гэсэн тэрхүү үг биелэгдэж болохын тулд бөлгөө” (Алма 7:11).

Би ахлах сургуулиа төгсөөд нэгдүгээр курсийн олон оюутны адил



коллежийн хичээлүүдэд дарагдаж, гэрээсээ удаан хугацаагаар хол амьдрахын зовлонд барьц алдан тэвдэж байлаа.

Христийн ач ивээлийн хүч чадал, туслагч хүчийг миний бие ойлгох хүртэл ийм байлаа. Би өдрийг ажиллаж, суралцан өнгөрүүлэхдээ, шаардлагатай ажлуудаа дуусгахын тулд Тэнгэрлэг Эцэгт хандан гуйж өдөр бүр залбирдаг байв. Би Христийн Цагаатгалын хүч чадал өгөгч, туслан дэмжигч хүчээр зөвхөн сайн төдийгүй, бас аливаа хүндрэлгүйгээр ажиллаж чадах юм байна гэдгээ хичээлийн жилийн явцад мэдээд баярлаж билээ.

“Надад хүч өгөгч Түүгээр би бүгдийг хийж чадна” (Филиппой 4:13).

Би хэдийгээр Түүний ач ивээлийн нөгөө хоёр хүч—амилуулалт болон гэтэлгэлийн бүрэн байдлыг хараахан биеэрээ мэдрээгүй ч, Есүс Христийн Цагаатгалаас өдөр бүр хамааралтай хэвээр байлаа. Есүс Христийн Цагаатгалаас ирдэг хүч болох ач ивээл намайг эдгээж, хүч чадал өгсөн юм. Би Бурханы зарлигуудад дуулгавартай байхыг хичээж, Түүний хүслийг дагаснаар чадвараасаа илүү их тэнгэрлэг тусламж хүлээн авдаг билээ.

“Ач ивээлээр л бид аврагдана, бидний хийж чадах бүхний дараа буюу” (2 Нифай 25:23). ■

ЭШЛЭЛ

1. Жон Ньютон, “Amazing Grace,” *Olney Hymns* (1779), no. 41.

ИХ ЭЗЭНИЙ АЧ ИВЭЭЛ БИДНИЙ АМЬДРАЛД ХЭРХЭН НӨЛӨӨЛДӨГ ВЭ?

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Давид А.Беднар энэ дугаарын 12-р хуудсан дахь “Цагаатгал ба бидний амьдрал дахь аян” өгүүлэл дэх энэ асуултанд хариулахад тусалжээ:

- “Их Эзэн Өөрийн Цагаатгал болон Ариун Сүнсний хүчээр дамжуулан зөвхөн биднийг удирдан чиглүүлэхийн тулд төдийгүй бас бидэнд хүч чадал өгөхөөр бидний дотор оршихыг хүсдэг.
- “Хувь хүний сэтгэлийн хат, хүсэл тэмүүлэл, үр өгөөжтэй төлөвлөлт болон зорилго дэвшүүлж, түүндээ хүрэх нь чухал боловч амьдралын аяныг ялгууснаар дуусгахад энэ бүхэн бидэнд үнэхээр чамлалттай юм. Тийм ээ, бид үнэхээр ‘Ариун Мессиагийн сайн үйл, нигүүлсэл, ач ивээлд’ (2 Нифай 2:8) найдах ёстой.”
- “Цагаатгалын туслагч хүч бидэнд ажиллах, сайн үлгэр дууриал үзүүлэх, хүсэл болоод төрөлхийн чадвараасаа илүү дээгүүр үйлчлэх хүч чадлыг бидэнд өгдөг билээ.”

Эдгээх, туслах, хүч чадал өгөх Их Эзэний ач ивээлийг мэдэрсэн тохиолдлуудынхаа тухай тэмдэглэлдээ бичиж, гэрийнхэнтэйгээ хуваалцахыг эрэлхийл.



Арванхоёр
Төлөөлөгчийн Чуулгын
Ахлагч
Давид А.Беднар

Аврагчийн сайн мэдээний үндсэн зорилгыг Ерөнхийлөгч Давид О.МкКей (1873–1970) дараах үгсээр товч тодорхойлон: “Сайн мэдээний зорилго бол . . . муу хүмүүсийг сайн, сайн хүмүүсийг улам сайн болгож, хүмүүний мөн чанарыг өөрчлөх явдал мөн” гэжээ.¹ Тийнхүү, бидний амьдралын аян бол бид муугаас сайн, сайнаас улам сайн болж өсч дэвжин, зүрх сэтгэлийн хүчирхэг өөрчлөлтөд хүрч, унасан, төрөлх зан чанараа өөрчлөх явдал мөн (Мозая 5:2-ыг үз).

Цагаатгал

БА БИДНИЙ
АМЬДРАЛ
ДАХЬ АЯН

*Цагаатгалын
туслагч хүч бидэнд
ажиллах, сайн
үлгэр дууриал
үзүүлэх, хүсэл
болоод төрөлхийн
чадвараасаа илүү
дээгүүр үйлчлэх
хүч чадлыг бидэнд
өгдөг билээ.*

Мормоны Ном бол бид муугаас сайн уруу, сайнаас улам сайн уруу аялан, зүрх сэтгэлээ өөрчлөх зам дахь бидний баримтлах удирдамжийн гарын авлага мөн. Хаан Бенжамин бидний амьдралын аян болон энэхүү аяныг амжилттай дуусгахад Цагаатгал ямар үүрэг гүйцэтгэдэг тухай: “Учир нь эгэл хүн бол Бурханы дайсан, мөн Адамын уналтаас тийм байсаар ирсэн, мөн тэрээр Ариун Сүнсний таталтанд автагдан эгэл хүмүүнээ орхиж, Их Эзэн Христийн цагаатгалаар гэгээнтэн болдог” (Мозая 3:19; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн) хэмээн заасан билээ.

Би энэ хэсэг дэх хоёр нийлэмж үг буюу өгүүдбэрт та бүхний анхаарлыг хандуулъя. Нэг дэх нь, “эгэл хүмүүнээ орхиж” гэсэн нийлэмж үг. Муугаас сайн уруу хийх аян бол бид бүгд эгэл эрэгтэй, эгэл эмэгтэй хүнээ орхих үйл явц мөн. Бид бүгд амьдралдаа махан биеийн хүслээр уруу татагддаг билээ. Бидний биеийн эрхтнүүд унасан байдлаар бүтээгдсэн бөгөөд гэм нүгэл, ялзрал доройтол, үхлийн эрхшээлд ямагт байдаг. Гэвч бид “Христийн цагаатгалаар дамжуулан” махан биеийн хүсэл болоод уруу таталтыг даван туулах чадвараа өсгөн нэмэгдүүлж чадна. Бид алдаа, зөрчил гаргаж, гэм нүгэл үйлдсэн үедээ наманчилж, Есүс Христийн Цагаатгалын гэтэлгэгч хүчээр дамжуулан цэвэр ариун болж чадна.



Хоёр дахь нь, “гэгээнтэн болдог” гэх өгүүлбэр юм. Энэ өгүүлбэр, бидний амьдрал дахь аяны хоёр дахь үе шат буюу “сайн хүмүүсээс улам сайн хүмүүс” болох, өөрөөр хэлбэл, гэгээнтэнтэй илүү адилхан болох үйл явцыг дүрсэлж байна. Амьдралын аяны энэхүү хоёр дахь хэсэг буюу сайнаас улам сайн болох үйл явцыг бид байнга судлаад юм уу заагаад байдаггүй, бас хангалттай сайн ойлгодоггүй.

Сүмийн олон гишүүд хүч чадал өгөгч энэхүү хүчтэй байснаар Цагаатгалын гэтэлгэгч, ариусгагч хүчний мөн чанарыг илүү сайн ойлгодог гэж би боддог. Христ бидний төлөө үхэхээр дэлхийд ирснийг мэдэх нь Христийн тухай сургаалын амин чухал хэсэг мөн. Гэвч Их Эзэн Өөрийн Цагаатгал болон Ариун Сүнсний хүчээр дамжуулан зөвхөн биднийг удирдан чиглүүлэхийн тулд төдийгүй бас бидэнд хүч чадал өгөхөөр бидний дотор *оршихыг* хүсдэгт бид бас талархах хэрэгтэй.

Буруу зүйл хийсэн үед амьдралыг сэвтүүлсэн нүглийн хор уршгийг даван туулахад тусламж хэрэгтэй байдгийг бидний олонх нь мэднэ. Аврагч бидний нүглийн төлөөсийг төлсөн бөгөөд Түүний цагаатгагч хүчээр дамжуулан ариусах боломж бидэнд бий. Цагаатгал нүгэлтнүүдийн төлөө хийгдсэнийг бидний олонх нь сайн ойлгодог. Гэвч Цагаатгал нь бас дуулгавартай, зохистой, ухамсартай бөгөөд улам сайн болж, илүү их итгэлтэйгээр үйлчлэхийг хичээдэг сайн эрэгтэй, эмэгтэй гэгээнтнүүдийн төлөө хийгдсэнийг бид мэддэг бас ойлгодог гэж би бодохгүй байна. Бид сайнаас улам сайн болох аяныг өөрийн оюун ухааны хүч чадал болон зориг, сахилга хийгээд өөрийн илэрхий хязгаарлагдмал чадвараар хийж, гэгээнтэн болж чадна хэмээн буруу ташаа бодож болзошгүй.

Аврагчийн сайн мэдээ бол амьдралдаа муу муухай зүйлсээс зөвхөн зайлсхийх төдийгүй харин сайн үйлсийг бүтээж, улам сайн хүмүүс болоход туйлын чухал юм. Иймээс Цагаатгал муу муухай зүйлийг даван туулж, түүнээс зайлсхийн, сайныг үйлдэж, сайн хүмүүс болоход бидэнд тусалдаг. Бид муугаас сайн, сайнаас улам сайн болж, төрөлх зан чанартаа өөрчлөлт гаргахад Аврагчийн тусламжийг амьдрал дахь аяныхаа туршид авч болно.

Цагаатгалын гэтэлгэгч болон туслагч хүч нь тус тусдаа салангид буюу нэг нь нөгөөгөөсөө өөр зүйл гэж би бодохгүй байна. Харин ч Цагаатгалын энэхүү хоёр тал холбоотой, нэг нь нөгөөгөө сайжруулдаг бөгөөд амьдралын аяны бүх үе шатанд хоёулаа үйлчилдэг билээ. Бидний амьдрал дахь аяны энэхүү амин чухал *хоёр* бүрэлдэхүүн хэсгийг таних нь бид бүгдэд мөнхийн ач холбогдолтой юм. Энэ хоёр элемент эгэл хүнээ орхиж, гэгээнтэн болох, муу муухай зүйлийг ялж, сайн хүмүүс болох үйл явцад Цагаатгалын хүчээр дамжин хэрэгждэг. Хувь хүний сэтгэлийн хат, хүсэл тэмүүлэл, үр өгөөжтэй төлөвлөлт болон зорилго дэвшүүлж, түүндээ хүрэх нь чухал боловч амьдралын аяныг ялгууснаар дуусахад энэ бүхэн бидэнд үнэхээр чамлалттай юм. Тийм ээ, бид үнэхээр “Ариун Мессиагийн сайн үйл, нигүүлсэл, ач ивээлд” (2 Нифай 2:8) найдах ёстой.

Цагаатгалын ач ивээл ба туслагч хүч

Ач ивээл гэдэг үг судруудад ихэвчлэн хүч чадал өгөх гэсэн утгаар хэрэглэгдсэн байдгийг бид Судруудын Удирдамжаас мэднэ.

Ач ивээл гэдэг үг Шинэ Гэрээнд, ялангуяа Паулын цэдгүүдэд байнга тааралддаг. Энэ үг нь *туслах буюу хүч чадал өгөх бурханлаг арга хэрэгсэл* гэсэн үндсэн утгатай бөгөөд энэхүү хүч чадал Есүс Христийн хязгааргүй нигүүлсэл хийгээд хайраар өгөгддөг.

Хүн төрөлхтөн үхэшгүй байдалд амилж, хүн болгон булшнаас биетэй болж босч ирэн, мөнх амьдрах нь Их Эзэн Есүсийн ач ивээл, түүний цагаатгагч золиослолоор боломжтой болсон юм. *Үүн лүгээ адил хувь хүмүүс Есүс Христийн цагаатгалд болон нүглээ наманчлахад итгэх итгэлээр* дамжуулан сайн үйлс бүтээх хүч чадал, дэмжлэг тусламжийг хүлээн авдаг. *Эс бөгөөс тэд зөвхөн өөрийн хүч чармайлтаар энэхүү хүч чадал, дэмжлэг тусламцааг авах боломжгүй юм. Энэхүү ач ивээл бол хүч чадал өгөгч хүч бөгөөд эрэгтэй, эмэгтэйчүүд чадах бүхнээ хийсний эцэст мөнх амьтай болж, өргөмжлөлд хүрэх боломжийг тэдэнд олгодог билээ.*²

Ач ивээл бол селестиел хаант улсад тохирох бидний амин чухал хэрэгцээнд туслах бурханлаг арга хэрэгсэл мөн. Тийнхүү,

Цагаатгалын туслагч хүч бидэнд амжилттай ажиллах, сайн үлгэр дууриал үзүүлэх, хүсэл болоод төрөлхийн чадвараасаа илүү дээгүүр үйлчлэх хүч чадлыг бидэнд өгдөг билээ.

Би хувиараа судар судлах үед ач ивээл гэдэг үгтэй тааралдах бүрдээ “хүч чадал өгөгч хүч” гэдэг нэр томъёог санадаг.



Нифай нөхцөл байдлаа өөрчилж өгөөч гэж залбираагүй. Харин тэр нөхцөл байдлаа өөрчлөх хүч чадлын төлөө залбирсан юм.

Жишээ нь, “Бид ач ивээлээр л аврагдана гэдгийг мэднэ, бидний хийж чадах бүхний дараа буюу” (2 Нифай 25:23) гэсэн шүлгийг бид бүгдээрээ сайн мэддэг шүү дээ. Бид судруудад *ач ивээл* гэдэг үгтэй тааралдах бүрдээ энэ үг “хүч чадал өгөгч хүч” гэсэн утгатайг санах юм бол Цагаатгалын энэхүү амин чухал талын тухай илүү ихийг мэдэж чадна гэдэгт би итгэдэг.

Зураг ба далд утга

Амьдрал дахь аян бол бид муугаас сайн, сайнаас улам сайн болж, төрөлх зан чанараа өөрчлөх үйл явц мөн. Амьдралын аяндаа Цагаатгалын хүч өгөгч хүчийг

мэдэж, ойлгон, түүгээр өөрчлөгдсөн шавь нар болон бошиглогчдын жишээ Мормоны Номоор дүүрэн байдаг. Энэхүү ариун хүчийг алгуураар улам тодорхой ойлгосноор бидний сайн мэдээний мэдлэг үлэмж өргөжин, баялаг агуулгатай болно. Ийм мэдлэг биднийг гайхалтай арга замаар өөрчлөх болно.

Аврагчийн хүч чадал өгөгч хүчийг мэдэж, ойлгон, түүнд найдвар тавьж байсан хүний жишээ бол Нифай юм. Лихайн хөвгүүд Ишмил болон түүний гэр бүлийг өөрсдийн үйл хэрэгт татан оролцуулахын тулд Иерусалимд эргэн ирснийг санагтун. Иерусалимаас аглаг буйд уруу Нифайтай хамт явсан хүмүүсийн дотроос Лемен болон бусад хүмүүс үглэн дургүйцэхэд Нифай ах нартаа Их Эзэнд итгэх итгэлтэй байхыг анхааруулсан билээ. Гэвч Нифайн ах нар аяны үед дүүгээ олсоор хүлж, амийг нь хөнөөхөөр завдаж байв. Нифай: “Ай Их Эзэн танд итгэх миний итгэлийн улмаас та намайг ах нарын минь гараас зайлуулаач, тийм ээ, намайг хүлсэн энэ хүлээсийг тасар татах хүчийг өгөөч надад” (1 Нифай 7:17; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн)

хэмээн залбирсныг санагтун.

Хэрэв миний ах нар намайг хүлсэн бол би юу гэж залбирах байсныг та нар төсөөлж байна уу? “Намайг энэхүү таагүй байдлаас ОДООХОН чөлөөлж өгөөч!” гэх байсан. Нифай нөхцөл байдлаа өөрчилж өгөөч гэж залбираагүй нь миний сонирхлыг бүр ч их татдаг. Тэр үүний оронд нөхцөл байдлаа өөрчлөх хүч чадлын төлөө залбирчээ. Мөн тэрээр Цагаатгалын хүч чадал өгөгч хүчийг тодорхой мэддэг, ойлгодог, үүнийг биеэр үзсэн хүн шиг залбирсан гэдэгт би итгэдэг.

Нифайн хүлээс ид шидээр лүгээ адил бугуйнаас нь судран тасарсан гэж би

боддоггүй. Харин тэр эхлээд төрөлхийн чадвараасаа илүү их хүч чадал, тэвчээрээр, дараа нь “Их Эзэний хүчээр” (Мозая 9:17) адислагдсанаар хүлээсийг хамаг хүчээрээ чангааж угзрахад олс тасарч суларсан гэж би боддог.

Энэ үйл явдлын далд санаа нь бид бүгдэд ил тод юм. Та бид Цагаатгалын хүч чадал өгөгч хүчийг ойлгож, амьдралдаа ашиглахын тулд бидний нөхцөл байдал өөрчлөгдөхийн төлөө биш, харин нөхцөл байдлаа өөрчлөх хүч чадлыг гуйж залбирах ёстой. Ингэвэл бид өөрсөд дээрээ үйлдүүлэгчид бус харин өөрсдийнхөө төлөө үйлдэгчид болно (2 Нифай 2:14-ийг үз).

Алма болон түүний хүмүүсийг Амюлон хэрхэн хавчсан тухай Мормоны Номон дахь жишээг сана. Их Эзэний дуу хоолой тэдэн дээр зовлон зүдгүүрийн үед нь ирж:

“Та нарын мөрөн дээр тавигдах ачаануудыг, бүр тэдгээрийг нуруун дээрээ байгааг ч мэдрэхгүй болтол . . . би түүнчлэн хөнгөвчилнө.

Мөнхүү эдүгээ улиран тохиох дор Алма болон түүний ах дүүсийн дээр тавигдаж асан ачаанууд хөнгөлөгдсөн байлаа; тийм ээ, тэд ачаагаа амархан даахын тулд *Их Эзэн тэднийг хүчирхэгжүүлсэн* билээ, мөн тэд баяртайгаар, мөн тэвчээртэйгээр Их Эзэний бүх тааллуудад захирагдсаныг” (Мозая 24:14–15; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн) харуулсан билээ.

Энэ түүхэнд юу өөрчлөгдсөн байна вэ? Ачаа өөрчлөгдсөнгүй. Хавчлагын сорилт, хүнд бэрхшээлээс хүмүүс тэр дороо чөлөөлөгдсөнгүй. Гэвч Алма болон түүнийг дагалдагчдад хүч өгөгдсөнөөр чадвар, хүч чадал нь нэмэгдэж, ачаа дарамт нь хөнгөрчээ. Энэ сайн хүмүүс Цагаатгалаар дамжуулан өөрсдийнхөө төлөө *үйлдэх* хийгээд нөхцөл байдалдаа *нөлөөлөх*

хүчийг олсон юм. Алма болон түүний хүмүүс “Их Эзэний хүчээр” Зарахемлагийн нутаг дахь аюулгүй газар уруу удирдагдсан билээ.

Алма болон түүний хүмүүсийн энэ түүх юугаараа Цагаатгалын хүч чадал өгөгч хүчний жишээ болдог юм бэ? хэмээн та бодох нь зүй ёсны хэрэг. Энэ асуултын хариу



Мозая 3:19-ийг Мозая 24:15 -тай харьцуулахад харагдана.

“Эгэл хүмүүнээ орхиж мөн Их Эзэн Христийн цагаатгалаар гэгээнтэн болж, хүүхэд *шиг хүлцэнгүй, номхон, даруухан, тэвчээртэй, хайраар дүүрэн, бүр хүүхэд эцэгтээ захирагддаг шиг Их Эзэн* түүн дээр ноогдуулах бүх зүйлийг хүлцэхэд бэлэн байдаг” (Мозая 3:19; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн).

Бид амьдрал дахь аяныхаа явцад муугаас сайнд, сайнаас улам сайнд өсөн дэвших үед эрэгтэй, эмэгтэй хүн бүр эгэл хүмүүнээ орхин, гэгээнтэн болж, зан төлвөө өөрчлөхийг хичээдэг. Иймээс энэ

Их Эзэний дуу хоолой тэдэн дээр зовлон зүдгүүрийнх нь үед ирж: “Та нарын мөрөн дээр тавигдах ачаануудыг, бүр тэдгээрийг нуруун дээрээ байгааг ч мэдрэхгүй болтол . . . би түүнчлэн хөнгөвчилнө” гэдгийг харуулсан юм.

шүлгэнд тоочсон зан төлвийн шинжүүд нь та биднийг ямархуу хэв маягийн хүмүүс болох ёстойг дүрсэлж байна. Бид бүр хүүхэд шиг, илүү хүлцэнгүй номхон, илүү тэвчээртэй, захирагдах илүү их хүсэлтэй болох ёстой.

Мозая 3:19 дэх зан төлвийн шинжүүдийг Алма болон түүний хүмүүсийг дүрсэлсэн зан төлвийн дараах шинжүүдтэй харьцуул: “Мөн тэд баяртайгаар мөн *тэвчээртэйгээр Их Эзэний* бүх таалуудад *захирагдсан* болой” (Мозая 24:15; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн).

Эдгээр шүлгүүдэд дүрслэгдсэн зан төлвийн шинжүүд хоорондоо адил төстэй бөгөөд Алмагийн сайн хүмүүс Их Эзэн Христийн Цагаатгалын хүч чадал өгөгч хүчээр улам сайн хүмүүс болсныг тодорхой харуулж байна.

Алма 14 дэх Алма, Амюлек нарын түүхийг сана. Энэ хэрэг явдлаар итгэлтэй олон гэгээнтнүүдийг галд хаяж, амийг нь хөнөөгөөд Их Эзэний итгэлтэй хоёр үйлчлэгчийг зодож, шоронд хорьсон билээ. Алма шоронд хоригдож байхдаа залбирч, ийн гуйсан ажээ: “Ай Их Эзэн, Ай Их Эзэн, Христэд итгэх бидний итгэлийн дагуу бүр чөлөөлөгдөх хүртэл бидэнд *хүчийг өгөөч*” (Алма 14:26; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн).

Энд бид Алмагийн гуйлтанд илэрсэн Цагаатгалын хүч чадал өгөгч хүчийг тэрээр ойгодог бөгөөд үүнд итгэлтэй байсныг дахин харж байна. Энэ залбирлын үр дүнг ажиглана уу:

“Мөн тэд [Алма, Амюлек хоёр] хүлэгдсэн олсоо тасчив, мөн хүмүүс үүнийг хараад устгалаас айх айдас тэдэн дээр ирсэн учир зугтаж эхлэв. . . .

“Мөн Алма, Амюлек хоёр шоронгоос гарч ирэв, мөн тэд гэмтээгүй байв. Учир нь Христэд итгэх итгэлийнх нь дагуу *Их Эзэн тэдэнд хүчийг соёрхсон ажээ*” (Алма 14:26, 28; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн).

Энд сайн хүмүүс нүгэл хилэнцийн эсрэг тэмцсэнээр улам сайн болж, “Их Эзэний хүчээр” илүү үр өгөөжтэй үйлчлэхийг хичээх болсон нь харагдаж байна.

Мормоны Номын өөр нэг сургамжтай жишээг авч үзье. Раумеуптом буюу ариун тавцан гэгчээ барьсны дараа бардамналаар дүүрэн залбирал хэлсэн урвагч зорамчуудыг Сүмд

буцаан авчрах номлолд Алмаг явуулсан тухай Алма 31-д өгүүлдэг.

Алма хувийн залбиралдаа: “Ай Их Эзэн, та энэ хүмүүсийн алдсын учир дээр минь ирэх эдгээр зовлонг тэвчээртэйгээр тэвчиж, болохын тул *надад хүч байж болохыг* соёрхоно уу” (Алма 31:31; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн) хэмээн хүч чадал гуйсныг ажиглаарай.

Алма бас номлолын хамтрагчид нь мөн дээрх адислалыг хүлээн авахын төлөө: “Энэ хүмүүсийн алдсын учир тэдний дээр ирэх зовлонгуудыг тэвчиж болохын тулд *тэд хүчтэй байж болохыг* та тэдэнд соёрхоно уу” (Алма 31:33; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн) хэмээн залбирчээ.

Алма зовлон зүдгүүр нь алга болохын төлөө залбираагүй байна. Тэр өөрийгөө Их Эзэний төлөөлөгч хүн гэдгээ мэдэж байсан бөгөөд өөрийн нөхцөл байдалд нөлөөлөх хүч чадлын төлөө залбирчээ.

Энэ жишээний хамгийн чухал санаа нь: “[Их Эзэн] тэдэнд Христийн баясалд автагдаж байснаас *бусдаар өөр зовлонгуудыг үзүүлэхгүйн тулд тэдэнд хүч чадал өгч байв гэсэн санаа Алма 31-ийн сүүлчийн шүлэгт агуулагддаг*. Эдүгээ энэ нь Алмагийн залбирлын дагуу байв; мөн энэ нь тэрээр итгэлтэйгээр залбирсны учир болой (шүлэг 38; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн).

Зовлон зүдгүүр нь арилаагүй ч, Алма болон түүний хамтрагчид “Христийн баясалд автагдаж байснаас бусдаар өөр зовлонгуудыг үзүүлэхгүйн тулд” Цагаатгалын туслагч хүчийг авч, адислагдсан юм. Ямар гайхалтай адислал билээ. Бид бүгдийн мэдэх ёстой ямар агуу сургамж вэ.

Хүч чадал өгөгч хүчний жишээнүүд зөвхөн судруудад байдаггүй. Даниел В.Жөүнс 1830 онд Миссурид төрж, 1851 онд Калифорнид Сүмд нэгджээ. 1856 онд тэрээр Вайомингд хунгар цасанд боогдсон гар тэрэгтэй багийнхныг аврахад оролцсон ажээ. Аврах бүлэг зовж туйлдсан Гэгээнтнүүдийг олсны дараа тэднийг чадах чинээгээрээ тайтгаруулж, өвчтэй болон сульдаж тамирдсан хүмүүсийг Солт Лейк хот уруу авч явахад Даниел тэдний эд хөрөнгийг харж хамгаалахаар үлдсэн байна. Даниел болон түүнтэй хамт сайн дураараа үлдсэн хүмүүсийн хомсхон хоол хүнс, амь зуух бусад зүйлс

тэр дорхноо дууссан гэнэ. Даниел Жөүнсийн хувийн тэмдэглэлд дараах болсон явдлын тухай өгүүлсэн байдаг.

“Ан амьтан тэр даруй үзэгдэхээ больсон учир бид чухамдаа оготнын хамраас ч цус гаргаж чадсангүй. Ганц хүн идээд ч цадахааргүй хумсын чинээ махаа дуусгав. Эцэстээ арьс ширнээс өөр юу ч үгүй болов. Тэгээд арьс ширээ идэхээс өөр аргагүй боллоо. Нэлээд их шир чанаад, цэрвэж сэжиглэсэнгүй идчихсэн чинь бүгдээрээ өвчлөх нь тэр.

“Байдал яах ч аргагүй болж, турж үхсэн үхрийн түүхий ширнээс өөр хэлэн дээр тавих юм юу ч үлдсэнгүй. Яах ёстой талаар бидэнд удирдамж өгөөч гэж Их Эзэнээс гуйв. Ах нар гомдоллож үглэсэнгүй, харин Бурханд итгэх итгэлээ мэдэрч байлаа. . . . Эцэст нь түүхий үхрийн ширээ хуйхалж цэвэрлээд халуун усанд юм уу ууранд чанавал гэдэс өвтгөдөг муухай амт нь гайгүй болох байх гэж санаад энэ тухайга бусдадаа хэллээ. Үхрийн ширээ хуйхалж цэвэрлэсний дараа их усанд бүтэн цаг чанаад өтгөрсөн усыг асган, зөөлхөн болсон шириийг маш сайн хусч цэвэрлэв. Тэгээд хүйтэн усанд угааж, цэлцгий болтол нь чанаад хөргөж, жаахан элсэн чихэр цацаад идэж үзлээ. Бас л муухай байлаа. Гэвч өөр юу ч байгаагүй болохоор өлсөж үхсэнээс арай дээр юм даа.

“Бидний ходоодыг адисалж, энэ хоолыг шингээж чаддаг болгон *өөрчилж өгөөч гэж Их Эзэнээс гуйлаа*. . . . Тэгээд идтэл нөгөөх хоол чинь бид бүгдэд баярын зоог шиг сайхан санагдаж билээ. Энэ хоолоо дахин идэх хүртэл гурав хоног хэлэн дээрээ юу ч тавьсангүй. Бид сайхан амттай энэ хоолоо зургаан долоо хоног орчим амтархан идсэн юм даа.”³

Хэрэв би тийм хүнд нөхцөлд орсон бол: “Тэнгэрлэг Эцэг минь, бидэнд бөднө шувуу юм уу зэрлэг үхэр илгээгээч” хэмээн үхрийн түүхий ширнээс арай өөр юм гуйн залбирах байсан биз ээ. Бидэнд байгаа хоолыг шингээж чадахаар ходоодыг минь хүчтэй болгож өгөөч хэмээн би залбирахгүй л байсан болов уу. Даниел В.Жөүнс юу мэдсэн бэ? Тэр Есүс Христийн Цагаатгалын туслагч хүчийг мэдсэн байлаа. Тэрбээр амьдралын нөхцөл байдал нь өөрчлөгдөхийн төлөө залбирсангүй харин амьдралын хүнд нөхцөл байдлаа шийдвэрлэх

хүч чадал өөрт нь өгөгдөхийн төлөө залбирчээ. Даниел В.Жөүнс Алма болон түүний хүмүүс, Амюлек болон Нифай нар хүч чадлыг олсон нь залбиралдаа юу гуйхыг мэддэг сүнсний мэлмийтэй байсных юм.

Христийн Цагаатгалын хүч чадал өгөгч хүч нь бид өөрсдөө хэзээ ч хийж чадахгүй зүйлсийг хийхэд бидэнд хүч чадал өгдөг билээ. Бичил долгионы зуух, гар утас, агааржуулагчтай машин, тохилог байр сууц бидний амьдралд нэвтэрсэн өнөө үед бид Цагаатгалын туслагч хүчнээс өдөр тутам хамааралтай байдгаа огт мэддэггүй юм шиг заримдаа надад санагддаг.

Беднар эгч бол гайхамшигтай итгэлтэй, ухаалаг, мэддэг сайтай эмэгтэй. Иймээс би түүний даруухан үлгэр жишээнээс хүч чадал өгөгч хүчний тухай чухал сургамж авсан юм. Тэр гурван удаа жирэмслэх үеэрээ найман сарын турш өдөр бүр их хүчтэй, удаан огиулдаг байлаа. Тэгэхэд нь би эхнэрийнхээ шантаршгүй тэвчээр хатуужлыг харсан. Бид хоёр түүнийг адислахын төлөө хамтдаа залбирдаг байсан ч, нөгөөх бэрхшээл огт арилаагүй, харин өөрийнхөө хүчээр хийж чадахгүй зүйлд нь түүнд бие бялдрын хүч чадал өгөгдсөн юм. Тэр Хожмын Үеийн Гэгээнтэн эмэгтэйн хувьд олон жилийн туршид бошиглогчийн зөвлөгөөнд анхаарлаа хандуулж, гэр бүл, үр хүүхдийнхээ хүмүүжлийг эн тэргүүнд анхаарах зүйлээ болгосны төлөө дэлхийн хүмүүс түүнийг шоолж, жигшин зөвүүцдэг байсныг хүлцэн тэвчих хүч чадал олсныг би бас харсан. Ийм их үнэ цэнэтэй зүйлийг мэдэж авахад тусалсан Сюзандаа би талархан, түүнийг хүндэлдэг.

Аврагч мэддэг бас ойлгодог

Аврагч яагаад бас хэрхэн хүч чадал өгөгч хүчээр хангадаг болохыг бид Алмагийн 7-р бүлгээс мэддэг билээ.

“Мөн тэрээр бүх төрлийн *өвчин* мөн *зүдгүүрүүд* мөн *уруу таталтуудыг* тэвчих болно; мөн энэ нь тэр өөрийн хүмүүсийн *шаналал* мөн *өвчнүүдийг* өөр дээрээ авах болно гэсэн тэрхүү үг биелэгдэж болохын тулд бөлгөө.

“Мөн тэрээр үхлийг өөр дээрээ авах

болно, тэр өөрийнх нь хүмүүсийг хүлсэн тэрхүү үхлийн хүлээсийг тайлж болохын тулд бөлгөө; мөн түүний зүрх сэтгэл бие махбодын дагуу нигүүлслээр дүүргэгдэж болохын тулд, тэрээр бие махбодын дагуу өөрийн хүмүүсийг тэдний сул байдлуудынх нь дагуу хэрхэн халамжлахыг мэдэж болохын тулд, тэрээр өөр

дарамтыг биеэрээ мэдэрч, үүрсэн учраас хэнээс ч илүүтэйгээр биднийг төгс мэддэг бөгөөд ойлгодог. Тэрбээр энэхүү ачаа дарамтын төлөөсийг бүрэн төлж, өөрөө үүрсэн болохоор биднийг төгс ойлгож, бидний амьдралын олон үе шатанд нигүүлслийн мутраа сунгадаг билээ. Тэрбээр чухамдаа бидний дэргэд гүйж ирэн, биднийг сэтгэл санаагаар дэмжин, хүч чадал өгч, бид өөрсдөө хэзээ ч гарч чадахгүй өндөрт биднийг өргөн гаргаж, өөрийнхөө хүчинд тулгуурлан бидний хэзээ ч хийж чадахгүй зүйлийг хийхэд бидэнд тусалдаг.

“Эцэж туйлдсан, хүнд дарамт үүрсэн хүмүүс ээ, бүгд Над уруу ир. Би та нарт амралтыг өгье.

“Буулгыг минь өөр дээрээ авч, Надаас суралц. Учир нь би зүрх сэтгэлдээ дөлгөөн, даруу билээ. Тэгээд та нар сэтгэлдээ амралтыг олох болно.

“Миний буулга амархан, Миний ачаа хөнгөн” (Матай 11:28-30).

Би Их Эзэн Есүс Христийн мөнхийн, хязгааргүй золиослолыг гэрчлэн, талархлаа өргөж байна. Аврагч амьдыг би мэднэ. Түүний гэтэлгэгч хүчийг бас Түүний хүч чадал өгөгч хүчийг би биеэрээ үзсэн

хүн. Тиймээс би эдгээр хүч үнэн бодитой бөгөөд бид бүгдэд боломжтойг гэрчилж байна. Бид амьдралын аяндаа урагш давшигдаа “Их Эзэний хүчээр” бүх зүйлийг хийж чадна, бүх сорилт бэрхшээлийг даван туулж чадна. ■

2001 оны 10-р сарын 23-нд Бригам Янгийн Их Сургууль дээр болсон онцгой цугларалт дээр хэлсэн үгнээс Англи хэлээрх бүрэн эхийг <http://speeches.byu.edu>-оос үз.

ЭШЛЭЛ

1. Франклин Д. Ричардс, Conference Report, 1965 оны 10-р сар, 136–37; мөн Давид О.МкКей, Conference Report, 1954 оны 4-р сар, х.26-г үз.
2. Судруудын Удирдамж, “Ач ивээл”; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн.
3. Даниел В. Жөүнс, *Forty Years among the Indians*, 57–58.



Бидний мөнх бус амьдралдаа амсаж болох бүх бие махбодын өвчин, сэтгэл санааны шаналал, сүнсний зовлон, сул дорой байдлыг Аврагч амссан.

дээрээ тэдний сул дорой чанаруудыг авах болно (Алма 7:11-12; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн).

Аврагч зөвхөн бидний гэм нүглийн төлөө төдийгүй бас бидэнд байнга тохиолддог алдаа дутагдал, шударга бус явдал, өвчин зовлон, сэтгэл санааны дарамтын төлөө зовж шаналсан юм. Бидний мөнх бус амьдралдаа амсаж болох бүх бие махбодын өвчин, сэтгэл санааны шаналал, сүнсний зовлон, сул дорой байдлыг Аврагч амссан.

“Хэн ч намайг ойлгохгүй юм. Хэн ч миний зовлонг мэдэхгүй” хэмээн бид цөхөрч дуу алддаг. Бурханы хүү бидний ачаа

Дэлхий даяар семинар өөртэй чинь
адил залуусыг Есүс Христэд
улам ойртуулж байна.



MÉXICO

СЕМИНАРЫН адислалууд

Британи Бетти

Сүмийн сэтгүүлүүд

Семинарт явах тухай шийдвэр гаргахад чи ганцаараа биш шүү. Дэлхий даяар хэдэн зуун мянган залуус семинарыг амьдралынхаа хэсэг болгон, автобус, далбаат завь, дугуйгаар, бүр интернэтээр хүртэл хичээлдээ явж байна. Зарим залуус семинартаа очихын тулд эрт босч, хол зам туулдаг бол зарим нь орой бүр явна, бас зарим нь долоо хоногт хэдэн цаг гэрээр хичээлээ үздэг.

Семинарт явах нь золиослол шаарддаг ч, ашиг тусаа өгдгийг дэлхий даяарх залуус нотолж байна. Семинарт явдаг хүмүүст адил нийтлэг нэг зүйл байдаг нь юу вэ гэвэл семинарын туршлага тэднийг Аврагч болон Тэнгэрлэг Эцэгт улам ойртуулдаг явдал юм.

Амлагдсан адислалууыг авах нь

Яагаад семинар та нарт маш чухал вэ? Нэг шалтгаан нь гэвэл хожмын үеийн бошиглогчид, төлөөлөгчдийн дараах амлалтууд юм:

- Семинар нь дэлхийн түүхэн дэх хамгийн хүнд хэцүү үед орчин үеийн Израилыг аврахын төлөө Бурханаас илгээсэн адислал мөн.”¹
- Сэргээгдсэн сайн мэдээний захиасыг таньдаг хүмүүстээ танилцуулахад семинар та нарыг бэлтгэх болно.”²

- Семинар “үнэний тухай нэн чухал ойлголттой” болоход тань тусална.”³
- Та нарыг аз жаргалтай болгох сургаалуудыг ойлгож мэдэх гайхамшигтай боломжийг семинар олгоно. Семинар өөртэй чинь адил итгэл бишрэлтэй хүмүүстэй танилцах сайхан боломжийг олгоно.”⁴
- “Сайн мэдээний мэдлэг тань өсөн нэмэгдэнэ. Итгэл чинь улам бат бөх болно. Гайхамшигтай сайхан найз нөхөд, танилуудтай болно.”⁵
- “Семинар . . . бид бүгдэд тохиолддог нүгэл хилэнцийг эсэргүүцэх болон сайн мэдээний мэдлэгээ үлэмж өсгөн нэмэгдүүлэх сүнслэг байдал, ёс суртахууны хүч чадлыг төлөвшүүлдэг.”⁶
- Энэ бол “номлолд үйлчлэх хамгийн сайн бэлтгэлийн нэг мөн.”⁷

Семинарт явах арга замаа олох нь

Та семинарт явах цагтай байхын тулд сонирхдог өөр ямар нэг зүйлээ орхих хэрэгтэй болж мэднэ. Харин ийм золиослол хийхэд алдах юм байхгүй. Филиппиний Элайжа Бугаёнг ахлах сургууль төгсөх жилээ ийм шийдвэр гаргахаар сонгосон ажээ. Тэр ахлах сургуульд сурсан бүх үеийнхээ турш сурлагаараа сургуулийнхаа хоёр дахь сурагч байсан гэнэ. Тэр сүүлчийн жилдээ сурлагаараа тэргүүн сурагч болох

ГЭРЭЛЗУРГУУДЫГ СҮМИЙН БОЛОВСРОЛЫН СИСТЕМИЙН ЗӨВШӨӨРЛӨӨР НИЙТЛЭВ; ЧИМЭГЛЭЛИЙГ СКОТТ ГРИЙР



НАСАН ТУРШИЙН ҮР ДАГАВАРТАЙ АДИСЛАЛ

Олон жилийн тэртээ өглөө өглөө эртийн заах онцгой боломж надад тохиосон юм. Семинарын анги сургуулийн хичээлтэй өдөр бүр 6:30-аас 7:30-ын хооронд хичээллэнэ. Багш нь тэднийг өглөө эрт босгох гэж шахаж шаарддагаас нойрмог суралцагчид хөл нь солбин ангид орж ирэхийг би хоёр жилийн турш харсан. Залбирал хэлж, сүнслэг бодол хуваалцсаны дараа тэдний оюун ухаан сэргэж, сайн мэдээний мэдлэгээ өсгөхөд бэлэн болдог байв. Хичээлийн хамгийн хүнд хэсэг нь ярилцлагыг цагт нь дуусгаж, суралцагчдыг ахлах сургуулийн хичээлд нь явуулах байлаа. Хичээлийн жил ахих тусам суралцагч бүр илүү итгэлтэй болж, хоорондоо сайн найз нөхөд болон сайн мэдээний гэрчлэл нь өсөн нэмэгддэг байв.

“Хэдэн жилийн өмнө эндээс холгүй хотын нэгэн хүнсний дэлгүүрт зогсож байтал нэг хүн намайг нэрээр минь дуудахыг сонсов. Эргээд хартал семинарын суралцагчдаас хоёр нь зогсож байв. Тэр хоёр гэрлэж, эхнэр нөхөр болсон ажээ. Тэднийд намайг очиход дөрвөн сайхан хүүхдээ надад танилцуулав. Тэд өнгөрсөн өдий олон жилийн туршид семинарын ангийнхнаасаа нэлээд олонтой нь холбоотой байсныг мэдээд би гайхаж билээ. Энэ бол өглөө эртийн семинарын ангид бий болсон үерхэл нөхөрлөлийн нотолгоо юм.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын
Ахлагч Л. Том Перри, “Receive Truth,”
Ensign, 1997 оны 11-р сар, 62.

зорилго тавьж, үүндээ хүрэхийн тулд гурван жил явсан семинартаа явахгүй байхаар шийдээд байтал нэг өдөр бодол нь өөрчлөгдсөн ажээ. “Хичээл хийдэг ширээ уруугаа хартал судрууд, семинарын тэмдэглэл, гарын авлага гээд бөөн ном ширээний ойролцоо хөглөрч байлаа. ‘Аль нь хамгийн чухал бол?’ хэмээн сэтгэл санааныхаа гүнд өөрөөсөө асуув.

Элайжа хариугаа Матай 3:33-аас олжээ: “Харин эхлээд Түүний хаанчлал болон Түүний зөвт байдлыг хайгтун. Тэгвэл энэ бүхнийг та нарт нэмж өгөх болно.” Тэрээр семинарт дуулгавартай явахаар шийдэж, хичээл сурлагандаа зориулах цагаа зохицуулах арга замыг олсон ажээ. Элайжа жилийн эцэс гэхэд сургуулийнхаа шилдэг сурагчаар шалгарч, их сургуулийн тэтгэлэг хүлээн авчээ.

АНУ-ын Алабамын Спенсер Доуглас семинарт суралцахын тулд олон нийтийн зарим үйл ажиллагаанд оролцохоо больсон гэнэ. Тэр семинарт явахын тулд эхний хоёр жил өглөөний 4:00-д, сүүлийн хоёр жил 5:00-д босдог байсан гэнэ. “Би орой эрт унтах хэрэгтэй учраас үдшийн цагаар болдог олон үйл ажиллагаанд найз нартайгаа оролцож чадахаа больсон. Хэрэв тэгэхгүй бол, маргааш өглөө нь семинарт явж, хичээлдээ идэвхтэй оролцож чадахгүй шүү дээ” гэж тэр ярилаа. Спенсер зөвхөн семинарт явдаг төдийгүй, цагтаа сэрж, хичээлдээ бэлтгэдэг байжээ.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Даллин Х.Өүкс сургасан нь: “Ямар нэгэн зүйл сайн байна гэдэг нь үүнийг хийх хангалттай

шалтгаан биш. Бидний хийж болох сайн зүйлсийн тоо тэдгээрийг хийх цагийн боломжоос хавьгүй их байдаг. Иймээс бид зарим онцгой сайн зүйлд тэргүүн зэргийн анхаарал тавих шаардлагатай болдог.⁸ Энэ бол семинарыг амьдралдаа эн тэргүүнд тавих шийдвэр гаргахад тань чухал зөвлөгөө юм.

Номлолд бэлтгэх нь

Хэрэв чи ирээдүйд бүрэн цагийн номлогчоор үйлчлэх хүсэлтэй бол, семинар нь өнөөдөр гишүүн номлогч байгаа үедээ номлолын ажилд бэлтгэх маш сайн бэлтгэл болж чадна. Перугийн Франко Хюман Куринику, семинарт судар судлах нь номлолд бэлтгэхэд тусалдгийг мэддэг ажээ.

Семинарт явахын тулд өглөө 4:00-д босч, үерийн саруудад далбаат завиар явж, дараа нь ангидаа хүрч очихын тулд лаг шавар дундуур туулдаг байсан нь чухамдаа номлолын бэлтгэл байлаа. Би номлолд бэлтгэхийн тулд семинараа төгсөөд институтэд явж, Сүмд өсөх болно” гэж тэр яриу. Судруудын тухай мэдэж, чухал шүлгүүдийг цээжилдэг нь сайн номлогч болоход нь тусалдаг учраас семинар түүнд маш чухал ажээ.

Амьдралынхаа бүх талд адислалыг хүлээн авах нь

Дэлхий даяарх залуучууд семинарт идэвхтэй явснаар судар судалснаас олдгоос бүр илүү бат бөх итгэлтэй болж байна. Английн Камерон Лисни амьдралынхаа бүх талд адислагдсан гэж үздэг ажээ. “Семинар зөвхөн сүнслэг байдалд төдийгүй бас хичээл сурлагад тусалдаг.

Өглөө эрт боссоноор тэр өдөр тархи сэргэг байдаг. Зарим найз нар маань семинарт явах цаг алга гэдэг. Гэтэл энэ чинь өглөө 6:00-д босч математикийн хичээлээ давтахтай л адил шүү дээ, тийм үү?” хэмээн тэр асуулаа. Шамдан суралцвал, “Их Эзэн шалгалтанд чинь тусална, семинарт явбал Тэр чамд бүр илүү тусална” гэж Камерон хэлэв.

Семинар мэдээж хэрэг, гэрчлэлээ бэхжүүлэхэд нь Камеронд тусалжээ. “Миний гэрчлэл семинарын хөтөлбөрөөс эхлэлтэй. Би 14-тэйдөө сайн мэдээний мэдлэгтэй болох гэж зовж байлаа. Би Сүмд явах дургүй бүр хийх ёсгүй зүйлсийг хийдэг байсан гээд бод л доо. Ганц хоёрхон сарын дотор л би бүхнийг хаясан.” Гэвч нэг найз нь Камероныг семинарт яваач гэж урихад нь түүнтэй хамт явахаар шийдсэн гэнэ. Тэгэхэд нь түүнд адислал үнэхээр иржээ.

“Би Сүнснийг дахин мэдэрч эхэлсэн. Сүмд илүү их анхаарал тавьж, ням гарагийн болон санваартны хичээлүүдэд суудаг болов. Сэтгэл санаа хөнгөрч, аз жаргалтай байгаагаа мэдэрдэг болов. Би эцэстээ сайн мэдээний гэрчлэлтэй болсон” гэж Камерон ярилаа. Камерон семинарт яваад хоёр сар болсны дараа бишоптойгоо уулзаж, Аароны санваартан, багшаар томилогджээ.

Семинар дэлхийн уруу таталтуудыг эсэргүүцэхэд өөрт нь тусалдгийг Камерон мэднэ. “Семинарт явж байсан

цагт, дэлхийгээс ирдэг сорилтуудыг шийдвэрлэхэд надад амар байдаг. Бидний амьдарч байгаа дэлхийд нүгэл хилэнц биднийг бүх талаас хүрээлэн бүсэлсэн учраас залуу хүнд тун амаргүй байдаг. Хэрэв та нар семинарт явбал уруу таталтаас өөрийгөө хамгаалах хүч чадлыг олох болно гэдгийг би гэрчилж байна. Семинар та нарын сүнслэг байдлыг хамгаалах бамбай болно. Олон хүнд сорилт, уруу таталт миний амьдралд тохиолдсон үед нарийн бөгөөд давчуу зам дээр үлдэхэд семинар чухам тийм бамбай болж тусалсан билээ.”

Бие биеэ хүчирхэгжүүлэх нь

Семинар нь бас итгэл нэгтэй өсвөр үеийнхэнтэй уулзаж, танилцах боломжийг өөрт чинь

олгоно. “Ёс суртахууны адил жишгүүд, адил санаа бодолтой бөгөөд Бурханд итгэдэг над шиг хүмүүсээс би сүнслэг нөлөө авдаг.” Хэрэв асуудал гарвал би семинарын багштайгаа эсвэл бусад суралцагчидтай зөвлөж болно. Би өөрийнхөө болон өрөөл бусдын гэрчлэлийг бэхжүүлэхийн тулд бодол санаа, гэрчлэлээ бусадтай хуваалцаж болно. Бид судруудыг хамт уншиж, сүнслэг агуулгыг нь тунгаан бодсоноор Бурханд болон бие биедээ улам ойртдог” хэмээн Оросын Вика Челишкова ярьж байна.

Украины Ксения Гончарова мөн ийм бодолтой ажээ. “Бид туршлагаа бие биетэйгээ хуваалцсанаар илүү бат бөх итгэлтэй болж, судруудыг илүү сайн ойлгоно. Хичээлийн үеэр амьдралынхаа тухай ярилцах





СЕМИНАР ЕРӨНХИЙЛӨГЧ ХЕНРИ Б.АЙРИНГИЙН АМЬДРАЛД НӨЛӨӨЛСӨН НЬ

1912 онд Майлдрид Беннион Гранитын Семинарын анхны ангийн суралцагчдын нэг байлаа. Тэрбээр хожим нь Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх, Ерөнхийлөгч Хенри Б.Айрингийн эх болсон юм.

Семинар амьдралд нь чухал ач холбогдолтойг Майлдрид ойлгон, семинараас өөрт нь ирсэн адислалуудыг хүүхдүүд нь мөн хүртэхийг хүсдэг байжээ. Тиймээс тэд гэр бүлээрээ нэгэн чухал шийдвэр гаргасан ажээ. “Хөвгүүд маань семинар, институтэд явж, итгэл нэгтэй хүмүүсийн дундаас найз нөхөдтэй болохын төлөө бид санхүүгийн их золиослол хийж, Ютад шилжин ирсэн юм. Энэ нь эн тэргүүнд анхаарах зүйлийн тухай миний асуултын хариу болсон билээ” (C. Coleman, *History of Granite Seminary*, 142-оос эш татжээ).

Ерөнхийлөгч Хенри Б.Айрингийг 1971 онд Сүмийн эзэмшдэг Рикс коллежийн (одоогийн Айдахо БЯИС) ерөнхийлөгч болоход мөн түүнийг Сүмийн Боловсролын Системийн Бүрэн эрхт төлөөлөгчөөр 1980–1985 онуудад үйлчлэх үед тэдний гэр бүлд Сүмийн боловсрол чухал ач холбогдолтой хэвээр байлаа.

үед миний болон бусад хүмүүсийн амьдралд сайн мэдээ хэрхэн нөлөөлдөг арга замыг мэдэж авдаг” хэмээн тэр ярьж байна.

Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрыг мэдэх нь

Семинар тэднийг хэрхэн адисалсан тухай хэсэг залуусаас саяхан асуусан юм. Семинар тэднийг Тэнгэрлэг Эцэг, Аврагч хоёрт илүү ойр дотно болоход нь тусалсныг тэдний хариулт харуулж байна. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Давид А.Беднар сургасан нь: “Семинарт та нарын судалдаг бүх сэдэв чухал юм. Жил бүр судраас судлахад гол сэдэв нь Их Эзэн Есүс Христ байдаг.”

Семинар тэднийг Есүс Христэд хэрхэн ойртуулсан тухай өсвөр насны зарим суралцагчид юу гэж хэлснийг сонирхье.

- “Олон бошиглогчийн бичсэн шастируудыг уншиж, би Түүнд хэчнээн чухал болохыг ойлгосноор Аврагч миний төлөө юу хийснийг мэдсэн юм. Тэрбээр надад хайртай учраас миний нүгэл хилэнцийн төлөө зовон шаналж, нас барсныг би ойлгосон.
- “Семинар бол миний өдрийн баясгалант эхлэл мөн. Би хэчнээн ядарсан ч, хүнд сорилтууд амьдралд минь тохиолдсон үед Аврагч минь надад хайртай учраас би зөв зүйлийн төлөө улам итгэлтэй зогсох болно гэдгээ өчүүхэн ч эргэлзээгүйгээр мэддэг билээ.”
- “Би Бол Сүмийн хөрвөгч. Бүр баптисм хүртэхээсээ өмнө семинарт явж эхэлсэн. Семинарт яваагүй бол би ер нь баптисм

хүртэх байсан болов уу гэдгээ ч мэдэхгүй байна. Семинарт яваагүй бол эдүгээ миний амьдралд Аврагч байхгүй байсан болов уу. Эсвээс би нүглээсээ уучлагдаж болно гэдгийг мэдэхгүй байх биз ээ. Миний амьдралд Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр ерөөсөө байхгүй байж ч болох байсан. Семинар Бурхан Эцэг, Есүс Христ хоёрыг олж Тэднийг өөрийнхөө болон ирээдүйн үр удмынхаа үүрдийн амьдралын хэсэг болгоход надад тусалсан юм.

- “Семинарт өдөр бүр явах нь Түүний сургаалуудыг болон намайг хайрладаг Түүний агуу хайрыг мөн Түүнтэй хамт амьдрахаар хэрхэн эргэж очихыг мэдэж, Их Эзэн, Аврагч Есүс Христтэй улам ойр дотно болоход надад тусалдаг” хэмээн тэр ярилаа.
- “Би семинарт судруудын утгыг гүнзгий ойлгосон. Өдөр тутмынхаа ажил үйлсэд Христтэй адилхан байх ёстойг өглөө бүр санахад семинар надад тусалдаг.”
- “Семинар судар хэрхэн уншихыг, сударт зөвхөн дуртай байх төдийгүй үзэл санааг нь хэрхэн хэрэгжүүлэхийг надад заасан юм. Хайраар дүүрэн Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрын тухай гэрчлэлээ бэхжүүлэхэд надад тусалсан сургаал, зарчмуудыг би амьдралынхаа үлдсэн хугацаанд зүрх сэтгэлдээ тээж явах болно.

Дэлхий даяарх залуучууд семинарыг эн тэргүүнд анхаарах зүйлээ болгосноор үүнээс ирдэг үй олон адислалыг авдаг билээ. ■

ЭШЛЭЛ

1. Бонд К.Пакер, *Teach the Scriptures* (Сүмийн Боловсролын Системийн ажилтнуудад хандан хэлсэн үг, 1977 оны 10-р сарын 14), 3.
2. Л. Том Перри, "Raising the Bar," *Лиахона*, 2007 оны 11-р сар, 48.
3. Ричард Г.Скотт, "Realize Your Full Potential," *Лиахона*, 2003 оны 11-р сар, 42.
4. Гордон Б.Хинкли, "Stand True and Faithful," *Ensign*, 1996 оны 5-р сар, 93.
5. Гордон Б.Хинкли, "The Miracle Made Possible by Faith," *Ensign*, 1984 оны 5-р сар, 47.
6. Гордон Б.Хинкли, "The State of the Church," *Ensign*, 1991 оны 5-р, 52.
7. Эзра Тафт Бенсон, "Our Responsibility to Share the Gospel," *Ensign*, 1985 оны 5-р сар, 7.
8. Даллин Х.Өүкс, "Good, Better, Best," *Лиахона*, 2007 оны 11-р сар, 104.
9. Давид А.Беднар, "Conclusion and Testimony," *Welcome to Seminary 2010–2011*, seminary.lds.org/welcome.

СЕМИНАРЫН ТҮҮХ

Өнгөрсөн он жилүүдэд семинар хэрхэн өсч хөгжсөнийг харцгаая.

- 1888 он: Ерөнхийлөгч Вилфорд Вудрафф Сүмийн боловсролын ажил, түүний дотор сургуулийн хичээлийн дараах шашны хичээлийг удирдан чиглүүлэх үүрэгтэй Сүмийн Боловсролын Зөвлөлийн ажилд хяналт тавьдаг байлаа.
- 1912 он: Сургуулийн хичээлийн хуваарьт багтан өдөр хичээллэдэг семинарын анхны ангиуд ахлах сургуулийн нийт 70 сурагчтайгаар зохион байгуулагдав. Эдгээр ангиуд АНУ-ын Ютагийн Солт Лейк хот дахь Гранит Ахлах Сургуулийн гудамжны нөгөө талд хичээллэдэг байлаа.
- 1925 он: Суралцагчдын тоо 10,000-д хүрэв.
- 1948 он: Нэгдсэн Улсаас гадна анх удаа Канадад семинар нээгдэв.
- 1950 он: Өдөр тутмын семинарын ангиудыг (өмнө нь өглөө эртийн семинар гэдэг байсан) Калифорнид зохион байгуулав. Суралцагчид сургуулийн хичээл эхлэхээс өмнө Сүмийн цуглааны байруудад хичээллэдэг байв.
- 1958 он: Суралцагчдын тоо 50,000-д хүрэв.
- 1958 он: Төв Америкт семинар анх удаа Мексикт нээгдэв.
- 1962 он: Европт семинар анх удаа Финлянд, Германд нээгдэв.
- 1963 он: Азид семинар анх удаа Японд нээгдэв.
- 1965 он: Суралцагчдын тоо 100,000-д хүрэв.
- 1967 он: Хөдөө нутагт гэрээр суралцах семинар нээгдэв. Энэ семинарт суралцагчид долоо хоногт 4 өдөр гэрээрээ суралцаж, нэг өдөр цугладаг байлаа.
- 1968 он: Семинар Австралид нээгдэв.
- 1969 он: Өмнөд Америкт семинар анх удаа Бразилд нээгдэв.
- 1972 он: Африкт семинар анх удаа Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсад нээгдэв.
- 1983 он: Суралцагчдын тоо 200,000-д хүрэв.
- 1991 он: Суралцагчдын тоо 300,000-д хүрэв.
- 2012 он: Дэлхий даяар семинар 134 улс орон нутаг дэвсгэрт 370 000 орчим суралцагчтайгаар хичээллэж байна.



ХӨРВӨГЧИЙН ДУУДЛАГА

Хелена Ханнонен



Б и 10-тайдаа Финландын Лаппийнрантад баптисм хүртсэнээс хойш удалгүй Сүмийн анхны дуудлага авч билээ. Энэ бол 1960 он байсан бөгөөд манай жижигхэн салбарт ариун ёслолын цуглаан дээр дуу хөгжим удирдах хүн маш их хэрэгтэй байлаа. Энэ үүрэгт ажлыг хийхийг надаас хүсэв.

Манай ээж ах бид хоёрыг урлагийн авьяасаа хөгжүүлэхийг дэмждэг ч, би төгөлдөр хуур яаж тоглохыг мэддэггүй байв, тэгээд ч манайд төгөлдөр хуур байсангүй. Гэвч би дуудлагат ажлаа хийхийг хүсч байсан болохоор бид хамтран төлөвлөгөө гаргав.

Энэ дуудлага бид бүгдийн хувьд чухал болохыг гэр бүлийн үдшээр ярилцдаг байлаа. Гэвч манай ээж бага насны хоёр хүүхэдтэй, бэлэвсэн эмэгтэй байсан болохоор төгөлдөр хуур худалдан авч, төлбөртэй хөгжмийн хичээл заалгана гэдэг



*Би шинэ хөр-
вөгч байхдаа
төгөлдөр хуур
тоглож чад-
даггүй байлаа.
Гэвч салбарын
хөгжмийн
удирдаачийн
дуудлага амьд-
ралыг минь
өөрчилсөнд
би хэчнээн
их баяртай
байдаг гээч.*

бүтэшгүй хэрэг болохыг бид мэдэж байв. Бид бүгдээрээ шаардлагатай золиослолыг хийе гэж шийдэв.

Манай гэр бүлийн хийсэн анхны золиослол санхүүгийнх байлаа. Бид хавраас намар хүртэл автобусаар явахгүй, дугуй унаж байж гэж шийдлээ. Манай ах Маргги үүнд их дуртай байв. Иймээс тэр бүр цас, мөсөн дээр ч дугуйгаар онцгой сайн явдаг болж билээ. Би ихэнх хувцсаа худалдаж авахаа больж, юм оёж сурлаа. Бид бас арвич хямгач амьдарч сурав. Хөдөө байдаг өвөөгийнхөө байшингийн ойролцоо ногоо тарьж, өвлийн хүнсээ базаадаг болов. Бидний “амралт” ээжийн маань Швейцарийн Ариун сүм уруу явдаг аян эсвэл гэрийнхээ ойролцоо салхинд гарч зугаалах болж хувирав.

Манай гэр бүлийн хийсэн хоёр дахь золиослол бол цаг хугацаа юм. Бид гэрийн ажлаа хувааж хийн, бусад үйл ажиллагаанууд болон гэрийн даалгавраа хуваарь гарган хийдэг болсноор надад төгөлдөр хуурын дадлага хийх хангалттай цаг гарсан билээ. Золиослол болон шаргуу ажил хөдөлмөрийн улмаас бидний насны бусад хүүхдүүдэд тохиолддог шиг төвөгтэй асуудалд ороолцолдох цаг бидэнд байдаггүй гэж ээж олонтаа ярьдаг байж билээ. Чухамдаа намайг ноотоор тоглож суртал миний дуудлага манай гэр бүлийн дуудлага байсан юм.

Би орон нутгийн нэг сургууль дээр хөгжмийн багшаар хичээл заалгаж эхлэв. Дадалагадаа цаасан даралтуур хөгжим болон сүмийн төгөлдөр хуурыг ашиглана. Хөгжмийн багшаа өөр газар шилжихэд бид төгөлдөр хуурыг нь худалдаж аваад, нутагтаа нэрд гарсан төгөлдөр хуурын багшаар би хичээл заалгах болов.

Дуулуудыг бие даан сурч, салбарын хөгжмийн удирдагчтай хамт удаан дадлага хийсэн. Ноогоо “буруу тоглосон ч,” хүн бүр надад урам хайрлан дэмждэг байлаа. Намайг бүх ноогоо сайн сурч, цээжлэхээс өмнө

хүмүүсийн өмнө гарч тоглосныг багш маань мэдээд цочсон гэдэг. Гэвч нэг гараар тоглох нь огт хөгжимгүй байснаас дээр биз дээ.

Хөгжмийн хичээлдээ дугуйгаар явна. Өвөл болоход явган юм уу бололцоо гарвал цанаар явна. Ням гараг бүр нэг цагийн өмнө очиж, дадлага хийхийн тулд Сүмийн цуглаанд ганцаараа очно. Агаарын хэм Цельсийн -150-аас доош болсон үед л зөвхөн автобусаар явна. Бороо, цас миний санааг огт зовоодоггүй байлаа. Олон сайхан дууллыг дотроо санаж явдаг болохоор явган явахад цаг хурдан өнгөрнө. Би явган явж байхдаа анхдагчуудтай хамт хээр талыг туулна (“Ирцгээ, ирцгээ, Гэгээнтнүүд ээ,” *Сүмийн дуулал болон хүүхдийн дуу*, х. 2-ыг үз), уулын оргил дээр гарна (“Уулын оргил дээр,” *Сүмийн дуулал болон хүүхдийн дуу*, х. 30), хэзээ ч үл шантрах залуустай хамт байна (“True to the Faith [Итгэлдээ үнэнч],” *Hymns*, дугаар 254). Оростой хаяа нийлэн оршдог дорнод Финляндын энэ нутагт манай гэр бүл ганцаархнаа Хожмын Үеийн Гэгээнтнүүд хэдий ч, дуулуудаас ирдэг энэхүү урам зориг намайг хэзээ ч шантрахад хүргээгүй юм.

Он жилүүд өнгөрөх тусам би төгөлдөр хуураар сайн тоглодог болж, хөгжим миний амьдралд зөвхөн ноотыг зөв тоглохоос илүү чухал зүйл болсон билээ. Цуглаан дээр Сүнс байхын тулд би хөгжмийг залбиран сонгож сурсан. Хамгийн чухал нь, сайн мэдээний тухай миний гэрчлэл хөгжмөөр дамжин ирсэн юм. Хэрэв би ямар нэг юманд эргэлзвэл, дуулуудын үг, захиас, дуулаас төрдөг гайхамшигтай мэдрэмжийг эргэн санадаг. Сайн мэдээний зарчмууд болон ёслолууд үнэн гэдгийг би мэднэ. Тэдгээрийг би шат шатаар, ноот ноотоор сурсан билээ.

Эдгээр зарчмуудад итгэх миний шийдвэр төгс байдал нэг удаа сорилттой тулгарсныг би санадаг. Тэгэхэд би 14-тэй байлаа, усанд сэлдэг, тэгээд бүр Олимпын тоглолтонд



оролцохыг мөрөөддөг байсан гээч. Ням гарагт тэмцээнд оролцдоггүй байсан ч миний чадвар үргэлж өсч хөгжсөөр байлаа. Тэгтэл Мексик хотод болох Олимпын Тоглолт ойртсон үед нэгэн дасгалжуулагч намайг дасгал сургуулилд оролцохыг урив.

Харин сургуулиалт ням гараг бүрийн өглөө ням гарагийн хичээлийн үеэр болох байв. Ням гарагийн хичээлд явалгүй, дасгал сургуулилтаа хийж болох юм биш үү. Учир нь ариун ёслолын оройн цуглаанд оролцох цаг гаргаж болно шүү дээ гэж бодов. Тэгээд автобусны мөнгө хурааж, бүх зүйлээ төлөвлөв. Сургуулилын өмнөх бямба гарагт төлөвлөгөөнийхөө тухай ээждээ хэллээ.

Ээжийн нүүрэнд гуниг, урам хугаралт илрэхийг харлаа. Гэвч ээж энэ бол чиний өөрийн чинь шийдвэр гэдгийг хэлээд юу зөв болохыг надад заасан юм. Тэр шөнө “Choose the Right [Зөвийг сонго]” (*Нутнс*, дугаар 239) дууллын үг миний санаанаас гарсангүй. Тэр дууллын үг миний толгойд эвдэрсэн пянз тоглуулагч шиг дахин дахин сонсогдсоор байсныг яана.

Ням гарагийн өглөө би усан сэлэлтийн цүнхээ нэг гартаа, хөгжмийн цүнхээ нөгөө гартаа барин, ээж намайг сүм уруу явж байгаа юм байна гэж бодог гээд гарч явлаа. Гадаа гараад автобусны буудал уруу явав. Усан сэлэлтийн бассейн уруу явдаг автобусны зогсоол гудамжны наад талд, харин цуглааны байр уруу явдаг автобусны

Нэг автобус намайг Сүмийн дуудлагад минь хүргэж өгсөн бол нөгөө нь усан сэлэлтээр дэлхийн хэмжээнд нэрд гарах гэсэн хүүхэд ахуйн мөрөөдөлд минь хүргэж өгөх байлаа. Миний тоглодог байсан дууллын хөгжим тулгарсан асуултуудын хариуг надад олон удаа өгсөн юм.

зогсоол гудамжны нөгөө талд байдаг байлаа. Хүлээж зогсол нэг л дургүй хүрээд явчихав. “Have I Done Any Good?” (Би сайн юм хийсэн үү?) дууллын хөгжим санаанаас гарахгүй, чихэнд сонсогдсоор байлаа. Энэ дууллыг (*Нутнс*, дугаар 223) тэр өдрийн ням гарагийн хичээлээр дуулахаар төлөвлөсөн байлаа. Энэ дуулал хэцүү айзам, утга уянгын нарийн хөг ая, өндөр нооттой болохоор сайн удирдаачгүй бол дуулахад эвгүй байж болохыг би туршлагаасаа мэдэж байлаа.

Яая даа байз хэмээн эргэлзэж байтал хоёр чиглэлийн автобус хоёулаа хүрээд ирэв. Усан бассейн уруу явдаг автобус намайг хүлээн зогсол сүм уруу явдаг автобус бас зогсоод намайг гайхсан янзтай харав. Учир нь намайг үргэлж энэ автобусаар явдгийг жолооч нь мэднэ. Бид бүгдээрээ хэдэн хором бие биенээ ширтэн харлаа. Би ер нь юу хүлээж байсан хэрэг вэ? Ингээд би Их Эзэнийг сонголоо (“Хэн Их Эзэний талд байна вэ? Дууллын ном, 260-р дууллыг үз.” (*Нутнс*, дугаар 260). Их Эзэн намайг хаашаа явахыг хүснэ, би тийшээ явахаар амласан (“Хаа ч дуудсан би үйлчлэх болно,” *Сүмийн дуулал болон хүүхдийн дуу*, х. 46-г үз). Зарлигуудыг сахих шийдвэрээ гаргаад удаж байна (“Keep the Commandments [Зарлигуудыг сах],” *Нутнс*, 303-р дууг үз).

Аль автобусанд суухаа шийдэхээс өмнө би нэг л мэдэхэд гудамж гатлан, нөгөө

автобусны жолооч уруу даллан ухаан жоолоогүй гүйж байв. Мөнгөө төлөөд сүмийн зүг хөдөлсөн автобусны ар тал уруу очиход дэлхийд нэрд гарсан сэлэгч болох мөрөөдөл минь замхран алга болсон юм шиг санагдаж билээ.

Тэр өдөр Сүнсийг мэдэрсэн учраас намайг уйлж байна гэж хүн болгон бодсон гэдэг. Харин би хүүхэд насны минь мөрөөдөл нуран унасны улмаас, бас Хүндэтгэлийн өдөр усанд сэлэхээр завдаж байсандаа ичсэнээс үнэнээсээ уйлсан юм. Гэвч би тэр ням гарагт ч бас түүнээс өмнө ч, дараа нь ч дуудлагаа биелүүлж ирсэн.

Би коллежид явахаасаа өмнө салбарынхаа нэлээд хэдэн гишүүнийг хөгжим удирдаж, төгөлдөр хуур тоглож сургасан. Би коллежид төгөлдөр хуур тоглохоо үргэлжлүүлж, бадралт баг бишгүүрийн хичээл заадаг байв. Усанд сэлэлтийн тэмцээнд оролцох хүслээ орхисон болохоор Латин Америкт очих боломжгүй боллоо хэмээн боддог болж билээ. Гэвч Бригам Янгийн Их Сургуульд магистрын зэрэг хамгаалсны дараа Колумбид номлолд үйлчлэв. Номлолд байхдаа төгөлдөр хуурын хичээл заадаг байлаа. Миний заадаг байсан Гэгээнтнүүд хөгжмийн бэлэгтэй үддээсэй хэмээн хүсдэг байлаа. Колумбын хүүхэд залуучууд төгөлдөр хуур тоглож сурахын тулд аагим халуун наранд хэдэн км газар явган явдаг байлаа. Тэд ч бас хоёр гараараа тоглож суртлаа нэг гараараа тоглодог байсан. Бас тэд төгөлдөр хуур тоглож сурахаар чармайхдаа надаас илүү золиослол хийсэн юм.

Намайг баптисм хүртсэнээс хойш эдүгээ 50 гаруй жил өнгөрчээ. Би Финлянд дахь гэрээсээ олон удаа хол газар явж үзсэн ч, хаашаа ч явсан хэн нэгэнд зориулж дуулал тоглох хэрэг үргэлж гардаг байлаа. Бүх хүмүүст адилхан ойлгогддог хөгжмийн хэл олон газар оронд харилцан ойлголцол, хайрын гүүр болж байна.

Би Колумби дахь номлолынхоо үеэр төгөлдөр хуурын хичээл заадаг байлаа. Хүүхэд, залуучууд хөгжим сурч, хөгжмийн бэлэгтэй болохын тулд их золиослол хийн, аагим халуун наранд хэдэн км явган явдаг байв.

Өнөөдөр миний гар удаан хөшүүн, бэртэнгэтэй болж, миний халааг олон чадварлаг хөгжимчин аваад байна. Ээж минь Сүмд өнгөрүүлсэн миний хүүхэд ахуй насны жилүүдийг, хийсэн олон золиослол, олон км явган явдаг байсныг, бас миний золиосолсон зүйлсийг эргэн санаад олонтаа гунигтай байдаг. Хүйтэн цаг агаар миний бэртэнгэд нөлөөлөхвий гэж ээж минь айдаг. Гэвч хийсэн олон золиослолынхоо энэхүү сануулагчийг хараад би баяртай байдаг. Баяр баясгалан, уй гашуугаа хөгжимтэй холбож, хөгжим тоглож байхдаа сэтгэлдээ инээж, уйлж сурсан юм.

Тэнгэрлэг Эцэг болон миний удирдагчид ийм төвөгтэй ажил үүргийг гүйцэтгэхийг бага насны охиноос хүссэнийг бодоход зүрх сэтгэл минь талархлаар дүүрдэг билээ. Миний дуудлага сайн мэдээний тухай бат бөх ойлголттой болох, хөгжмөөр дамжуулан Сүнсийг мэдрэхэд нь бусдад туслах боломжийг надад олгосон билээ. Шинэ хөрвөгчдөд, бүр төгөлдөр хуур тоглож чаддаггүй бяцхан охидод хүртэл дуудлага хэрэгтэй байдгийн амьд нотолгоо нь би байна. Бурханд боломжгүй юм гэж байдаггүй бөгөөд Өөрийнхөө хүүхэд нэг бүрд зориулсан төлөвлөгөө, зорилго Түүнд байдгийг би анхны дуудлагаараа мэдсэн юм. Би хөгжмөөр дамжуулан Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээний тухай гуйвшгүй гэрчлэлтэй болсон хүн. ■




Тойргийн ЗӨВЛӨЛИЙН АЖИЛ

ЛаРийн Гаунт

Сүмийн сэтгүүлүүд

*Хожмын Үеийн Гэгээнтнүүд тойрог,
салбарын зөвлөлөөр дамжуулан
тусламж хэрэгтэй хүмүүсийн
амьдралыг адисалдаг.*



2011 оны тавдугаар сарын 22-ны шөнө хангинасан чанга дуут дохиотой зэрэгцэн, их хар салхи АНУ-ын Миссурийн Жоплины төвийг нөмрөн олон орон гэрийг сүйтгэж, олон хүний амийг авч одсон билээ. Жоплины нэгдүгээр тойрог хар салхинд хүндээр нэрвэгдсэн ч бишоп Крис Хоффман болон тойргийн зөвлөл тэр даруйд гишүүдийн аюулгүй байдалд анхаарал тавьж эхэлжээ.

“Бид гамшиг болохоос өмнө тойргийн зөвлөлөөр гамшигт бэлтгэлтэй байх асуудлыг хэлэлцсэн учраас хариу арга хэмжээ авах төлөвлөгөө бэлэн байлаа” гэж тэр яриу. “Бид бас юу хийхээ мэдэхийн тулд Сүнсэнд найдвар тавьж байсан. Эрчим хүчний шонгууд унаж, гар утас ажиллахгүй болсон. Бид залбирч хариу хүлээн чагнаж байтал хариу ирсэн. Ер нь үргэлж ирдэг л дээ. Гишүүд “Намайг юу хийхийг та хүсэхсэн бол?” гэж асуухын оронд “За би ийм зүйл хийлээ” гэж хэлэхийг сонсвол бишоп би баяртай, сэтгэл хангалуун байдаг.

Жоплинд гамшигт хариу арга хэмжээ авсан нь тойргийн зөвлөлийн эв нэгдлийн хүчийг харуулсан юм. “Тойргийн зөвлөлийн хурал бол Сүмийн хамгийн чухал хурлуудын нэг. Учир нь санваартны чуулгын болон туслах бүлгүүдийн удирдагчид бишопын зөвлөлтэй хамтран хэлэлцэж, төлөвлөгөө гаргадаг. . . . Сүм дэх бүх зөвлөл, хороодоос тойргийн зөвлөл Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдэд туслахад хамгийн их нөлөө үзүүлдэг гэдэгт



би итгэдэг” гэж Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч М.Расселл Баллард бичжээ.¹

Хайр итгэлээр нэгдэх нь

Эквадорын ширэнгэн ойд алслагдсан бөглүү тосгон Пуэрто Франциско де Орелланад гишүүд хайр, итгэлийн хүчирхэг холбоотой байдаг. Сар тутам болдог салбарын зөвлөлийн хурал тэдний анхаарал, халамжийг харуулдаг. Тэд юуны өмнө хувь хүмүүс, гэр бүлүүдэд, дараа нь хөтөлбөрүүд хэрхэн хэрэгжиж байгаад анхаарал төвлөрүүлдэг ажээ. Ингэсэн үед сүнсний удирдамж ирдэг байна.

Олон гишүүдэд ажил олоход нь туслах хэрэгтэй байдаг гэнэ. Гишүүдийн асуудлыг ихэнхдээ орон нутагт шийдвэрлэх боломжтой гэж салбарын зөвлөл үзэж байна. Эрүүл мэнд нь тааруухан бага насны охинтой ганц бие эхийн хэрэгцээг салбарын зөвлөлөөр хэлэлцэхэд Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч тэр эх охинтойгоо ойр байхын сацуу ажил хийх боломж байгаа гэдгийг хэлжээ.

Салбарын зөвлөл ХҮГ Сүмийн ажил эрхлэлтийн төвийн сургалтын материалууд зэрэг Сүмийн нөөц боломжийг ашигладаг байна.² Тус салбарын нэг гишүүн анги зохион байгуулж хичээл заан, өөр нэг гишүүнд сайн ажил олоход нь тусалсан гэнэ.

Салбарын ерөнхийлөгчийн зөвлөлийн нэгдүгээр



ҮР АШИГТАЙ ЗӨВЛӨЛИЙН ҮНДСЭН ШАЛГУУР

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч М.Расселл Баллард *Counseling with Our Councils* номондоо дараах гурван зөвлөмжийг өгчээ:

“Нэгдүгээрт, суурь сургаалууд дээр анхаарал төвлөрүүл.” Гарын авлага 2: Сүмийг удирдах нь, бүлэг 4 дэх удирдамжуудыг баримтал. Энэ бүлэг бас онлайнд LDS.org-ийн Serving in the Church хэсэгт байгаа.

“Хоёрдугаарт, хөтөлбөр дээр биш, хүмүүс дээр анхаарал төвлөрүүл.” Шинэ гишүүдийг тойргийнхоо хэсэг болгохыг хичээн, идэвх султай гишүүдийг идэвхжүүлж, залуучуудын болон гишүүдийн аж байдлын асуудлууд, ганц бие эхчүүд, бэлэвсэн эмэгтэйчүүдийн хэрэгцээнд анхаарал тавь.

“Гуравдугаарт, зөвлөл бол зөвлөгөө өгч, санаа бодлоо хуваалцах зорилготой болохоос тайлан тавьж, лекц уншдаггүй. Хүн болгон эсвэл бүлэг бүр зөвлөлд чухал үүрэг гүйцэтгэдэг, хүн бүрийн саналыг үнэ цэнэтэй гэж үзэн хүндэтгэлтэй ханддаг уур амьсгалыг бүрдүүл. Хүн бүр өөр үзэл бодол, боловсролын өөр өөр төвшинтэй байдаг. Иймээс гишүүдийн хэрэгцээг ойлгоход хүн бүр хэрэгтэй зөвлөгөөг өгч чадна.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч М. Рассел Баллард, *Counseling with Our Councils* (1997), 106, 109, 112-ыг үз.



зөвлөх Рамиро Райс салбарын зөвлөлийн талаар ийн хэллээ: “Бид бол Их Эзэний мутар дахь зэмсэг. Тэр бидний ажлаар дамжуулан зорилгодоо хүрдэг.”

Ариун сүмд хүрэх зам

АНУ-ын Нью-Йоркийн Ливерпульд Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгч Мелисса Фиск тойргийн зөвлөлийн хуралд оролцсоноор зөвлөлийн хүчийг аажмаар ойлгожээ. Тэр цүнхэн доторх тэмдэглэлийн дэвтэртээ хүртэл Нью-Йоркийн Палмира Ариун сүмийн довжоон дээр зогсож буй Хүүхдийн Хэсгийн 28 хүүхдийн зургийг харсан аж. Хүүхдүүд бүгдээрээ хэдгэнэд хатгуулсан байв. Тэр зураг түр хугацаанд анхаарлыг

нь хурлаас хөндийрүүлэхэд, тойргийн Хүүхдийн Хэсэг ариун сүмийн газар дээр ариун нандин мэдрэмжийг мэдрэхээр Палмира уруу очсон тэр өдөрт анхаарлаа түр төвлөрүүлжээ. Харамсалтай нь, хүүхдүүд хөнжлөө газарт дэвсэхдээ санаандгүйгээр хэдгэнийн үүрийг хөндсөн ажээ.

Хэдгэнэнд хатгуулсан хүүхэд бүрд анхаарал тавьж зохих арга хэмжээ авсны дараа удирдагчид тэднийг ариун сүмд бүр тулж очихыг урихад хүүхдүүд бүр олон хэдгэнэ байгаа гэж айн татгалзав. Тиймээс удирдагчид, эцэг эхчүүд ариун сүм уруу очих замын хоёр талаар эгнэн, хүүхдүүдийг хүрээлэн зогсоход сая тэд зориглон урагш хөдөлжээ.

Мелисса тойргийн зөвлөлийн хуралд анхаарлаа дахин хандуулж, “Хүн болгон ариун сүмд хүрэх замдаа

ТОЙРОГ БУЮУ САЛБАРЫН ЗӨВЛӨЛИЙГ ЯМАР ХҮМҮҮС БҮРДҮҮЛДЭГ ВЭ?

Дараах санваартны болон туслах бүлгийн удирдагчид тойргийн зөвлөлд хоёр зорилгоор: (1) тойргийн хэрэгцээ болон тулгамдсан асуудлуудын шийдлийг олоход бишопт туслах, тойргийн зөвлөлийн гишүүдийн хувьд (2) өөрийн байгууллагын төлөөлөгчийн хувиар оролцоно. Тэд тойрог буюу

Бишопын зөвлөл

Бишопын зөвлөл тойргийн нийт гишүүд, байгууллага болон үйл ажиллагаануудын төлөө хариуцлага хүлээнэ. Бишоп тойргийн зөвлөлийн хурлыг тэргүүлэх боловч шаардлага гарсан үед зөвлөхүүдтэйгээ болон тойргийн зөвлөлтэй ярилцсаны үндсэн дээр сайн шийдвэр гаргаж чадна.

(Гарын авлага 2: Сүмийг удирдах нь, 4.1; 4.2-ыг үз.)

Тойргийн бичиг хэргийн ажилтан

“Тойргийн бичиг хэргийн ажилтан тойргийн зөвлөлийн хурал дээр өгсөн үүрэг даалгавар болон гаргасан шийдвэрийн тухай тэмдэглэл хөтөлнө. . . . Тэр бас Сүмийн бүртгэл хөтөлтийн програмаас статистикийн холбогдох мэдээллээр хангана.

(Гарын авлага 2, 4.6.4-ийг үз.)

Гүйцэтгэх нарийн бичиг

“Гүйцэтгэх нарийн бичиг тойргийн зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлуудын төлөвлөгөөг бэлтгэнэ. . . . Бишоп бас тойргийн зөвлөлийн гишүүдэд өгсөн үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавихад туслахыг түүнээс хүсч болно. . . . [Тэр] бас тойргийн зөвлөлийн болон санваартны гүйцэтгэх хорооны хурлыг байнга явуулах үүрэгтэй.

(Гарын авлага 2, 4.6.5-ыг үз.)

Мелкизедек санваартны удирдагчид

Дээд пристүүдийн бүлгийн удирдагч, ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч хоёр өөрсдийн тэргүүлдэг эрэгтэйчүүдийн сүнслэг болон материаллаг сайн сайхан байдлын төлөө хариуцлага хүлээдэг. Бишоп гэр бүлдүүдийн талаар зохион байгуулдаг ажлынхаа нэг хэсгийг чуулгын болон бүлгийн удирдагчдад даалган хариуцуулж болно.

(Гарын авлага 2, 7-г үз.)

Тойргийн номлолын удирдагч

Тойргийн номлолын удирдагч тойргийн номлолын ажлыг зохицуулна. Тэр бүрэн цагийн болон тойргийн номлогчидтой ажилладаг. Тойргийн зөвлөлийн хурал дээр номлолын ажлын тухай хэлэлцүүлэг хөтлөн явуулахыг бишоп түүнээс хүсч болно.

(Гарын авлага 2, 5.1.3-ыг үз.)

үүн шиг хайрт найз нар, удирдагчдаар хүрээлүүлж болно шүү дээ” гэж бодсон ажээ.

Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч тусламж хэрэгтэй нэг эгчийн талаар: “Тэр өнгөрсөн ням гарагт сүмд ирсэнгүй. Удахгүй болох ариун сүмийн аялын талаар айлчлагч багш нараар нь түүнд хэлүүлнэ” гэж хэлэхэд Меллиссагийн бодол тасалдсан гэнэ.

“Тэдэнд одоо нэг хүнд асуудал тулгараад байгаа. Би гэрийн багш нартай нь ярилцаж, тэдэнд хэрхэн тусалж болохыг мэдье” гэж ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч нэмж хэлэхэд,

“залуу эмэгтэйчүүд хүүхдийг нь харахад тусалж болно” гэж Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгч хэлэв.

Мелисса тойргийн зөвлөлийн гишүүдийн нүүрэнд жинхэнэ хайр энэрэл, санаа тавилт илэрч байхыг

хараад, инээмсэглэв. “Их Эзэн хүүхдүүдээ хайрлах, хамгаалах арга замыг *бэлтгэсэн юм.*” “Нэг арга зам нь тойргийн зөвлөл!” гэж тэр бодлоо.

Дэлхий даяарх Сүмийн удирдагчид Жоплин, Пуэрто Франциско де Ореллана, Ливерпульд болсон шиг тойрог, салбарын зөвлөлөөс ирдэг адислалуудыг нээж олсоор байна. Ийн тэд хүүхдүүдээ адисалж, Өөрийн ажлыг гүйцэлдүүлэхэд нь Их Эзэнд туслахын тулд тойрог, салбарын зөвлөлүүдийг ер бусын хүчтэй болгож байна. ■

ЭШЛЭЛ

1. М. Рассел Баллард, *Counseling with Our Councils: Learning to Minister Together in the Church and in the Family* (1997), 102.
2. *The Career Workshop Participant's Workbook* (item no. 35163) номыг store.lds.org-хаягаар орж үзэж болно, эсвэл Сүмийн Хангамжийн болон Ажил эрхлэлтийн төвүүдээс авч болно.

салбар дахь хувь хүмүүс болон гэр бүлүүдэд хайраар үйлчилж, тэднийг хүчирхэгжүүлэхийн төлөө хамтран ажилладаг. (Тойрог болон бишопын зөвлөл нь мөн салбар болон салбарын ерөнхийлөгчийн зөвлөлд хамаарна.)

Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч

Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч тойргийнхоо 18-аас дээш насны эмэгтэйчүүдийг төлөөлнө. Тэр эмэгтэйчүүдэд итгэлээ болон хувийн зөв шударга байдлаа өсгөн нэмэгдүүлэхэд нь туслах, гэр бүлүүдийг бэхжүүлэх, тусламж хэрэгтэй хүмүүст туслахын тулд чадах бүхнээ хийдэг.

(Гарын авлага 2, 9-ийг үз.)

Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгч

Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгч тойргийнхоо 12-18 насны залуу эрэгтэйчүүдийн итгэлийг бэхжүүлэхийн төлөө ажилладаг. Тэр зөвлөхүүдийнхээ туслалцаатайгаар Аароны санваартнуудын ерөнхийлөгчийн зөвлөлд (бишопын зөвлөл) тусалж, Скаутын хөтөлбөр байдаг газарт уг хөтөлбөрт хяналт тавина.

(Гарын авлага 2, 8.3.4-ийг үз.)

Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгч

Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгч тойргийнхоо 12-18 насны залуу эмэгтэйчүүдийн итгэлийг бэхжүүлэхийн төлөө ажилладаг. Тэрээр “залуу эмэгтэй бүрд ариун гэрээнүүдийг хийж, ариун сүмийн ёслолуудыг хүлээн авахуйц зохистой байхад нь туслах” үүрэг хариуцлагатай юм.

(Гарын авлага 2, 10.1.1-ийг үз.)

Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгч

Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгч нь тойргийнхоо 18 сартайгаас 11 настай хүүхдүүдийг төлөөлнө. Тойргийн зөвлөл тойргийн хүүхдүүдэд нөлөөлөх асуудлуудыг авч хэлэлцэх үед түүний санал хэрэг болдог.


(Гарын авлага 2, 11-ийг үз.)

Ням гарагийн ангийн ерөнхийлөгч

Ням гарагийн ангийн ерөнхийлөгч ням гарагийн ангийн үеэр заагддаг сайн мэдээний бүх зааврын төлөө хариуцлага хүлээдэг. “Ням гарагийн ангийн ерөнхийлөгч нь тойргийн зөвлөлийн хуралд ирэхдээ сайн мэдээг гишүүд сүм дээр болон гэр орондоо заах, сурах арга барилыг сайжруулахад зориулсан санал боловсруулж ирнэ.”

(Гарын авлага 2, 12.2.2.)

Дуудлагадаа хэрхэн амжилт олох талаар тодорхой мэдэхийн тулд нэлээд хэдэн хэлээр байгаа Удирдлагын Сургалтын Номын Санд leadershiplibrary.lds.org хаягаар орж үзнэ үү.



Роземари М.Виксом

Хүүхдийн Хэсгийн
ерөнхий ерөнхийлөгч

Ярилцах, сонсох цаг гаргаж бай

Өнөө үед гэр бүлийн гишүүдтэйгээ зориуд цаг гарган ярилцаж, тэднийг анхааралтай сонсож байх нь хаягаар гэр бүлүүдийг мөнхөд адислах болно.

Төгс төгөлдөр нийгэмд хүүхэд бүрийг сургуулиас гэртээ ирэхэд нь шоколадтай шинэхэн шарсан төмсний жигнэмэг, шилэн аягатай хүйтэн сүүгээр угтаж, ээж нь хүүхдийнхээ тэр өдрийн тухай ярилцаж, үгийг нь сонсох цаг гаргадаг байх нь туйлын чухал юм. Бид төгс төгөлдөр нийгэмд амьдардаггүй болохоор, та хүсвэл хүүхдээ жигнэмэг, сүүгээр угтахгүй байж болох юм. Харин “түүнтэй ярилцаж, үгийг нь сонсох цаг гаргахгүй” байж болохгүй.

Хорин есөн жилийн өмнө Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх, Ерөнхийлөгч Жеймс И. Фауст (1920–2007) гэр бүлүүд маш бага цагийг хамт өнгөрүүлж байгааг харамсан тэмдэглэсэн юм. Тэрбээр 29 жилийн тэртээ ерөнхий чуулган дээр: “Өнөө үед гэр бүлүүдийн өмнө тулгарч байгаа гол асуудлуудын нэг нь бид улам бүр бага цагийг гэр бүлээрээ хамт өнгөрүүлж байгаа явдал мөн. . . . Гэр бүл хамтдаа өнгөрүүлдэг цаг бол хамгийн үнэтэй цаг–ярилцаж, бие биеэ сонсон, урам хайрлаж, юмсыг хэрхэн хийхийг үзүүлдэг цаг мөн” хэмээн хэлснийг бодоод үз дээ.¹

Бид хүүхдүүдтэйгээ цагийг хамт өнгөрүүлж, тэдэнтэй ярилцсанаар хүүхдүүд маань биднийг, бид тэднийг сайн мэддэг болно. Хүүхэд бүртэйгээ ярилцаж байх нь бидний эн тэргүүнд анхаарах зүйл, зүрх сэтгэлийн хүсэл байх ёстой.

Хүүхэдтэйгээ хуваалцахаар таны сонгох зүрх сэтгэлийн чинь хамгийн чухал захиас юу вэ?

Бошиглогч Мосе Дэд Хуулинд ингэж заажээ:

“Чи өөрийн Бурхан ЭЗЭНийг бүх зүрх, бүх сэтгэл, бүх хүч чадлаараа хайрла.

“Өнөөдөр миний чамд тушааж байгаа энэ үгсийг чи зүрхэндээ байлгаж,

“хөвгүүдээ хичээнгүйлэн зааж, гэртээ сууж байхдаа ч, замд явж байхдаа ч, өндийн босохдоо ч түүний тухай *ярьж бай*” (Дэд Хууль 6:5–7; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн).

Би үүн дээр: “Ширээний ард хамт сууж хооллож байхдаа ч” хэмээн нэмж хэлмээр байна.

Хэрэв бид гэр бүлээрээ үүрд хамт байхыг хүсдэг бол энэхүү үйл явцыг өнөөдөр эхлэх хэрэгтэй. Хүүхдүүдтэйгээ ярилцаж цагийг хамт өнгөрүүлэх нь мөнх амьдрал өөд хамтдаа мацах замд үүрдийн гэр бүлдээ оруулж байгаа хөрөнгө оруулалт юм.

АНУ-ын Иллиной мужийн нэгэн ээж хүүхдүүдтэйгээ ярилцах цаг яаж гаргадаг тухайгаа ийн хуваалцжээ:

“Би хүүхдүүдээ бага байхад дурлан үздэг зурагтын хэдэн хөтөлбөртэй болсон байлаа. . . . Харамсалтай нь, тэдгээр хөтөлбөр хүүхдүүдийн унтах цагтай давхцана.

“ . . . Нэг удаа би өөрийн үздэг зурагтын хөтөлбөрүүдийг жагсаалтын эхэнд, харин хүүхдүүдээ бүр ард нь тавьснаа мэдэв.



Зурагтаа асаагаад нэгэн зэрэг унтахын өмнөх түүхүүдийг хүүхдүүдээ уншиж өгөхийг хэсэг хугацаанд хичээсэн ч, энэ нь сайн арга биш гэдгийг би зүрх сэтгэлдээ мэдэж байлаа. Энэ тухай хэдэн өдөр, долоо хоног тунгаан бодоод зурагт үзэх зуршлаа орхисон. Би гэм буруутайгаа мэдэрч, залруулахаар шийдэв. Эргэлзээгүйгээр зурагтаа унтраадаг болтол бас ч багагүй хугацаа өнгөрсөн.

Зурагтын хөтөлбөрүүдээ үзэхээ больсноос хойш хоёр долоо хоног орчмын дараа сэтгэлийн дарамт яагаад ч юм хөнгөрснийг мэдрэв. Санаа сэтгэл сайхан болж, бүр илүү цэвэр ариун болсноо мэдрэв. Ийнхүү зөв сонголт хийснээ мэдсэн юм.”²

Унтахын өмнөх цаг бол ярилцах хамгийн тохиромжтой цаг.

Хиламан залуу дайчдын тухай ийн хэлсэн юм. “Тэд эхчүүдийнхээ үгсийг надад давтаж хэлсэн нь: Эхчүүд маань үүнийг

мэдэж байсан гэдэгт бид эргэлзэхгүй байна” (Алма 56:48).

Энэ бол “эхчүүдийнх нь тэдэнд заасан үгс” байлаа. Тэр эхчүүд хүүхдүүдтэйгээ ярилцахдаа Бурханы үгийг заадаг байжээ.

Хувийн харилцаа, хэлхээ холбоогоо хадгалах нь

Ярилцахын ашиг тус их юм. Дайсан үгийн хүчийг мэддэг. Бид гэр орондоо харилцан ярилцаж, сонсон, бие биедээ урам хайрлаж, юмсыг хамтран хийхэд ирдэг сүнсийг бууруулахыг Сатан хичээдэг.

Иосеф Смит, Бурхан Эцэг болон Түүний Хүү Есүс Христ нарын хооронд болсон шийдвэрлэгч ач холбогдолтой яриаг Сатан зогсоохыг хичээн, энэ эрин үе дэх Есүс Христийн сайн мэдээний Сэргээлтэд саад учруулахыг оролдсон нь бүтэлгүй болсон билээ.



Энэ тухай Иосеф Смит өгүүлсэн нь, “Тэр даруй намайг бүхэлд нь эзэмдсэн ямар нэг хүчээр би баригдан, мөн ярьж чадахгүй боллоо хэл минь гацаж, ийм нэгэн гайхалтай нөлөөлөлд автав” (Иосеф Смит—Түүх 1:15).

Бид нүүр тулан, зүрх сэтгэлийнхээ бодол санааг үг яриагаар илэрхийлэхэд дайсан ямар нэг зүйлээр саад учруулахыг, тухайлбал бидний хэлийг гацаахаар чармайх болно. Тэр холын зай, анхаарал сарниулах зүйлс, чимээ шуугиан, хөндий хүйтэн харилцаа зэрэг ямар нэг зүйлээр, нүүр тулан ярилцахаас ирдэг элэгсэг халуун, чин сэтгэлийн яриа хөөрөө, хүмүүний ийм мэдрэмжид саад учруулахдаа баяртай байдаг.

Хүүхдийнхээ зүрх сэтгэлийн үгсийг сонсох нь

Сонсох нь ярихтай адил чухал. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Жеффри Р.Холланд сургасан нь: “Хэрэв бид хайраар сонсвол, юу ярих билээ гэж бодох хэрэггүй. Энэ нь бидэнд. . . Сүнсээр өгөгдөх болно.”³

Бид бусдын үгийг сонссоноор тэдний бодол санааг ойлгодог. Хүүхэд нэг бүрдээ зориулсан төлөвлөгөө Тэнгэрлэг Эцэгт бий.

Бид өөрийнхөө хүүхэд нэг бүрд зориулсан төлөвлөгөөг харж чадвал юу болохыг төсөөлөн бодоод үз дээ. Бид тэдний сүнслэг бэлгүүдийг хэрхэн өргөжүүлэхийг мэдэж болох уу? Хэрэв бид хүүхдийнхээ авьяас чадварыг мэдэж, хэрхэн хөгжүүлэхийг мэдвэл юу болох бол? Хүүхэд насны итгэлээ гэрчлэл болгоход нь хүүхдүүдэд туслахын тулд бид яах ёстой вэ?

Бид хэрхэн мэдэж чадах вэ?

Бид бусдын үгийг сонсоноор тэдний санаа бодлыг мэдэж чадна.

Хожмын Үеийн Гэгээнтэн нэг эцэг ингэж хэлжээ: “Хүүхдүүдтэйгээ ярилцахаас илүүгээр тэднийг сонссоноор би олон сайн зүйлийг хийж чаддаг. . . . Хүүхдүүд маань бэлэн эзлэн юмыг хүсдэггүй, харин олон жилийн явцад нотлогдох, ухаалаг хариулт хүсдэгийг би аажмаар ойлгосон. . . . Асуух гэсэн зүйлээ асууж чаддаг байх, өөрсдийнхөө асуудлын талаар ярилцах нь миний бэлэн хариултыг хүлээж авахаас тэдэнд илүү чухал юм. Хүүхдүүд ярилцлагад анхааралтай оролцсон үед, би тэднийг хангалттай удаан хугацаагаар сонсох юм бол, миний бэлэн хариулт тэдэнд үнэхээр хэрэггүй. Тэд хариугаа аль хэдийн олчихсон байдаг.”⁴

Хамгийн чухал асуудлуудад анхаарал төвлөрүүлэхэд цаг хугацаа шаарддаг даг. Ярилцах, сонсох, урам хайрлах нь түргэн үйл явц биш. Дээрх үйл явцыг яаруу сандруу буюу хуваарь гарган хийж болохгүй, тэдгээр нь явц дундаа аяндаа сайжирдаг. Ямар нэг зүйлийг хамтран хийж үр дүнг нь үзэх, хамт ажиллах, тоглох үед ярилцах, бие биеэ сонсох *боломж гардаг*. Зурагтаа унтрааж, анхаарал сарниулах дэлхийн зүйлсийг хойш тавин, бие биедээ анхаарал төвлөрүүлсэн үед ийм боломж гардаг.

Ярилцах, бие биеэ сонсох нь амаргүй зүйл. Бид зурагтаа унтрааж, дэлхийн зүйлсийг хойш тавьсны дараа болох зүйлд бэлтгэлтэй байх ёстой. Эхлээд нам гүм болоход тийм ч таатай биш, эвгүй мэдрэмж төрж болно. Тэвчээртэй байж, хэдэн хором хүлээгээд, хөгжилтэй эхэл. Дэргэдээ байгаа хүмүүст бүх анхаарлаа төвлөрүүлж, тэдний талаар нэг асуулт асуугаад, сонсож эхэл. Эцэг эхчүүд ээ, хүүхдийнхээ сонирхдог зүйлийн тухай ярилцаж бай. Өнгөрсөн зүйлийн

тухайд инээж, ирээдүйгээ мөрөөд. Энгийн яриа чухал ярилцлага болон өрнөж болно.

Мөнхийн зорилгоо эн тэргүүнд тавих нь

Өнгөрсөн хавар намайг залуу эмэгтэйчүүдийн хичээлд сууж байтал, эн тэргүүнд анхаардаг 10 зүйлээ жагсаан бичихийг багш ангийнхнаас хүсэв. Би түргэн бичиж эхэллээ. Би түр бодсоноо, “Номер 1: гал тогооны өрөөн дэх үзэг харандааны шургуулгаа цэвэрлэх” гэж бичив. Жагсаалт дуусахад бичсэн зүйлээ хуваалцахыг Залуу Эмэгтэйчүүдийн Удирдагч биднээс хүслээ. Саяхан 12 хүрсэн Абби миний дэргэд сууж байлаа. Аббигийн жагсаалтыг сонирхье:

1. Коллежид сурах.
2. Дотоод засал чимэглэлийн дизайнч болох.
3. Энэтхэгт номлогчоор явах.
4. Ариун сүмд буцаж ирсэн номлогчтой гэрлэх.
5. Гэр оронтой, таван хүүхэдтэй болох.
6. Хүүхдүүдээ номлолд явуулж, коллежид суралцуулах.
7. Ач зээ нартаа “жигнэмэг өгдөг,”
8. тэднийг эрхлүүлдэг эмээ болох.
9. Сайн мэдээний тухай улам ихийг мэдэж, амьдралын баяр баясгаланг эдлэх.
10. Тэнгэр дэх Эцэгтэйгээ хамт амьдрахаар эргэж очих.

“Баярлалаа, Абби. Бид бүгдэд зориулсан төлөвлөгөө Тэнгэрлэг Эцэгт байдаг тухай үзэгдэл харснаа чи бидэнд заалаа. Явах замаа мэдэж байгаа болохоор ямар ч саад тотгор тохиолдоход чи алзахгүй. Явах зам чинь өргөмжлөл болон Тэнгэрлэг Эцэгтээ буцаж очих эцсийн зорилго дээр төвлөрч байгаа болохоор чи тэнд очно” гэж би хэллээ.

Мөнхийн зорилгын тухай ийм санаа болдол Аббид хаанаас бий болсон юм бол? Энэ нь бидний гэр орноос эхэлдэг. Ийм мэдэрэмж манай гэр бүлүүдэд эхлэн бий болдог. “Гэр бүлдээ эн тэргүүнд анхаарах зүйлсийг бий болгох талаар юу хийдэг вэ?” гэж би түүнээс асуув.

“Бид судар уншихын зэрэгцээ *Миний Сайн мэдээг номло* удирдамжийг судалж байгаа” гэж тэр хариулаад, “Бид гэр бүлийн үдшээрээ, хамт хооллох үеэр, бас

машинаар явж байхдаа машин дотроо олон зүйлийн талаар ярилцдаг” гэж нэмж хэллээ.

Нифай ийн бичжээ: “Бид Христийн тухай ярьж, бид Христэд баясч, бид Христийн талаар номлодог.” Яагаад? “Бидний хүүхдүүд нүглээс ангижрахын тулд ямар сурвалжийг хайж болохыг мэдэж болохын тулд” (2 Нифай 25:26) юм.

Гэр бүлээрээ хамтран ярилцаж, бие биенийхээ үгийг сонсон, харилцан урам хайрлаж, юмсыг хамтран хийх нь биднийг Аврагчид улам ойртуулна. Тэр бидэнд хайртай. Өнөө үед гэр бүлийн гишүүдтэйгээ зориуд цаг гарган ярилцаж, тэднийг сонсож байх нь манай гэр бүлүүдийг мөнхөд адислах болно. Бид Христийн тухай ярилцснаар бас Христ дотор болон Цагаатгалын бэлгэнд баясдаг билээ. Хүүхдүүд маань “нүглийнхээ уучлалын ямар эх сурвалжийг хайхаа” мэддэг болно. ■

2010 оны аравдугаар сарын 24-нд хиймэл дагуулаар нэвтрүүлсэн гадасны чуулган дээр Солт Лейк хотод хэлсэн үгнээс.

ЭШЛЭЛ

1. Жеймс И.Фауст, “Enriching Family Life,” *Ensign*, 1983 оны 5-р сар, 41.
2. Сюзан Хетон, “Talk Time Instead of TV Time,” *Ensign*, 1998 оны 10-р сар, 73.
3. Жеффри Р.Холланд, “Witnesses unto Me,” *Луахона*, 2001 оны 7-р сар, 16.
4. Жорж Д.Дуррант, “Pointers for Parents: Take Time to Talk,” *Ensign*, 1973 оны 4-р сар, 24.



НЭРС ЖИМС БА МОРМОНЫ НОМ

Хэдэн жилийн өмнө манайх түм түжигнэж, бум бужигнасан, их хөлийн том хотоос нэгэн жижигхэн тосгоны зах дахь хөдөөгийн бяцхан эдлэн газартаа нүүж ирсэн юм. Манай ойролцоо арвин их нэрс ургадаг нэг ферм байлаа. Бид эзнийх нь найз нараар дамжуулан хүссэн л хэмжээгээрээ нэрс хурааж авах зөвшөөрөл олж авлаа.

Бид тэр зун долоо хоног бүрийн хэдэн өглөө машин дүүрэн хувин, шуудай авч очоод, нэрс түүж цагийг

тун сайхан өнгөрөөдөг байж билээ. Нэг өглөө манай отгон хүү Хайрам бидэнтэй хамт явах дургүй байгаа юм шиг харагдав. Бид нэг ч нэрс хаялгүй бүгдийг түүсэн болохоор тийшээ дахин явах нь цагийн гарз гэж түүнд санагдсан гэнэ. Хэчнээн олон нэрс үлдчихсэнийг тэр мэдээд гайхахын ихээр гайхаж билээ. Түүний ажиглаагүй өнгөрсөн олон газарт багсайсан нэрс бөөн бөөнөөрөө байв. Бас өмнө нь түүний түүсэн мөчрүүд дээр хүртэл хамгийн

их шүүслэг нэрс хэсэг хэсгээрээ үлдсэн байлаа.

Яг тэр үед тойргийн залуучуудын удирдагчид сургуулийн хичээл эхлэхээс өмнө Мормоны Номыг наймдугаар сард уншиж дуусгах даалгаврыг өсвөр насныханд өгсөн байлаа. Хүүхдүүд маань даалгаврыг гэртээ авчирсан болохоор насанд хүрэгчид бид тэдэнтэй нэгдэхээр шийдэв.

Мормоны Номыг тэр жилийн эцэс гэхэд уншиж дуусгасан байх тухай

Бид нэрсийг ганцныг ч үлдээлгүй түүсэн болохоор ферм уруу дахин явах нь цагийн гарз гэж Хайрам бодсон ажээ.



Ерөнхийлөгч Гордон Б.Хинклийн (1910–2008) даалгавартай *Ensign* сэтгүүл наймдугаар сарын 25-нд ирэхэд бид Мормоны Номоо уншиж дуусгаад байлаа. Бид бошиглогчийн үгийг аль хэдийн дуулгавартай дагасан шүү дээ гэж Хайрам, Жозеф ах дүү хоёр гайхсан гэнэ. Тэгэхэд нь Ерөнхийлөгч Хинкли биднийг энэ номыг өмнө нь хэчнээн ч удаа уншсан байх амаагүй дахин уншихыг хүссэн байна шүү дээ гэж Сет, Бетани хоёр ах нь тэдэнд сануулсан аж.

“Яагаад тэгсэн юм бол?” гэж хөвгүүд асуулаа. “Бид үг бүрийг гээлгүй уншсан. Бидний уншсан зүйлээс өөр мэдэх ёстой юу тэнд байдаг юм бол?”

Хэдэн хором дуугүй байсны дараа хэн нэг нь нэрсний тухай дурдав. “Бид нэрсийг ганцыг ч орхилгүй бүгдийг түүсэн гэж бодож байсныг санаж байна уу? Гэтэл буцаад очиход зөндөө нэрс үлдсэн байсан биз дээ! Бид олон удаа, бүр саяхан очсон ч, нэрс дандаа л бөөн бөөнөөрөө байсан шүү дээ.”

Энэ хоёр зүйл хоорондоо ямар холбоотой болохыг бид түргэн ойлголоо. Ойролцоох ферм болон түүний сайхан амттай нэрс, Мормоны Ном хоёр үнэнийг шинээр нээх сүнсний тэжээлийн байнгын эх сурвалж юм. Тиймээс бид Мормоны Номыг дахин уншиж эхлэв.

Би бошиглогчийн даалгаврыг аваад Мормоны Номноос өмнө нь олон удаа уншсан зүйлсийг уншсан. Гэхдээ тэдгээрийг шинэ өнцгөөс харж, шинэ нөхцөл байдал, шинэ сорилтын үед хэрхэн хэрэглэхийг ойлгосон. Мормоны Номыг чин сэтгэлээсээ унших бүрд олон шинэ ойлголттой болж, Аврагчид улам ойртоогийг би мэднэ. ■
Сюллен С.Вейлер, Жоржи, АНУ

БИ НОМЛОЛД ЯВАХ ЁСТОЙГОО МЭДЭРСЭН

Намайг Аргентины Буэнос Айрест баптисм хүртсэнээс хойш хоёр жил зургаан сарын дараа, надад заасан ахлагч нарын нэгнийх нь: “Та бол номлогч гэдгийг би мэднэ” гэж хэлсэн үгс одоо хүртэл миний чихэнд сонсогдсоор байх шиг санагддаг. Зүрх сэтгэлд минь шингэсэн энэхүү мэдрэмж үнэн эсэхийг мэдэхээр залбираад хариут нь хүчтэй мэдэрснээ би бас санадаг. Би 20-тойдоо номлолд бэлтгэх ёстойгоо мэдсэн.

Гэвч яаж номлогч болох вэ? Надад сайн мэдээг заасан тэнгэр элч шиг тэр залуу эрчүүдтэй би огтхон ч адилгүй шүү дээ. Бас ажлаа яаж орхих юм бэ? Гэртээ эргэж ирсний дараа хаана амьдрах юм бэ? Хүний байшингийн мухрын нэг жижиг өрөө олж, толгой хоргодох гэж хэчнээн зовлоо доо.

Нэг орой гэр уруугаа харьж явтал нөгөөх мэдрэмж, нөгөөх эргэлзээ толгойд дахин орж ирлээ. Гэртээ ирээд шийдвэр гаргая гэж бодоод, тусламж хүсч өвдөг сөгдөн залбирав. Уйтгар гунигт автсан үед хүч чадал өгдөг найз Леандротойгоо уулзах хэрэгтэй гэсэн хүчтэй мэдрэмж залбирч дуусахад надад төрлөө.

Гэвч шөнө дунд түүнийг сэрээх нь эвгүй байв. Би түүнийг ажилдаа явахаар эрт босдогийг мэдэх учраас тэр үед хаалгыг нь тогшихыг хүссэнгүй. Яах вэ гэж эргэлзсэн ч, түүнтэй уулзах ёстой гэсэн мэдрэмж санаанаас гарахгүй байлаа. Түүнтэй уулзах уу, яах вэ гэж эргэлзэн ацан шалаанд ороод байлаа.

Тэгээд юу ч гэсэн орон сууцны хорооллын хавиар салхинд жаахан

Гэртээ ортол Леандро миний өрөөнд сууж байх нь тэр. Сүнс надад хүчтэй мэдрэгдэж, амьсгал давчдах шиг болов.

алхъя гэж шийдэв. Гэтэл хаалгаа онгорхой орхисноо санаад гэр уруугаа буцлаа. Гэртээ ортол Леандро миний өрөөнд сууж байх нь тэр. Сүнс хүчтэй мэдрэгдэж, амьсгал давчдан, сэтгэл доголсноос амьсгаагаа дарж ядан, “Чи энд юугаа хийж байгаа юм бэ?” гэж би түүнээс асуулаа.

“Мэдэхгүй ээ. Чамтай уулзмаар санагдаад байхаар нь хүрээд ирлээ” гэж найз маань хэлэв.

Номлолын талаарх эргэлзээгээ би түүнд ярихад тэр гэрчлэлээ хуваалцаж, надад урам хайрлав. Тэгээд номлолын өргөдлөө бөглөхөд надад туслав. Би маргааш өглөө нь өргөдлөө бишопт аваачиж өглөө. Хоёр сарын дараа Аргентины Салта номлолд үйлчлэх дуудлагаа хүлээж авлаа.

Тэр шөнө миний найз Их Эзний мутарт зэмсэг болсныг би мэднэ. Чин сэтгэлээсээ, үнэн санаа бодолтойгоор хэлсэн залбирлыг Тэнгэрлэг Эцэг сонсож, хариулдгийг би мэднэ. ■
Альдо Фабио Морака, Невада, АНУ

БИ ҮХЭХ НЬ ЭЭ!

Би мэс заслын дараах эрчимт эмчилгээний тасгийн сувилагчаар амсхийх завгүй ажиллаж байхдаа саяхан мэс засал хийлгэсэн Билл гэгч өвчтөний талаар нэг хүн надтай утсаар ярьж билээ. Түүнийг сэхээн амьдруулах тасагт хэвтүүлэх ёстой байсан ч тэр тасаг дүүрэн хүнтэй байсан учир манай тасагт шилжүүлсэн юм.

Өвчтөн удаалгүй гэр бүлтэйгээ ирлээ. Тэр санаа нь зовсон, бие нь ямар байгаа болон хаана ирснээ сайн мэдсэн янзтай, сэтгэлээр унасан шинж царайд нь харагдахгүй байсанд би тайвширлаа.

Зүрхнийх нь цохилт, цусны даралт, биеийн халууныг үзэж, энэ тухай өөрт нь болон гэрийнхэнд нь хэлсний дараа би өвчний түүхэнд тэмдэглэл хийхээр өрөөндөө

орлоо. Үзгээ цаасанд дөнгөж хүргэнгүүд “Өвчтөний өрөө уруу буцаад яв” гэж хэлэхийг сонсоод, бичихээ больж, эргэж харав. Хэн ч байсангүй. Тэгж хэлэх шиг санагдсан юм байх даа гэж бодтол хоёр дахь удаагаа нөгөөх үгсийг чангаар хэлэхийг гэнэт сонслоо.

Биллийн өрөөнд буцаад гүйж ортол хүзүү нь хоёр дахин том болчихсон, хүндээр амьсгаадаж байв. Гүрээнийх нь артерийн судас хагарсан юм болов уу гэж бодоод баруун гараараа хүзүүн дээр нь дарж, зүүн гараараа мэс засал хийсэн эмч рүү нь утасдлаа. Билл уруу мэс засалч эмч нарын багийг аль болох түргэн явуулна. “Харин гараа авч болохгүй шүү!” гэж мэс заслын эмч хэллээ.

Би Биллийн хүзүүн дээр дарж байхдаа орных нь дэргэд Сүмийн нэг танил ном байхыг ажиглав. “Та

Сүмийн гишүүн үү?” гэж би асуув.

Тэр толгойгоо дохих гэж оролдсоноо Атлантын Жорж Ариун сүмийн ёслолын ажилтан гэдгээ хэллээ. Тэр нулимсаа барьж ядан, “Би үхэх нь ээ!” гэв.

Та үхэхгүй ээ гэж би өчүүхэн ч эргэлзээгүйгээр хэлээд, “Би ирэх сард Атлантын Ариун сүмд гэрлэнэ. Тэгэхэд та тэнд байгаарай” гэв. Тэгтэл мэс засалч эмч нарын баг ирж, Биллийг аваад явав.

Би ирэх сард болох хуримандаа сэтгэл догдлоод, эмчилгээ нь хүндэрсэн Биллийг бараг мартчихаад байлаа. Гэвч хуримын өдөр ариун сүмийн ерөнхийлөгчийн гэргий намайг лацдан холболтын өрөөнд дагуулж ороход нэг танил царай харагдсан нь Биллийн эхнэр Жорж байлаа. Би түүнд гэрлэх гэж байгаагаа хэлтэл тэр Биллийг олж ирэхээр гарав. Ёслол эхлэхээс хэдхэн хормын өмнө хаалга нээгдэж, Билл орж ирлээ. Билл хэдэн долоо хоног толгой нь өвдөж, огиулан, сульдан тамирдсаны эцэст бие нь илааршиж, тэр өдөр миний хуримын өдөр гэдгийг мэдэлгүйгээр ариун сүм дээр ирсэн гэнэ.

Хоёр жилийн дараа нөхөр бид хоёр Тенниссийн Нашвилл ариун сүмд ёслолын ажилтнаар дуудагдав. Бид хоёр онцгойлон адислагдахаар ариун сүм дээр иртэл нэг эрэгтэй хүн надад хаалга нээж өгөөд, “Нашвиллын ариун сүмд тавтай морилно уу!” гэв. Энэ бол Билл ах байлаа.

Бид хамт гурван жил үйлчилсэн. Намайг амийг нь аварсан хэмээн Билл хүн болгонд ярьдаг байлаа. Гэвч Их Эзэн түүнийг аварсныг би мэднэ. Сүнсний өдөөлтөнд анхаарал тавихын чухлыг Их Эзэн тэр үйл явдлаар надад заасан юм. ■

Рамона Росс, Теннессий, АНУ

“Билл уруу эмч нарын багийг аль болох түргэн явуулна. Харин гараа авч болохгүй шүү!” гэж мэс засалч эмч хэллээ.



ЗАЛБИРААД ҮЗВЭЛ ЯАСАН ЮМ БЭ?

1975 оны хавар би гэр бүлийнхээ хамт Баруун Германы Рейнланд-Пфалз нутагт, үзэсгэлэнт ногоон ферм дээр амьдарч байлаа. Бид бороотой нэг ням гарагт сүмээс гэртээ ирэх замдаа ойн захад замын нойтон ховилд онхолдсон машиныг харахаар зогсов. Моддын орой бараг дээвэр шиг шигүүгээс гадна үдшийн бүрий болж байсан болохоор ой дотор харанхуй байлаа.

Бид эвдэрсэн машиныг хараад, машин уруугаа эргэж иртэл, манай машин шаварт шигдчихсэн байв. Ухарч болсонгүй, харин ой уруу урагшаа хөдлөв. Бид өмнө нь ой дундуур явдаг байлаа. Ой дотор олон зам байдаг болохоор эцэстээ буцаж болох байх гэж бодоод харанхуй ой уруу урагш хөдөллөө.

Буруу шийдвэр гаргаснаа тэр дорхноо ойлгов. Олон машины дугуйны хээ гарсан нарийхан, нойтон шавартай зам харанхуй ой уруу улам цаашаа хөтөлнө. Зогсвол шаварт суучихна гэж айгаад хурдаа хассангүй. Машины дугуй шигдчихээргүй хэсэгхэн хатуу, өндөрлөг газар өмнөө байхыг олж харлаа. Машинаа шавраас гаргаад, яахаа бодъё гэж шийдэв. Машин ухасхийж, шавраас гарахад

машинаа унтраагаад гадагшаа гарлаа. Холын гэрлээ тавихгүй бол юу ч харагдахгүй байв. Холын гэрлээ асаагаад, гар чийдэн авч, урдах замаа сайн харлаа. Эргээд ой уруу орж, ирсэн замаараа хурдхан буцах нь л өлзийтэй болохыг ойлгов.



Холын гэрлээ асаагаад, гар чийдэн авч, урдах замаа сайн харлаа. Эргээд ой уруу орж, ирсэн замаараа хурдхан буцах нь л өлзийтэй болохыг ойлгов.

Ой уруу нэлээд лавхан орох үед, мотор жигд хүнгэнэн, ирсэн замдаа орж давхитал, шаварт гүнзгий суучихав. Бид ингээд яах ч аргагүй болох нь тэр. Гадаа тас харанхуй, нам гүм байв. Эхнэр бид хоёр айж сандарсан гурван хүүхэдтэйгээ машиндаа сууж байлаа.

Одоо яах вэ гэж эхнэрээсээ асуув. Тэр хоромхон зуур бодсоноо, “Залбираад үзвэл яасан юм бэ?” гэв. Хүүхдүүд тэр дороо тайвшрав. Би тусламж хүсч даруухнаар, чин сэтгэлээсээ залбирлаа. Залбирч байх үед: “Дугуйгаа гинжээр орооё” гэсэн бодол толгойд орж ирлээ.

Намайг хойд талын дугуйгаа

улаан нүцгэн гараараа цэвэрлэн, гинжээр орооход хайрт хань минь 25 см зузаан шавар дотор ням гарагийн хувцастайгаа гар чийдэн барин зогсож байлаа. Бид итгэлтэйгээр дахин залбирч, машинаа асаагаад, шавар дундуур зөөлхөн явсаар явган хүний зам дээр гарч ирлээ.

Би шавар, харанхуй хоёроос чөлөөлөгдсөндөө баярлаад, харанхуй ойгоос гарахад хэн бидэнд тусалсныг бараг мартчихсан байлаа. Манай таван настай охин, “Аав аа, Тэнгэрлэг Эцэг үнэхээр залбиралд хариулдаг, тийм биз дээ?” гэж надад сануулж билээ. ■

Скотт Эдгар, Юта, АНУ

Хүн болгон Блекийг танина

Адам К.Өүлсон

Сүмийн сэтгүүлүүд

Хоноура “Блек” Бонет-д сагсан бөмбөг-нөөс өөр бодох юм байдаггүй гэхэд болно. Блек 15-тай байхдаа Францын Полинезид энэ орны насанд хүрэгчдийн хамгийн шилдэг багийн хамгийн шилдэг, өсч яваа тоглогчдын нэг болон тодорчээ. Хэдийгээр түүний хоч нь *блэк (black-хар)* гэсэн англи үгийн алдаатай бичлэг ч түүний гоц авьяасанд ямар ч алдаа байхгүй.

Гэвч тэр илүү ихийг, тухайлбал Европт мэргэжлийн сагсан бөмбөг тоглохыг хүсдэг байв. Түүгээр ч зогсохгүй Өмнөд Номхон Далайн Тоглолтоос алтан медаль авахыг хүсдэг байсан гэнэ.

Хоноура “Блек,”
Миранда Боннет хоёр
Тахитид олон жилийн
турш сагсан бөмбөг
тоглож байгаа ажээ.

Амжилтанд хүрэх замд нь зөвхөн Сүм л саад болж байгаа мэт түүнд санагддаг байж.

Номлолд үйлчилсэн нь

Тэр үед түүний тоглодог багийг Сүм ивээн тэтгэдэг байсан ч, Блек Сүм эсвэл номлолд үйлчлэх чадвартай, зохистой залуу эрэгтэй бүрт зориулсан бошиглогчийн дуудлагыг бараг сонирхдоггүй байлаа.

Тэр номлолд явахгүй гэдгээ бишоптоо хэлсэн гэнэ. Хэрэв тэр бүтэн хоёр жилийг алдах юм бол, яаж мэргэжлийн сагсан бөмбөг тоглох юм бэ?

Хамгийн гол нь, Өмнөд Номхон Далайн Тоглолт дөрвөн жил тутам буюу түүнийг номлолд үйлчилж байх үеэр болох нь байна шүү дээ. Бас Тахитийн Сагсан Бөмбөгийн Холбоо үндэсний шигшээ багт түүнийг тоглуулах сонирхолтой байгаа. Блекийг биеэ тоож эхлэх бүрд: “Хүн болгон Блекийг танина, гэвч тэр алтан медаль аваагүй л байна” хэмээн аавынхаа хэлдэг үгэнд цэг тавих боломж эцэстээ түүнд тохиожээ.

Блекийн аав Жин Баптите дээрх үгийг аятайхан байдлаар хэлдэг байв. Гэвч энэ үг Блекийг галууруулах шахдаг аж. Аавынх нь энэ үг Тахитийн бүх сагсан бөмбөгийн хорхойтнууд түүнийг мэддэг ч, Блек тэмцээнээс медаль аваагүй байгааг түүнд сануулсан аж. Харин аав нь Өмнөд Номхон Далайн Анхны Тоглолтоос эрэгтэйчүүдийн багийн бүрэлдэхүүнд тоглож, алтан медаль авсан ажээ.

Аавынх нь үг буруу гэдгийг нотлох нь Блекийн зорилго байв. Өөр зүйлд зориулах цаг түүнд байсангүй.





*Сагсан бөмбөг
Блекийн дур-
тай зүйл бөгөөд
сорилт, адислалыг
хоёуланг нь түүнд
авчирчээ.*



“Их Эзэн таныг ямар байдлаар амьдрахыг хүсдэг вэ, тийм байдлаар амьдарснаас аз жаргал ирдэг.”

Ерөнхийлөгч
Томас С.Монсон,
“Preparation Brings Blessings,” *Лиакхона*,
2010 оны 5-р сар, 67.

Санаа бодол өөрчлөгдөхөд зүрх сэтгэл өөрчлөгдөнө

Блек номлолын тухай боддоггүй ч Сүмийн үйл ажиллагаануудад оролцсоор байлаа. Блек 16-тай байхдаа Сүм дээр болсон бүжгийн үеэр Миранда Маритеражийг бүжгэнд урихаар зориглосон гэнэ. Миранда бол мөн л алтан медаль авахыг мөрөөддөг, сагсан бөмбөг сайн тоглогч байлаа. Аав нь бас л анхны алтан медаль авсан багийн бүрэлдэхүүнд тоглосон ажээ.

Блек түүнийг бүжгэнд урьснаас хойш хэдхэн хором болоод хөгжим нь зогсчихож. Тиймээс тэд дараагийн хөгжим эхлэхэд бүжиглэв. Энэ нь тэр оройн сүүлчийн бүжиг байжээ. Гэвч Блек бүжиг дуусахыг хүссэнгүй.

Блек ариун сүмд гэрлэх, тэр тусмаа ариун сүмд гэрлэхийг хүсдэг гишүүнтэй гэрлэх бодолгүй байлаа. Гэвч тэр дараагийн хоёр жил Мирандатай бүр сайн танилцсан үед дээрх бодол нь өөрчлөгдөж эхлэв. Нэг өдөр Залуу Эмэгтэйчүүдэд зориулан Мирандагийн гэртээ хийсэн нэг зүйл Блекийн анхаарлыг татсан гэнэ. Энэ нь “Би ариун сүмд гэрлэнэ” гэсэн үгс байлаа.

Миранда болон ариун сүмд гэрлэх түүний эргэлтгүй шийдвэр сонирхлыг нь татсан учир Блек бодол санаагаа эргэн харахад хүрсэн ажээ. Тэрээр Сүмд буурь суурьтай хандахаар шийдсэн гэнэ. Түүний энэ шийдвэр амьдралд нь оролцох боломжийг Ариун Сүнсэнд олгосон үйл ажиллагаа уруу хөтөлжээ.

Шийдвэр гаргасан нь

18 насандаа патриархын адислал авахаар бэлтгэх нь түүний гаргасан шийдвэрүүдийн нэг байлаа. Патриарх Блекийг номлолд үйлчилж, ариун сүмд гэрлэх болно гэсэн үгсээр адислалаа эхлэхэд тэрээр Сүнсийг мэдэрчээ. “Энэ бол Бурхан надаар хийлгэхийг хүсч байгаа зүйл мөн гэдгийг би мэдсэн” гэж тэр хэллээ.

Үндэсний шигшээ баг медаль авах боломжтой байсан ч Блек гэр бүлийнхээ дэмжлэгтэйгээр Бурханы хүсдэг зүйлийг өөрийнхөө хүсдэг зүйлийн түрүүнд тавихаар шийджээ. Ийм шийдвэр гаргах нь амаргүй байлаа. Шигшээ багт тоглооч гэсэн шахалт хүчтэй байлаа. Бурханы хүсэлд захирагдах түүний шийдвэр нэг бус удаа соригдоно гэдгийг Блек удалгүй ойлгов.

Түүнийг Тахитид нэг жил номлогчоор үйлчилсний дараа Сагсан Бөмбөгийн Холбоо ердөө ганцхан сарын хугацаагаар шигшээ багтаа эргэн ирж, тоглооч гэж гуйжээ.

Блекийн номлолын ерөнхийлөгч, тоглолын дараа эргэн ирж, номлолдоо үйлчлэх нь боломжгүйг ойлгоод, санаа нь зовон, “Хэрэв чи хүсвэл явж болно, харин буцаж ирээд номлолоо үргэлжлүүлнэ гэж байхгүй” гэв.

Блек медаль авахыг хүсч байсан ч, энэ нь бусад бүх зүйлээс илүү гэж бодохоо нэгэнт больжээ. Номлол нь гайхалтай сайхан байлаа. Сагсан бөмбөг тоглох гэж номлолын сүүлчийн жилээ орхихыг хүссэнгүй, үйлчлэлээ үргэлжлүүлэв.

Баг нь алтан медаль авчээ.

Өөр нэг чухал шийдвэр

Блек номлолоо хүндэтгэлтэйгээр дуусгасны дараа Тахитийн Папийте Ариун сүмд Мирандатай гэрлэж, гал голомтоо бадраасан ажээ. Тэр бас үндэсний шигшээ багт тоглохсон гэж бодно.

Миранда Эмэгтэйчүүдийн Үндэсний Шигшээ Багийн гол хамгаалагч болж, Өмнөд Номхон Далайн тоглолтонд бэлтгэж байлаа.

Гэвч тоглолт ойртох тусам гэр бүлийн энэ хос хоёр дахь үрийнхээ зулайг үнэрлэх нь гэдгийг хүчтэй мэдэрч эхэлсэн гэнэ.

Тоглолт болоход жил шахам хугацаа байгаа болохоор Миранда хүүхдээ төрүүлэхээс нэлээд өмнө тоглолтод оролцож болохоор байв. Эмэгтэйчүүдийн баг медаль авах магадлал өндөр байлаа.

Гэвч гэр бүлийн энэ хос өөрсдийн хүслийг Бурханд захируулах нь хувийн ашиг сонирхлоо эрхэмлэснээс илүү их адислал авчирдгийг амьдралаас мэджээ.





Тэд анхааралтай судалж үзэн, залбирсны дараа гэр бүлээ эн тэргүүнд тавихаар шийдсэн гэнэ.

1999 онд Мирандаг найман сартай жирэмсэн байхад эмэгтэйчүүдийн баг алтан медаль авчээ.

Хүн болгон Блекийг танина

Блек Миранда хоёр өнгөрсөн арван жилийн турш Францын Полизид сагсан бөмбөгийг өндөр төвшинд тоглож, үндэсний аварга шалгаруулах болон цомын тэмцээнүүдэд түрүүлж, 2003, 2007 оны тоглолтуудад үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүнд тогложээ.

2011 оны тоглолтуудад хоёул оролцсон бөгөөд Блек энэ удаа эрэгтэйчүүдийн багийн дасгалжуулагчаар ажиллажээ. Миранда болон эмэгтэйчүүдийн баг алтан медаль авсан бол эрэгтэйчүүдийн баг хүрэл медаль авч, алтан медаль авах гэсэн Блекийн мөрөөдөл биелэгдсэнгүй.

Хэрэв Блек Бурханы хүслийн оронд өөрийнхөө хүслийг биелүүлэхээр зүтгэсэн бол амьдрал нь ямар байх байсан бол гэж заримдаа боддог ажээ.

“Би алтан медаль авсан байж магадгүй.

Мэргэжлийн сагсан бөмбөг тоглосон байж магадгүй, үгүй ч байж магадгүй” гэж тэр хэлэв.

Гэвч гэр бүлийн энэ хос гаргасан шийдвэртээ харамсдаггүй ажээ. Тэд одоогийнх шигээ аз жаргалтай байх байсан гэж боддоггүй гэнэ.

“Би ариун сүмд гэрлэсэн. Сайн хань, дөрвөн сайхан хүүхэдтэй болсон. Сүмд идэвхтэй байгаа. Ганцхан сагсан бөмбөг эдгээрийн алийг нь ч надад өгч чадахгүй шүү дээ. Энэ бүхэн бол Их Эзэнийг нэгдүгээрт тавьсны ачаар ирсэн адислаалууд” хэмээн Блек яриу.

Их Эзэнийг нэгдүгээрт тавьсан нь аавынх нь егөөдсөн үг буруу байсныг нотолсонгүй, харин энэ үгийг шинэ утгатай болгожээ. Хэдэн жилийн өмнө сагсан бөмбөгийн холбоо ням гараг бүр лигийн тоглолт явуулж байх тухай ярилцахаар клубын ерөнхийлөгч нар цугласан ажээ. Тэдний нэг нь, “Та Блекийг урьсан уу?” гэж асуув.

Уг саналыг Блек хүлээж аваагүй ажээ.

Блек Их Эзэнийг нэгдүгээрт тавьсан учраас эдүгээ хүн болгон зөвхөн түүнийг таньдаг төдийгүй, тэр юунд итгэдгийг бас мэддэг болсон гэнэ. ■

Блек Миранда хоёрын хувьд спортын амжилт нь өрх гэрийнхээ амьдралыг өнгөтэй өөдтэй авч явахаас бага ач холбогдолтой зүйл болсон юм.

“Би судруудыг бие даан судалж чадах байтал яагаад семинарт явах хэрэгтэй юм бэ?”

Та амьдралынхаа үлдсэн хугацаанд судруудыг бие даан судалж болно л доо. Харин боломжтой бол судруудыг онцгой туршлагатай багш, найз нөхөдтэйгөө хамт семинарт одооноос судлах сайхан боломжийг бүү алд.

Сайн багшийн удирдлагаар судруудыг судлах нь бие даан судлахад ойлгохгүй байж болох судруудын тухай шинэ ойлголттой болоход тань тусална. Багш чинь бас бошиглогчид болон Сүмийн бусад удирдагчдын сургаалаас хуваалцах болно. Энэ нь судруудыг сайн ойлгоход тань тусална.

Түүнчлэн, ангийнхантайгаа хамт суралцах нь сонирхолтой, хөгжилтэй байдаг. Унших үедээ шинээр олж мэдсэн зүйлсийнхээ тухай ярих боломж өөрт чинь олдоно. Ангийнхан чинь сударт хэрхэн дуртай болсон туршлагаа хуваалцаж болно. Тэдний туршлагыг сонсох нь судруудыг амьдралдаа хэрэгжүүлэхэд чинь тусалж болно. Та сайн мэдээг бусадтай хамтран судалдаг учраас дараах амлагдсан адислалыг хүртэнэ: “Хоёр эсвэл гурваараа миний нэрээр, . . . хамтдаа цугласан тэнд би тэдний дунд байх болно” (С ба Г 6:32).

Семинар бас таны судар судлах бүтцийг тогтоож өгдөг. Та бас судрыг тодорхой хуваариар унших хүсэлтэй болох бөгөөд энэ нь судрын ном бүрийг уншиж дуусгахад тань тусална. Судрын гарамгай эзэмших шүлгүүдийг ярилцан, тэдгээрийг цээжлэх боломж танд олдоно. Семинарт явснаар амьдралынхаа энэ үед өөр ямар ч аргаар судалснаас илүү их үр өгөөжийг судруудаас олох нь танд баталгаатай болно.

Шинэ найз нөхөд, шинэ санаа



Семинарт та шинэ найз нөхөдтэй болж, бие бие-тэйгээ нэг гэр бүл мэт ойр дотно болно. Та бие дааж судлаад мэдэх аргагүй олон шинэ зүйлийг сурч мэднэ. Энэ нь хөгжилтэй бас туйлын сүнслэг байж, цаг заваа зөв өнгөрүүлэх боломжийг олгоно. Хэрэв та семинарт хамрагдаагүй бол одоо яв,

тэгвэл амьдрал чинь өөрчлөгдөх болно.

Катарина Б., нас 16, Калифорни, АНУ

Аз жаргал



Семинараар миний өдөр эхэлдэг. Семинар намайг аз жаргалтай бөгөөд сайн мэдээг бусад хүмүүстэй ярилцах хүсэл эрмэлзэлтэй болгосон. Бид судруудыг шүлэг бүрээр нарийвчлан

ярилцдаг болохоор илүү сайн ойлгодог.

Мади С., нас 15, Колорадо, АНУ

Хувиараа болон семинараар хослон судал



Семинар бол сэтгэл санаа өөдрөг өрнүүн байдаг сайхан газар. Зарим үед бие дааж судлах нь хангалтгүй байдаг. Хувиараа болон семинараар

хослон судлах нь үр өгөөж маш сайтай. Багш нар гайхалтай сайхан заахын сацуу хэрвээ танд асуулт байвал багш нар болон ангийнхан чинь асуултанд тань хариулахад тусална.

Доосон Д., нас 15, Айдахо, АНУ

Илүү сайн ойлголт



Ариун судруудыг ганцаараа судалснаас бусадтай хамтран судлах нь илүү сонирхолтой, хөгжилтэй байдаг. Түүнээс гадна, бид судруудыг хамтран судалснаар бусдаасаа сонирхолтой санаануудыг сурч мэдэж болно.

Би семинараас олон сонирхолтой түүхийг мэдэж авсан, мөн судрууд юун дээр үндэслэгдэн бичигдсэн талаар их зүйл мэддэг болсон. Энэ нь судар судлахыг улам сонирхолтой, сэтгэл догдлом болгодог! Би семинарт явахаар шийдсэндээ баяртай байдаг.

Ребека М., нас 16, Шлесвиг-Холстейн, Герман

Хариултауд нь туслах болон ирээдүйг харахад зориулагдсан бөгөөд Сүмийн сургаалын албан ёсны мэдэгдэл биш юм.

Бат бөх гэрчлэл



Нэгдүгээрт, хоёр юм уу гурван хүн Түүний нэрээр цугласан газарт Тэр тэдэнтэй хамт байх болно хэмээн Их Эзэн хэлсэн билээ (Матай

18:20; С ба Г 6:32-ыг үз). Түүний Сүнсийг мэдрэх нь бидний төлөө Тэрбээр юу хийснийг тунгаан бодоход тусална. Хоёрдугаарт, бид судруудыг бусадтай хамтран судалснаар тэнд бичигдсэн зүйлийг илүү сайн ойлгож чадна. Бид бие биеийнхээ үгийг сонссоноор өөрөө ажиглаагүй ямар нэг зүйлийг мэдэж болно. Бас биднийг мэддэг зүйлээ хуваалцахад бусад нөхөд маань ч бас сурч мэдсэнээ хуваалцана. Гуравдугаарт, семинарт явснаар миний гэрчлэл бат бөх болсон. Семинар гэрчлэлээ хуваалцах болон бусад хүмүүсийн гэрчлэлийг сонсох боломжийг бидэнд олгодог. Бас үргэлж зөв зам дээр байхад бидэнд тусалдаг.

Дмитрий Г., нас 16, Днепрпетровск. Украин

Бусдаас суралц



Семинарт явах нь миний заавал биелүүлэх ёстой үүрэг мөн. Туршлагатай багш надад зааж, судар дахь үнэнүүдийг тайлбар-

лаж өгдгөөс гадна би хичээл дээрх ярилцлагаас маш их зүйл сурдаг. Бусад суралцагчид сурч мэдсэн зүйлээсээ хуваалцах нь сайн мэдээний тухай, Аврагч болон Түүний Цагаатгалын тухай илүү их мэдлэгтэй болоход надад тусалдаг. Ганцаараа бие дааж судлах нь хангалтгүй учраас би хичээл дээрх ярилцлагуудаас зарим асуудлынхаа хариуг олсон. Есүс Христийн үнэн Сүмийн тухай миний гэрчлэл өсч хөгжихөд семинар маш чухал үүрэг гүйцэтгэснийг би гэрчилж чадна.

Дензел Ж., нас 15, Баруун Самоа

Гэрэл ба үнэн



Би семинарт явснаар гэрэл ба үнэнийг хайж, Бурханы өвч хуяг дуулгыг өмссөн юм (С ба Г 27:15–18-ыг үз). Энэхүү хуяг дуулга

бүх цаг үед, бүх газарт Түүний дуу хоолойг танихад надад тусалдаг. Өдөр бүр судар унших нь миний итгэл, гэрчлэлийг бэхжүүлж, сорилт бэрхшээл тулгарсан үед зоригтой байхад тусалдаг. Семинарт явах нь гэрэл ба үнэнийг олж, судруудыг судлан, тунгаан бодох хамгийн сайн аргуудын нэг мөн.

Нохеми М., нас 17, Пуэбло, Мексик

Гурван шалтгаан

Нэгдүгээрт, би номлолд үйлчлэхийг хүсдэг учраас семинарт явдаг. Номлогчид өглөө эрт босч, сайн мэдээг өглөө судалдаг байх хэрэгтэй. Семинарт явах нь өглөө эрт босч байх сайн хэвшлийг бий болгоход надад тусалдаг. Хоёрдугаарт, бид өглөө толгой сэргэг байхад уншиж, судалж байгаа зүйлдээ анхаарлаа төвлөрүүлж чадна. Бурханы тухай мэдэхийн тулд өдрийн хамгийн тохиромжтой цагийг ашиглах нь ухаалаг арга юм. Гуравдугаарт, хэрэв би бие даан судаллаа гэхэд багшаар

заалгасан шиг гүнзгий ойлгохгүй байж мэднэ. Би багшийн заах арга, удирдлагаар өөрөө бие даан судалснаас илүү ихийг сурч чадна.

Х. Чен Юань, нас 16, Тай-Чунг, Тайвань



СЕМИНАРЫН АДИСЛАЛУУД

“Семинар, институтын хөтөлбөрүүдэд хамрагдсанаас ирдэг хүч чадлыг би мэднэ. Энэхүү хүч чадал миний амьдралыг баялаг болгосон юм.

Энэ нь та нарын хувьд ч мөн ийм байх болно гэдгийг би мэднэ. Институт та нарт хамгаалалтын бамбай болж, дэлхийн уруу таталт, хүнд сорилтуудаас та нарыг хол байлгах болно. Сайн мэдээний мэдлэгээс агуу адислал ирдэг. Сүмийн залуу хүмүүс ариун зүйлсийн тухай үнэн бодит мэдлэгтэй болоход семинар, институтын хөтөлбөр хамгийн сайн тусалж чадна гэдгийг би мэднэ.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Л. Том Перри, “Receive Truth,” Ensign, 1997 оны 11-р сар, 61–62.

ДАРААГИЙН АСУУЛТ

“Ариун явдлын хуулийг зөрчих нь яагаад ноцтой нүгэл болохыг би найздаа яаж тайлбарлах вэ?”

Хариултаа 2012 оны 5-р сарын 15-ны дотор liahona.lds.org хаягаар эсвэл liahona@ldschurch.org хаягаар э-мэйлээр эсвэл дараах хаягаар шуудангаар ирүүлнэ үү:

Liahona, Questions & Answers 5/12
50 E. North Temple St., Rm. 2420
Salt Lake City, UT 84150-3220, USA хаягаар шуудангаар явуулж болно.

Хариултын хэмжээг тохируулах болон тодорхой болгохын тулд хянан засварлаж болно.

Э-мэйл буюу захидалдаа дараах мэдээлэл болон зөвшөөрлийг оруулна уу: (1) бүтэн нэр, (2) төрсөн он сар өдөр, (3) тойрог буюу салбар, (4) гадас буюу дүүрэг, (5) таны хариулт болон гэрэл зургийг нийтлэхийг зөвшөөрсөн өөрийн чинь бичгээр гаргасан зөвшөөрөл, 18 нас хүрээгүй бол, эцэг эхийн бичгээр гаргасан зөвшөөрөл (э-мэйл байж болно).

ЯАГААД СЕМИНАРТ ЯВАХ ХЭРЭГТЭЙ ЮМ БЭ?

СЕМИНАРТ ХАМРАГДААРАЙ


Семинар нь Есүс Христийн Цагаатгал болон сургаалуудыг ойлгож, эдгээрт итгэл найдвар тавихад та бүгдэд туслах болно. Та судруудад дуртай болсноор Их Эзэний Сүнсийг мэдрэх болно. Та өөрийгөө ариун сүмд ороход болон номлолын үйлчлэлд бэлтгэх болно.

Залуучууд та бүхнийгээ семинарт хамрагдахыг би хүсч байна. Судруудаас өдөр бүр суралц. Багш нараа анхааралтай сонсож бай. Сурсан зүйлээ залбирч амьдралд хэрэгжүүл.

Ерөнхийлөгч Томас С.Монсон, "Participate in Seminary," seminary.lds.org.

Семинар, институтээс суралцагчийн олж авдаг хамгийн чухал зүйл таны бодлоор юу вэ? Семинарын хэсэг суралцагч Сүмийн Боловсролын Системийн Бүрэн эрхт төлөөлөгч, Далын Ахлагч Пол В.Жонсоноос дээрх асуултыг асуухад, семинараас та нарын олж авах хамгийн чухал зүйл бол "Есүс бол Христ болох тухай үнэн бодит гэрчлэл" хэмээн тэрээр хариулжээ. *Үнэн бодит* мэдлэг бол сүнсний мэдлэг гэж ойлгох хэрэгтэй. Энэхүү мэдлэг Ариун Сүнснээс бид бүгдэд ирдэг. Энэ бол семинар, институтээс бидний олж авдаг хамгийн чухал үнэн, хамгийн чухал зүйл мөн. Энэ нь зөвхөн мэддэг зүйлийг чинь өөрчилдөггүй, харин таныг өөрийг чинь өөрчилдөг, бас дэлхийг үзэх үзлийг чинь өөрчилдөг. Энэхүү дээд боловсрол таны бусад боловсролыг бүрэн гүйцэд болгоход тусалдаг ("A Higher Education," *New Era*, 2009 оны 4-р сар, 15).

Ахлагч Жонсон бол семинар, институтэд явснаас ирдэг гайхамшигтай адислалуудын тухай ярьсан олон Ерөнхий эрх мэдэлтнүүдийн нэг юм. Иймээс та яагаад семинарт явах хэрэгтэй юм бол гэж боддог бол үүний шалтгааныг бошиглогчид, төлөөлөгчид юу гэж үздэгийг доор өгүүлэв.



АЗ ЖАРГАЛ, АМЖИЛТ БҮТЭЭЛИЙН СУУРИЙГ ТАВЬ

"Семинарын хөтөлбөр залуу эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд та нарт амьдралдаа аз жаргал, амжилт бүтээлийн үндэс суурийг тавихад туслах болно.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Ричард Г.Скотт, "Now Is the Time to Serve a Mission!" *Лиэхона* 2006 оны 5-р сар, 88.





СЕМИНАРЫН АЧААР БИЙ БОЛДОГ ГУРВАН ЗҮЙЛ

“Семинарын ачаар дараах чухал гурван зүйл бий болдог. Нэгдүгээрт, семинар залуу хүмүүсийг адил зүйлсийг эрхэмлэн дээдэлдэг хүмүүстэй танилцуулдаг. Залуучууд итгэл нэгтэй бөгөөд судруудад дуртай бусад хүмүүстэй хамт байхад дуртай байдаг. Хоёрдугаарт, семинар залуусыг гэрчлэл бүхий багштай хамт нэг баг болгосноор тэд гэрчлэлтэй болж, гэрчлэл нь улам хүчтэй болж байгааг мэдэрдэг. Гуравдугаарт, семинар залуу хүмүүсийг сударт сонирхолтой болгодог.”

Тэргүүн Зөвлөлийн Нэгдүгээр зөвлөх, Ерөнхийлөгч Хенри Б.Айринг, “Судар судлах тухай ярилцлага,” *Лиахона*, 2005 оны 7-р сар, 11.

САЙН МЭДЭЭНИЙ ҮНЭНҮҮДЭД СУРАЛЦ

“Семинарт сайн мэдээний олон үнэнийг мэдэж авдаг учраас би хөвгүүд, охид нэг бүрийг семинарт яваарай хэмээн чин сэтгэлээсээ захьж байна. Семинар бол олон хөвгүүд, охидын хувьд хийх ёстой зүйлсээ туйлын зорилго болгон оюун ухаандаа төлөвшүүлдэг газар юм. Тиймээс тэд номлолд явдаг.”

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл (1895–1985), “President Kimball Speaks Out on Being a Missionary,” *New Era*, 1981 оны 5-р сар, 49.

СЕМИНАРЫГ ЭН ТЭРГҮҮНД ТАВЬ

“Суралцагчид аа, хэрэв та нарын эрхэмлэдэг зүйлс ном ёсоороо байх юм бол сонгон суралцах ангид явах тухайд бүү эргэлз. Энэ нь ангид үздэг хичээлээс сонирхолтой байж болох бөгөөд судлах зүйлсийн үндэс суурийг сайн тавьж чадна. Нэгэнт элссэн л бол семинартаа тогтмол явж, ихийг сурч мэд. Найз нараа мөн семинарт явахыг ятга. Та нар семинарт явсныхаа төлөө хэзээ ч харамсахгүй. Би үүнийг та бүхэнд амлаж байна.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч Бойд К.Пакер, “Agency and Control,” *Ensign*, 1983 оны 5-р сар, 67.



АДИСЛАЛУУДЫГ АМЬДРАЛДАА УРЬ

“Сүм дэх семинарын тогтолцоо болон институтын хөтөлбөрийн төлөө би талархалтай байдаг. Миний бие ахлах сургуулийн сурагч бүрийг семинарын хөтөлбөрийн давуу талыг ашиглаасай хэмээн хүсдэг. Та нар семинарт явбал амьдрал чинь агуу ихээр адислагдах болно.”

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли (1910–2008), “Excerpts from Recent Addresses of President Gordon B. Hinckley,” *Ensign*, 1995 оны 12-р сар, 67.

СЕМИНАРАА ТӨГСӨЖ БАЙ

“Семинарт тогтмол явж, төгсгөж бай. Семинарын хичээл бол залуу эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн эзэмшиж болох гайхалтай сүнслэг туршлагаудын нэг мөн.”

Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон (1899–1994), “To the Youth of the Noble Birthright,” *Ensign*, 1986 оны 5-р сар, 44; “To the Young Women of the Church,” *Ensign*, 1986 оны 11-р сар, 82.



СПЕНСЕР В.КИМБАЛЛЫН ГЭРЭЛ ЗҮРГИЙГ ХУГ СУМИЙН АРХИВЫН ЗӨВШӨӨЛГӨӨР НИЙТЛЭВ





Эквадорын ширэнгэн ой дахь СЕМИНАР

Алслагдсан ширэнгэн ой дахь семинар залуучуудыг маш их өөрчилж байна.

Жошуа Ж.Перки

Сүмийн сэтгүүлүүд

Эквадорын Квитогоос зүүн тийш, галт уулс болон Андын нурууг өнгөрмөгц газрын байдал Амазоны ширэнгэн ой болж өөрчлөгддөг. Тэр нутагт шигүү ой, олон гол мөрөн, төрөл бүрийн сармагчин, халуун орны халбаган хошуут (шувуу), бүр цэнхэр далайн гахай хүртэл бий.

Мөн тэнд Пуэрто Франциско де Орелана гэдэг хот байдаг. Энэ хот Эквадорын юм бүхнээс алс хол оршдог. Энд арвантаван жилийн өмнө харьцангуй цөөхөн хүн амьдарч байлаа. Гэвч энэ нутагт газрын тос олдсон нь аж үйлдвэр хөгжихөд түлхэц үзүүлж, ажил хайсан олон хүн, тэдний дотор Сүмийн гишүүд ирж суурьшжээ.

Жижигхэн салбарын семинар

Энэ салбарыг зохион байгуулах үед Оскар Р. шиг ганц хоёрхон залуу хүн хуучин гишүүд байсан бол ихэнх нь шинээр хөрвөгчид байлаа. Тэд Сүмийн талаар оргилуун урам зориг, өөдрөг үзэл бодолтой байгаа ажээ. “Бидний итгэл бат бөх байгаа” гэж Оскар хэллээ.

Салбар зохион байгуулагдсанаас хойш яг жилийн дараа 2010 оны 9-р сард семинарын

хөтөлбөр эхэлсэн ажээ. “Бид хэдхэн жилийн өмнө цуглаж эхлэхэд цөөхүүлээ байсан. Ганцхан залуу хүн нь би байв. Гэвч бид олон болсоор байлаа. Удалгүй бид зургуулаа, дараа нь арвуулаа болсон. Одоо бүр олон залуустай болсон” хэмээн Оскар яриу.

Залуучуудын зарим нь өглөө, зарим нь үдээс хойш сургуульд явдаг учраас нэг нь өглөө 8:00–9:00 цагт, нөгөө нь үдээс хойш 4:30–5:30-д хичээллэдэг семинарын хоёр ангийг зохион байгуулжээ.

Семинарын хөтөлбөрт тийм ч олон залуус хамрагддаггүй байж болох ч, эдгээр залуусын амьдралыг өөрчилжээ.

Залуус яагаад семинарт явдаг юм бэ?

“Семинар миний хувьд агуу адислал мөн” гэж саяхны хөрвөгч Люис В. хэллээ. “Семинар надад сайн номлогч болохоор бэлтгэхэд тусалдаг. Би Сүмд нэгдсэнээс хойш олон сорилт, уруу таталттай тулгарсан ч, зөв зүйл хийж байгаагаа мэддэг байсан учраас бат бөх итгэлтэй байж чадсан.”

Ганцхан Люис ч ингэж боддоггүй ажээ. “Би Сүмийн гишүүн болоод удаагүй ч, баптисм хүртсэнээсээ хойш семинарт тасралтгүй явж байна. Би Есүс Христийн сайн мэдээний талаар олон үнэн зүйлийг

Эквадорын эдгээр залуусын итгэлийг семинар хүчирхэгжүүлжээ. Тэднээс олон нь саяхны хөрвөгчид юм.



мэдсэн учраас семинарт явсандаа баяртай байна. Миний сурч мэдсэн зүйлс зүрх сэтгэлийг минь итгэл найдвараар, оюун ухааныг минь мэдлэгээр дүүргэдэг” гэж Ариана Ж. ярьлаа.

Семинарт явсан нь сайн мэдэний мэдлэгээ тэлэхэд Арианад тусалжээ. “Семинарын ангийн гишүүн байгаа нь надад адислал болдог. “Семинарын хичээл миний сүнслэг байдлыг бэхжүүлж, нэгэн цагт сайн

өгөөд дараа нь эмэгтэй дүүтэйгээ семинарт явахаар гэртээ эргэж ирдэг ч, үүнээс төвөгшөөдөггүй ажээ.

“Энэ бүхэн миний хувьд шинэ зүйл ч гэсэн би аз жаргалаар бялхан байна. Би Тэнгэрлэг Эцэгтэйгээ дахин учран золгох боломжийг олгож буй зөв зам дээр байгаагаа мэдэж байна. Ариун Сүнс энэхүү баталгааг надад өгсөн юм. Би эцсийг хүртэл чадах бүхнээ хийх ёстой” гэж Жерардо хэлэв.

Тэвдэх хэрэггүй

Уолтер А.-д семинар эхний үед жаахан сүрдмээр юм шиг байжээ. “Би семинарт анх ирээд тэвдсэн шүү” гэж тэр хэллээ. “Тэвч ангид ороод л аятайхан болчихсон. Судар судлахад ямар мэдрэмж төрдөг билээ, яг тийм хайрын мэдрэмж надад төрсөн. Тэгээд семинараас гарч явахдаа сурч мэдсэн зүйлийнхээ төлөө сэтгэл зүрхэндээ талархалтай байгаагаа мэдэрч билээ. Тэнгэрлэг Эцэгээс залуучуудад зориулан бэлтгэсэн агуу адислалуудын нэг нь семинар юм.”

Номлолд явахаар бэлтгэж байгаа Абел А., “Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм миний амьдралыг өөрчилсөн юм” гэв. “Би бошиглогчдын сургаалаас олон зүйл сурч байна. Би Иосеф Смитийг их хайрладаг. Үнэн Сүмийг сэргээхэд үй олон хэцүү асуудал түүнд тулгарсан ч тэр асар их зоригтой байлаа. Би түүн

шиг зоригтой байхыг хүсдэг.”

Олон залуус семинарт явахын тулд золиослол хийх шаардлагатай болдог. Золиослол хийх нь үргэлж хялбар байдаггүй ч, Эквадорын Пуэрто Франциско де Ореланагийн залуус энэ талаар хүч чармайлт гаргаж байна.

“Судруудад өгүүлдэг шиг намайг урагш тэмүүлэхэд, амьдралдаа хамгийн түрүүнд тавих ёстой зүйлсийг судар бидэнд зааж өгдөг гэж би боддог” хэмээн Абел өгүүлэв. Тэдгээр зүйлсийн нэг бол семинар юм. “Семинар миний амьдралыг өөрчилсөн шиг бусад залуусын амьдралыг ч бас өөрчлөх болно.”

Эквадорын өтгөн ширэнгэн ойд Есүс Христийн Сүм болон залуучуудад зориулсан семинарын хөтөлбөр цэцэглэн хөгжиж, семинарт явахаар сонгосон хүмүүсийн амьдралыг өөрчилж байна. ■



гэргий, сайн ээж, Сүмийн удирдагч, магадгүй бүрэн цагийн номлогч болохоор бэлтгэхэд надад тусалдаг” хэмээн Ариана яриу.

Арианагийн ах Жерардо ч мөн ингэж боддог ажээ. “Семинар миний амьдралын чухал хэсэг болсонд би баяртай байна. Нэгэн цагт номлолд үйлчлэхэд семинар намайг бэлтгэж байна. Надад зориулан Бурханы бэлтгэсэн авралын төлөвлөгөөний тухай би семинараас мэдсэн. Би селестиел хаант улсад амьдрах болно гэсэн найдварыг миний суусан хичээл бүр надад төрүүлдэг. Би бас Есүс Христийн сайн мэдээг хүлээн авснаа семинарын хичээлээс тодорхой ойлгосон” хэмээн тэр ярьлаа.

Жерардо заримдаа хичээлийн үеэр их ядардаг гэнэ. Тэр эхлээд жаахан эрэгтэй дүүгээ сургуульд нь хүргэж



СЕМИНАРЫН ДАРАА ЯАХ ВЭ?

Семинарыг төгссөнөөр шашины хичээл чинь дуусч байгаа юм биш. Нэгэн сайхан зүйл чамайг хүлээж байгаа.

Давид А.Эдвардс

Сүмийн сэтгүүлүүд

Чи семинарт судруудыг судалж, үе тэнгийнхээ бусад залуустай тогтмол уулзаж байсан нь лавтай. Бас семинарт баяр баясгалантай байж, Сүнснийг мэдэрч байсан нь мэдээж. Харин семинараа төгсчихөөр энэ бүхэн байхгүй болчих уу? Огт үгүй.

Сүмийн институтын хөтөлбөр бол дараагийн алхам бөгөөд энэ нь чамд таалагдах болно. Чи коллежид сурдаг буюу сурдаггүй байсан ч, сайн мэдээний тухай мэдлэгээ гүнзгийрүүлж, номлол болон ариун сүмийн гэрлэлтэд бэлтгэн, үетэнгийнхээ бусад залуустай туршлагаа хуваалцаж чадна.

Институтын тухай зарим асуултын хариуг дор өгөв. institute.lds.org хаягаас чи илүү их мэдээллийг олж үзэж болно.

Институт гэж юу вэ?

Институт нь сайн мэдээг, түүний дотор судар, бошиглогчдын сургаалуудыг судлах, номлолд болон ариун сүмийн гэрлэлтэд бэлтгэх ангиудаас бүрддэг. Зарим институтэд олон төрлийн хичээлээс сонгон суралцаж болно.

Хэн институтэд явж болох вэ?

Ганц бие залуу насанд хүрэгч бүрийг институтын ангиудад суралцахыг ихэд урамшуулан дэмждэг. 18-30 насны гэрлэсэн болон ганц бие хэн ч гэсэн институтэд явж болно.



ИНСТИТУТЫН ТУХАЙ ТОО БАРИМТ

Суралцагчдын тоо:
350,000 гаруй

Институт хичээллэдэг газрын тоо: 2,500 гаруй

Үздэг хичээлийн тоо:
15 үндсэн хичээл, сонгон суралцах нэлээд хэдэн хичээл

Анхны институт:
Москва, Айдахо, АНУ (1926)

АНУ, Канадаас гаднах анхны институт:
Мексик (1959)

Институтын зорилго:
бол залуучууд болон залуу насанд хүрэгчдэд Есүс Христийн сургаал болон Цагаатгалыг ойлгон, найдаж Ариун сүмийн адислалд бэлтгэн зохистой байж, өөрсдийгөө, гэр бүлээ болон бусдыг Тэнгэрлэг Эцэгтэйгээ байх мөнх амьдралд бэлтгэхэд нь туслалахад оршино.

Институт хаана байдаг вэ?

Зарим бүсүүдэд коллеж, их сургуулиудын ойролцоо институтын байрууд байдаг. Бусад бүсүүдэд институт Сүмийн байруудад эсвэл бусад газарт хичээллэдэг. Орон нутаг дахь институтын хөтөлбөрийн тухай түүнчлэн хамгийн ойрхон институтыг мэдэхийн тулд бишоп буюу салбарын ерөнхийлөгчтэйгөө холбоо барь эсвэл institute.lds.org хаягаар орж үзнэ үү.

Би яагаад институтын хичээлд суух ёстой юм бэ?

Ерөнхийлөгч Томас С.Монсон хэлсэн нь: “Юуны түрүүнд институтэд яв. . . . Үүнийг тунгаан бодоорой. Институтэд явснаар найз нөхөдтэй болж, Сүнснийг мэдэрэн, итгэл тань хүчтэй болно. Институтэд хамрагдан, судруудыг хичээнгүйлэн судалснаар уруу таталтаас зайлсхийх хүч, хийж буй бүх зүйлдээ Ариун Сүнсний удирдамжийг хүлээн авах тань нэмэгдэх болно гэдгийг би та нарт амлаж байна (institute.lds.org, 2009 сарын 21). ■



2 Тимот 3:16-17

*Судрууд бидний амьдралыг хэрхэн адисалдаг тухай
Төлөөлөгч Паул ийн бичсэн байдаг.*



Судар бүр

“Бид Бурхантай ярихыг хүссэн үедээ залбирдаг. Мөн Түүнийг бидэнд хандан ярихыг хүссэн үедээ бид судруудыг

судалдаг; учир нь Түүний үгс бошиглогчдоор дамжин бидэнд ирдэг. Бид Ариун Сүнсний өдөөлтийг анхааран сонссон үед Тэрбээр бидэнд заах болно.

“Хэрэв та өөрт чинь хандан ярьсан Түүний дуу хоолойг сүүлийн үед сонсоогүй бол, Сүмдээ эргэн ирж, судруудыг дахин унш. Судрууд сүнслэг байдлаа насан туршид хадгалахад бидэнд тусалдаг.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Роберт Д.Хейлс, “Holy Scriptures: The Power of God unto Our Salvation,” *Лиакона*, 2006 оны 11-р сар, 26-27.

Сайн үйлс

Ямар сайн үйлсийг хийхэд судрууд танд тусалдаг вэ? Нэн тодорхой цөөн сайн үйлсийг дор жагсаав. Өөр ямар сайн үйлсийг та нэрлэж чадах вэ? Энэ тухай тэмдэглэлдээ бичнэ үү.

- Бүрэн цагийн номлогчоор үйлчлэх
- Сүмийн дуудлагаа (чуулгын болон ангиудын ерөнхийлөгчийн зөвлөлийн гэхчлэн) биелүүлэх
- Сайн мэдээг заах
- Гэрчлэлээ хуваалцах
- Сайн мэдээг хуваалцах
- Сүмийн тухай найз нарынхаа асуулганд хариулах

Залруулга

Библи дэх анхны грек үг нь “дахин цэх шулуун болгох” гэсэн утгатай ажээ. Иймээс зөв чиглэл дээр байж, нарийн бөгөөд шулуун замыг дагахад тань судрууд тусална (2 Нифай 9:41-ийг үз).

16 Судар бүр Бурханы амьсгалснаар байгаа бөгөөд заахад, зэмлэхэд, залруулахад, зөвт байдал дотор чиглүүлэхэд тустай. 17 Энэ нь Бурханы хүн аливаа сайн үйлд бүрэн бэлтгэгдсэн байхын тулд юм.

Зэмлэл

Зэмлэл бол ихэвчлэн найрсаг байдлаар сануулах, шүүмжлэх, хатуухан үг хэлэх, дутагдлыг засч залруулах явдал юм.

Бүрэн бэлтгэгдсэн байх

Бүрэн бэлтгэгдсэн байх гэдэг нь арга зам буюу арга хэрэгслээр хангагдсан байх гэсэн утгатай.



(Сургаалыг) заах

“Үнэн сургаал ойлгомжтой байх юм бол хүмүүсийн зан төлөв, харьцаа хандлагыг өөрчилж чадна. Сайн

мэдээний сургаалуудыг судлах нь зан төлөвийг судлах замаар үүнийг сайжруулахаас илүү түргэнээр зан төлөвийг сайжруулна.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч Бойд К.Пакер, “Do Not Fear,” *Лиакона*, 2004 оны 5-р сар, 79.

Редакторын тэмдэглэл: Энэ хуудас бол сонгосон судрын шүлгийн бүх талыг хамарсан тайлбар биш, зөвхөн өөрийн тань судалгааны эхлэх цэг юм.



СҮЙРЭЭЛД БҮҮ ХҮР

Жижиг асуудлуудыг одоо шийдвэрлэж, хожмын том асуудлуудаас урьдчилан сэргийл.

Адам К.Өүлсон
Сүмийн сэтгүүлүүд

СҮНСЛЭГ БАЙДЛАА ШАЛГА



“Бид аль талаараа сайжрах хэрэгтэй байгаагаа мэдэхийн тулд сүнслэг байдлаа тогтмол шалгаж байх хэрэгтэй.

“Бид жижиг

сажиг дутагдлаа ихэвчлэн Ариун Сүнсний тусламжтайгаар ухамсарлан ойлгодог. . . . Сүнс болон Сүмийн удирдагчид, бидний хайртай хүмүүс, хамт ажиллагсад болон найз нөхдөөс бидний талаар хэлж байгаа зүйлсийг бид анхааралтай сонсох хэрэгтэй.”

Далын Ахлагч Маркус А.Айдукайтис, “Honesty in the Small Things,” *Ensign*, 2003 оны 9-р сар, 30.

Андрей бүр багаасаа нисэх онгоцонд дуртай байжээ. Нисэхийг мөрөөддөг олон хүн байдаг ч, Андрей онгоцоор нисэх тухай боддоггүй, харин нисэх онгоцны бүтцийг сонирхдог ажээ. Румыны 16 настай энэ залуу нисэх онгоцны механикч болохоор суралцаж байгаа гэнэ.

Румынд өсвөр насны хүүхдүүд коллеж буюу мэргэжлийн сургуульд суралцахын тулд ахлах сургуульд явах хэрэгтэй. Андрей нисэх онгоцонд дуртай болохоор нисэхийн мэргэжлийн сургуульд суралцах шийдвэрийг тэр дороо гаргасан ажээ.

Нисэх онгоцны механикчид зөвхөн эвдэрсэн онгоцыг засдаг төдийгүй, тэдний хийдэг хамгийн чухал ажлуудын нэг нь нисэх онгоц эвдрэхээс урьдчилан сэргийлдэг үзлэг шалгалт, засвар үйлчилгээ юм. Тэд нисэх онгоцны юм бүхнийг, сэнснээс эхлээд газардах төхөөрөмж, түүнчлэн энэ хоёрын хоорондох бүх эд ангид тогтмол үзлэг хийдэг.

“Нисэх онгоцыг эвдрэхэд хүргэж болох жижиг асуудлыг олох нь хэцүү. Гэвч асуудлыг олох нь нисэх онгоцыг эргээд бүрнээр нь эвлүүлэх гэж оролдохоос илүү амархан зүйл” гэж Андрей хэллээ.

Засвар үйлчилгээний хуваарийг чанд мөрдөж, бүх эд ангийн засвар үйлчилгээг алгасахгүй хийх нь нисэх онгоцонд туйлын чухал. Үүн лүгээ

адил Сүмийн гишүүд сүнслэг байдалд нь заналхийлж болох аливаа асуудлыг урьдаас мэдэж, залруулах нь мөн л амин чухал юм.


Сүнслэг байдалдаа онцгой анхаарал тавь

Андрей бараг хоёр сая хүнтэй Бухарест хотод амьдардаг. Румын дахь Сүм харьцангуй шинэ бөгөөд Бухарестадад ердөө хоёр салбарт явахад хангалттай тооны гишүүд байдаг ажээ. Андрей болон түүний гэр бүл салбарынхаа бусад гишүүдээс хол амьдардаг. Андрей сургууль дээрээ бас найз нөхдийнхөө дунд дэлхийн нөлөөг байнга мэдэрдэг гэнэ. Хэрэв сүнсний амьдралдаа байнга анхаарал тавихгүй бол сүнслэг байдал хэчнээн амархан доройтогийг тэр мэднэ.

Амьдрал амсхийх завгүй байж болно. Андрей хичээлээ хийж, хөл бөмбөг тоглон, компьютерийн ард сууж цагаа өнгөрүүлнэ. Бас залбирах, мацаг барих, судар судлах, санваартны үүргээ биелүүлэх цаг гаргана. Тэр бас семинарт “явна.” Гэхдээ хол амьдардаг учраас онлайнгаар хичээлээ хийдэг ажээ.

Эдгээр зүйлсийг хийснээр та сүнслэг байдлын доройтол амьдралд чинь заналхийлэхээс өмнө үүнийг мэдэж, сул талаа засч залруулахын тулд сүнслэг байдалдаа анхаарал тавьж байгаа хэрэг юм.

“Хэвшил болтол нь байнга хийх ёстой зарим зүйл бидэнд байдаг.



Амьдралыг чинь бусниулах боломжийг та хэзээ ч бүү олго” гэж тэр хэллээ.

Сүнслэг байдлын сүйрэл

Хэрэв бид сүнслэг байдалдаа байнга анхаарал тавьж байхгүй бол бухимдал, үе тэнгийнхний шахалт зэрэг хүчин зүйлс уруу таталтыг эсэргүүцэх бидний хүчийг давамгайлж мэднэ. Ийм явдал тохиолдоход бид их удалгүй амьдралд зүг чигээ алдан, өөртөө хяналт тавих чадваргүй болж, эцэстээ сүнсний хүч чадлаа бүрмөсөн алдах боно.

Мотор нь унтарсан онгоц гарцаагүй өндрөө алддаг шиг хэрэв бид нүгэл үйлдвэл сүнсний хүч чадал болон өндөр жишгүүдээсээ хагацаж, тэнгэрээс холдон, эрт орой хэзээ нэгэн цагт сүнслэг байдлын сүйрэлд хүрнэ.

Сүнслэг байдал алдагдсаны дараа Аврагчийн Цагаатгал биднийг урьдын байдалд буцаан оруулах боломжтой ч, жижиг асуудал даамжирч сүнслэг байдлын сүйрэлд хүргэхээс өмнө уг асуудлыг залруулахын тулд Түүний хүчинд найдвар тавих нь хамаагүй дээр юм.

Хайхрахгүй өнгөрөхийн аюул

Нисэх онгоцонд тогтмол хийх ёстой засвар үйлчилгээг хийхгүй өнгөрнө гэсэн ойлголт Андрейн санаанд багтдаггүй ажээ. Засвар үйлчилгээг хийхгүй байж огт болохгүй. “Энэ талаар хууль байдаг.

Онгоцонд ердөө ганцхан удаа засвар үйлчилгээ *хийхгүй байхад* “юу л болно гэж дээ” хэмээн бодох хүн байж магадгүй.

Заавал хийх ёстой засвар үйлчилгээг нэг удаа хийхгүй өнгөрөхөд онгоц тэр дороо эвдрэхгүй л дээ. Гэвч ингэж болохгүй. “Өнөөдөр засвар үйлчилгээ хийгээгүй байхад юу ч болоогүй юм чинь, маргааш өнжихөд юу ч болохгүй шүүдээ гэсэн уруу таталтад бүр амархан автагдана” гэж тэр хэллээ.

Засвар үйлчилгээг олон удаа хийхгүй өнгөрүүлэхэд нисэх онгоцны хүч суларч, эд ангиуд нь гэмтэх эрсдэл ихсэн, эрт орой хэзээ

нэгэн цагт эвдрэлд хүргэнэ. Үүн лүгээ адил, бид сүнслэг байдалдаа байнга анхаарал тавихгүй бол эрт орой хэзээ нэгэн цагт сүнслэг байдлын хувьд доройтож, “эцэстээ сүйрэлд хүрнэ” хэмээн тэр ярив.

Чухам иймээс сүнслэг байдалдаа байнга анхаарал тавих хуулиудыг Бурхан бидэнд өгсөн юм. “[Сүм дээр] *ойр ойрхон* цуглан уулзацгаа” (3 Нифай 18:22; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн). *Байнга* залбирч бай (3 Нифай 18:19-ийг үз). Судруудыг *хичээнгүйлэн* судал (3 Нифай 23:1-5-ыг үз). “Бодол санааг чинь ариун журам *зогсолтгүй* чимэн гоёр” (С ба Г 121:45; онцлон

тэмдэглэлт нэмэгдсэн). Ариун сүмд *тогтмол* ор.¹

Эдгээр хуулиудыг сахьж, сүнслэг байдалдаа байнга анхаарал тавих нь биднийг зөв чиглэлд удирдах болно.

“Онгоц газраас тасарч, дэлхийг орхихын тулд зохион бүтээгдсэн юм. Энэ бол Тэнгэрлэг Эцэг биднээс хүсэн хүлээдэг зүйл. Бид сүнслэг байдалдаа байнга анхаарал тавьснаар очих ёстой газартаа буюу тэнгэрт аюулгүйгээр эргэн очих болно” хэмээн Андрей ярилаа. ■

ЭШЛЭЛ

1. Томас С.Монсон, “The Holy Temple—a Beacon to the World,” *Лиакхона*, 2011 оны 5-р сар, 92.

“Та нар итгэл дотор байгаа эсэхээ шалга”
(2 Коринт 13:5).

СҮНСЛЭГ БАЙДЛАА ШАЛГА

Нисэх онгоцны механикуудад байнга үзлэг шалгалт хийж байх зүйлсийн жагсаалт байдаг. Сүнслэг байдлаа өөрсдөө тогтмол шалгаж байхыг Сүмийн удирдагчид бидэнд зөвлөдөг билээ.¹

Сүнслэг байдлаа үе үе шалгаж үзэхэд өөрт чинь туслах хэдэн асуултыг доор өгөв. Хэрэв хариултанд чинь санаа зовоох ямар нэг зүйл байвал эцэг эх, бишоп болон салбарын ерөнхийлөгчтэйгөө ярилц.

- Би чин сэтгэлээсээ, тогтмол залбирдаг уу?
- Би судрууд дахь Бурханы үг болон амьд бошиглогчдын сургаалуудыг шимтэн судалдаг уу?
- Би Хүндэтгэлийн өдрийг ариунаар нь сахьж, Сүмийн цуглаануудад тогтмол оролцдог уу?
- Би мацаг барьж, аравны нэг болон бусад өргөлөө дуртай төлдөг үү?
- Би бусдыг уучлахад бэлэн байдаг уу?
- Би бусдад үйлчлэх арга замыг үргэлж олдог уу?
- Би бүх цаг үед Аврагчийг санаж, үлгэр жишээг нь дагадаг уу?
- Би бодол санаа, үг яриагаа цэвэр байлгадаг уу?
- Би бүх зүйлд шударга байдаг уу?
- Би Мэргэн Ухааны Үгийг сахьдаг уу?

ЭШЛЭЛ

1. Жозеф Б.Вертлин, “True to the Truth,” *Ensign*, 1997 оны 5-р сар, 17.

СУДРУУДЫГ ШИМТЭН СУДАЛ

Семинар чамайг өөрчлөг.

(1 Нифай 19:23-ыг үз.)



Ярилцах цаг

*“Би эцэг эхээ хүндэлж,
гэр бүлээ бэхжүүлэхийн
тулд хувь нэмрээ оруулна”
(Миний сайн мэдээний
жишгүүд).*

Хилари Уоткинс Лемон

Бодит түүхээс сэдэвлэв.

Тиймээ, хүн бүр ингэх хэрэгтэй. Ярилцах цагтай байцгаая” гэж ээж хэллээ.

Жоси ярилцах цагийг өдөржингөө хүлээдэг байлаа. Жоси орой бүр хоёр жаахан эрэгтэй дүү Бен, Уэстайгаа бас аав ээжтэйгээ том өрөөнд цуглаж, гэр бүлдээ болж байгаа үйл явдлуудын тухай ярилцдаг ажээ.

Маргааш өглөө сургууль дээрээ нийтэд сонордуулах зарлалыг өнөө орой уншиж дадлага хийхэд аав нь Жосид тусалъя гэжээ. Өглөөний зарлалыг нийтэд уншиж сонсгох нь Жосигийн сургууль дээрх нэгэн онцгой боломж байлаа. Жоси маргааш сургуулийн чанга яригчаар дуртай нэг дууныхаа багаахан хэсгийг тоглож, тухайн өдрийн үйл ажиллагаанууд болон үдийн хоолны цэсийг микрофон ашиглан зарлах ажээ.

Жоси уншин сонсгох зарлалаа давтан сургуулилах болсондоо хөл нь газарт хүрэхгүй шахам баярлан, том өрөөнд гүйж орлоо.

“Манай мундаг зарлагч хүрээд ирлээ!” Жоси дэргэдэх буйдан дээр дэвхрэх үед аав нь ингэж

хэлжээ. “Маргаашийн тухайд ямар бодолтой байна?”

“Сэтгэл их догдолж, бага зэрэг сандарч байна. Бүх сургуулийнхний өмнө эвгүй байдалд орчихвий дээ гэж айх юм” гэж Жоси хэлэхэд,

“Тийм учраас л бид хоёр дадлага хийх гэж байна шүү дээ” гэж аав нь хариулав. “За одоо зарлалаа унш. Би сонсоод юун дээр анхаармаар байгааг хэлж өгье.”

Жоси, “Баярлалаа, аав аа” гэв.

Зарлалыг аавтайгаа олон удаа уншлаа. Бүр хэчнээн удаа уншнаа Жоси тоолж байгаад сүүлдээ тоогоо алдчихсан гэнэ. Тэгээд тэр зарлалыг гэрийнхэндээ сүүлчийн удаа зогсож байгаад уншиж өглөө. Аав, ээж хоёр нь баяр хүргэв. Бен алгаараа Сюзийн гарын алгыг цохин баяр хүргэхэд

Уэс инээмсэглэн алгаа ташив.

Жоси өөртөө итгэлтэйгээр орондоо орлоо.

Маргааш өглөө нь бүх юм сайн боллоо. Жоси жаахан сандарсан ч, сургуулийн чанга яригчаар өөрийнхөө тоглосон хөгжмийг сонсоод инээмсэглэв. Тэр аавтайгаа дадлага хийсэндээ баяртай байв. Зарлалыг удаан боловч огт алдаагүй уншжээ.

Захирлын туслах, хатагтай Блейк “Чи үүргээ онцгой сайн биелүүллээ” гэв.

Жоси хичээл тарсны дараа автобус хүлээн зогсож байтал түүнээс ахмад нэг хөвгүүн хүрч ирээд, “Чи өнөө өглөө зарлал уншсан охин мөн үү?” гэж асуухад

Жоси инээмсэглээд, “Тийм ээ” гэв.



“Чи яагаад тэр дуут сонгосон юм бэ?” гэж нөгөөх хөвгүүн асуугаад, “Тэр чинь шал тэнэг дуу. Чи өглөөний зарлалыг ёстой балласан даа” гэх нь тэр. Тэгээд нөгөөх хөвгүүн Сюзийг эвгүй нэрээр дуудаж, найз нартайгаа чанга инээлдэв.

Жоси автобусны урд талын суудал дээр ганцаараа суулаа. Гэдэс нь өвдөж байх шиг санагдав.

Жосийг гэртээ ирэхэд ээж нь Уэстай тоглож байв.

“Ээж ээ, одоо ярилцахад тохиромжгүй цаг гэдгийг ойлгож байна л даа гэхдээ хоёулаа яг одоо ярилцаж болох уу” гэж Жоси хэлэхэд,

“Бололгүй яахав, Жоси. “Юу болоо вэ? Өглөөний зарлалд ямар нэг тусгүй зүйл болоо юу?” гэж ээж нь асуухад,

“Үгүй ээ. Би бүх зүйл сайн болсон гэж бодож байлаа. Гэтэл нэг хөвгүүн намайг шал тэнэг дуу сонгосон гэх юм. Тэр бас намайг үнэхээр эвгүй нэрээр дуудлаа” гэж Жоси хэлэв.

Ээж нь түүний өмнөх шалыг зүлгэж байлаа. Жоси шалан дээгүүр алхаж гараад суув. Ээж нь охиноо чанга тэврэв. Жоси тэр өдөр болсон бүх зүйлийн тухай, түүний дотор хатагтай Блейк түүнийг магтсан тухай ээждээ ярилаа.

“Тэр хөвгүүн найз нарынхаа хамт чамд бүдүүлгээр хандсанд ээж нь харамсаж байна.” “Гэвч чиний хүндэлдэг бусад хүмүүс, жишээлбэл хатагтай Блейк чамайг зарлалаа сайн уншсанд баяртай байсан нь лавтай. Аав ээж хоёр нь охиноороо их бахархдаг шүү. Чи их чармайсан, үр дүн нь ч гарсан шүү дээ!”

Жоси ээжийгээ дахин тэвэрлээ. “Баярлалаа,” ээж ээ. “Дотор онгойж, их сайхан боллоо” гэж Жоси хэлэв. Ямар ч үед ярилцах боломжтой байгаадаа Жоси баяртай байлаа. ■



Гэр бүлийн гишүүд хоорондоо илэн далангүй, элэгсэг, чин сэтгэлийн харилцаатай байхаас илүү чухал зүйл байдаггүй.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч М. Рассел Баллард, “Like a Flame Unquenchable,” *Лиакона*, 1999 оны 7-р сар, 103.





ГЭР БҮЛЭЭРЭЭ ЯРИЛЦАЦГААЯ

Гэр бүлээрээ “ярилцах цаг”-тай байх талаар цөөн зөвлөмж өгье.

- Гэр бүлээрээ ярилцаж байх хэдэн минутыг өдөр бүр гаргаж байхыг эцэг эхээсээ гуй.

Хоолны үеэр эсвэл өдөр бүр тогтсон цагаар ярилцаж болно.

- Хүн бүр ээлжлэн ярьж, анхааралтай сонсох нь чухал. Ярилцахад хүн бүрийг оролцуул!

- Гэр бүлийн гишүүдийн саналд хүндэтгэлтэй ханд. Хүн бүрийн ярьж байгаа зүйл чухал гэдгийг сана.

ЯРИАН ТОГЛООМ

Ярилцах цагийн зарим санаа хэрэгтэй байна уу? Дараах тоглоомуудаар тоглож үз:

Чихмэл тоглоом орхих: Хэрэв танайх олон хүнтэй, ээлжээр ярихад хүндрэлтэй бол хэн ярихыг шийдэхийн тулд чихмэл тоглоом орхиж шод. Чихмэл тоглоомыг авсан хүн хэлэх зүйлээ хэлээд ярих ээлжээ хүлээж байгаа гэр бүлийн дараагийн гишүүнд шидэж өгнө.

Ярилцлага авагч: Гэр бүлийн гишүүдийг хоёр хоёроор нь бүлэг болгон хувааж, ээлжээр ярилцлага авагч болгон тоглуул. Нөгөө хүнээсээ асуух хэдэн асуулт бодож олоод асуусны дараа өөрөөсөө асуултууд асуухыг түүнээс хүс. Ярилцлагадаа микрофон буюу дуу хураагч ашиглаж болно.

Чи яах вэ? Хэрэв . . . (тэгвэл) “чи яах вэ?” гэсэн асуултуудыг гэрийхнээсээ ээлжлэн асуу. Жишээ нь, “Хэрэв чи төөрвөл яах вэ?” “Хэрэв чи дэлхийн хаа нэгтээ явах болбол яах вэ” гэсэн асуултууд байж болно.




НЭГ НЬ НЭГ УДАА ЭЦЭГ ЭХДЭЭ ТУСАЛ

Гэр бүлээрээ хамт ярилцах нь хөгжилтэй ч бас эцэг эх, хүүхдүүд нэг нэгэнтэйгээ хамт байж цагийг өнгөрүүлэх нь чухал юм. Өдрийн аль нэг цагаар хүүхдүүдтэйгээ ганцаарчлан уулзаж ярилцах нь чухлыг сана. Нэг хүүхдээ нэг удаа гэрийн нэг ажил хийхэд өөртөө туслах юмуу ямар нэг ажилд өөртэйгөө хамт явахыг хүсч болно, эсвэл ерөөндөө урьж ирүүлэн хэдэн минут ярилцаж болно. Хэдхэн минут хамт байх нь чухал яриа өрнүүлэхэд хөтөлж болно.



Тэр ҮХЛИЙН ХҮЛЭЭСИЙГ “ЭВДСЭН”



Далын
Ахлагч Патрик Керон

“Тэд үхлийн хүлээсийг тасчсан Христээр дамжин мөнх амьдралтай болно” (Мозая 15:23).

Манай хүүхдүүдийг бага байхад бид нэг орой гэр бүлээрээ судар уншиж байлаа. Бид Аврагчийн тухай уншиж, Тэр яагаад ямар ч алдаа гаргадаггүй байсан тухай ярилцаж байв.

Тэр үдэш манай эхнэр гурван настай охин Сюзигээ унтуулахаар ор уруу нь аваачив. Сюзи ээж рүүгээ харснаа, “Ээж ээ, Есүс нэг алдаа гаргасан байна ш дээ” гэв.

“Энэ чинь юу гэсэн үг вэ?” гэж ээж нь асуув.

“Есүс нэг юм эвдсэн байна ш дээ” гэж Сюзи хэллээ.

Ээж нь гайхсанаа, “Тэр юу эвдсэн юм бэ?” гэж асуухад,

“Есүс үхлийн хүлээсийг “эвдсэн” гэж Сюзи хариулав.

Ээж нь Сюзитэй хамт Хүүхдийн Хэсгийн нэгэн дууг олон удаа дуулж байсан болохоор, “Хаврын нэгэн сайхан өдөр Есүс Христ булшийг орхин, үхлийн хүлээсийг эвдсэн юм” гэсэн үгсийг охин нь цээжилснийг мэджээ.¹ Үхлийн хүлээсийг эвдсэн гэдэг нь бид бүгд үхлийн дараа дахин амьдрахын тулд Есүс

амилсан юм гэсэн утгатайг ээж нь Сюзид тайлбарлаж өгчээ.

Бид бүгдийн хувьд Цагаатгал ямар учир холбогдолтойг Лизи, Сюзи, Эмма гурван охиндоо заах олон боломжийг дээрх яриа эхнэр бид хоёрт олгосон юм. Есүс үхлийн хүлээсийг “эвдсэн” болохоор Сюзигийн зөв байлаа. Харин энэ нь алдаа байгаагүй юм. Энэ бол Түүнээс бидэнд өгсөн хамгийн агуу бэлэг мөн. (Сургаал ба Гэрээ 14:7-г үз.)

Бид болон бидний гэр бүлүүд зөв шударга амьдарч, Тэнгэрлэг Эцэгтэйгээ дахин амьдарч болохын тулд Аврагч үхээд дахин амилсан билээ. Хэрэв бид зохистой байвал үхэшгүй байдал болон мөнх амьдралын адислалуудыг хэзээ нэгэн цагт хүртэх болно. Есүс үхлийн хүлээсийг тасалсанд би баяртай байдаг. ■

ЭШЛЭЛ

1. “On a Golden Springtime (Хаврын нэгэн сайхан өдөр),” *Children’s Songbook*, 88.



Хүүхдийн Хэсгийн энэ сарын сэдвийн тухай илүү ихийг мэдэхийн тулд та нар энэ хичээл болон үйл ажиллагааг ашиглаж болно.

ЕСҮС ХРИСТ

Надад зөвийг сонгохыг заадаг

Таннерын хувьд Христийн Амилалтын баяр энэ жил өөр байх болно. Өвөө нь өөд болсон учраас Таннер энэхүү онцгой өдрийг өвөөтэйгөө хэзээ ч дахин тэмдэглэхгүй болжээ.

Харин Христийн Амилалтын Баярыг Хүүхдийн Хэсэгтээ тэмдэглэнэ гэдгийг Таннерт хэлсэн ажээ. Учир нь Христ амилсан шүү дээ! Түүнийг амилахад Сүнс нь

биетэйгээ үүрд дахин нэгдэж, хэзээ ч үхлийг дахин үзэхгүй болсон юм. Есүс амилсан учраас нэгэн цагт хүн бүр, түүний дотор өвөө нь амилах болно гэдгийг Таннер мэдсэн ажээ.

“Есүс, бидний найз Есүс амилсан. Баяр баясал бидний зүрх

сэтгэлийг дүүргэлээ;

Тэр дахин амьд!”

хэмээн дууддаг Христийн Амилалтын Баярын дуу Таннерын зүрх сэтгэлийг

догдуулжээ.¹ Таннер энэхүү сайхан мэдээг хүн бүхэнтэй хуваалцахыг хүслээ. Тэрээр Христийн Амилалтын Баярын өмнө хөршүүдийнхээ хаалган дээр хаврын цэцгийн жижигхэн баглааг Есүсийн Амилалтын тухай судрын шүлэгтэй хамт тавихаар шийдсэн гэнэ. Хөршүүд нь Христийн Амилалтын өглөө түүний бэлгийг олоод нүүрэнд нь хэрхэн инээмсэглэл тодрохыг тэр төсөөлөн бодлоо. ■

Эшлэл

1. “Есүс Амилсан,” *Children's Songbook*, 70.



Дуу ба судар

- Иохан 13:15
- Есүс Христийн тухай чиний сонгох дуу
- *Children's Songbook* номноос зөвлөмж болгох дуунууд: “Есүс амилсан” (70), “Есүс үнэхээр амилсан уу?” (64), “Бид дахин амилахын төлөө Тэр хальсан” (*Лиахона*, оны 4-р сар, 2005, Н13), “Христ амилсан, Хосанна!” (*Лиахона*, оны 4-р сар, 2003, Н8-9)

ЭҮН ТАЛД: ЗУРАГ: ЧИЭГЛЭЛИЙГ: СИМИНИ БЛОКЕР; ПОП МАНЫ УРАН ЗУРАГ © 1999 ИР; БАРУУН ТАЛ: ХРИСТ БА ХҮҮХДИЙН НОРМОНЫ НОМ, ДЕЛ ПАРСОН © 1995; АМИЛАЛТ, ХАРИ АНДЕРСОН © ИР; ЕСҮС ХРИСТ АМЕРИЖ ТҮВД ЗОЧИЛСОН НЬ, ЖОН СКОТ © ИР; ГЭНГЭГ ОДСОН НЬ, ХАРИ АНДЕРСОН © ИР; ХРИСТ ДЭЛХИЙН БАРУУН ХАГАСТ ОЧСОН НЬ, АННОЛЬД ФРАЙБЕРГ © 1951 ИР; ВМИРИЙГ ТАГ, ЖЕЛЛЭГ ХАРАГ ТУН, ХАРИ АНДЕРСОН © ИР; ЦЭДГИЙГ АВЧИР, ГАРРИЛ КАПТ © 1999, ХУЛБАРТААЖ БОЛГОХУЙ; ТИЙМЭЭС А НАР ЯВЖ, БҮХ ҮНДЭСНГҮДЭД ЗАА, ВУ ХАРИ АНДЕРСОН © ИР

ЗС үйл ажиллагаа Энэ газар дэлхийд хаана байдаг вэ?







Есүс Христ амилсныхаа дараа зөвхөн Иерусалим дахь хүмүүст үзэгдсэн төдийгүй бас Америк тив дэх зөв шударга хүмүүс дээр зочилж очсон юм. Зураг бүрээс уг үйл явдал болсон газар уруу (Иерусалим эсвэл Америк тив) гэр бүлээрээ хамтран сугам тат. Дараах зургуудад болсон үйл явдлуудын тухай илүү тодорхой мэдэхийн тулд судруудыг ээлжээр унш.




И е р у с а л и м

Чи ч мөн адил

Чи бас Таннер шиг Христийн Амилалтын Баярын баглаа цэцэг хийж чадна. Тэгш өнцөгт цагаан буюу өнгөтэй цаас ашиглан, доорх дэс дарааллаар хий. Найздаа эсвэл гэр бүлийнхээ аль нэг гишүүнийг дайлах буюу түүнд онцгой бэлэг барихын тулд тэгш өнцөгт цаасан уутыг жижиг цэцгүүдээр дүүргэ!



Есүс хүүхдүүдийг адислав
3 Нифай 17:11–25



Есүс Магдалын Мариад харагдав
Иохан 20:14–18



Есүс Америк тивд очиж заав
3 Нифай 11:8–11



Есүс тэнгэрт одов
Үйлс 1:9–11



Есүс зөв шударга хүмүүст үзэгдэв
3 Нифай 11:1–8



Есүс шархаа Төлөөлөгчдөдөө үзүүлэв
Лук 24:36–40




Есүс нифайчуудын цэдгийг авчрахыг хүсэв
3 Нифай 23:7–13



Есүс Төлөөлөгчдөдөө үзэгдэв
Матай 28:16–20

А м е р и к т и в





Би Есүс шиг байхыг хичээдэг

Хялбаршуулсан

Шийдэмгий ♩ = 104-116

Үг аяыг Жэнис Кэп Перри

1. Би Есүс шиг байх - ыг хи - чээ - дэг. Би Түү - ний зам -
(2. Би) хөрш - өө хайр - лахыг хи - чээ - дэг. Би найз - даа үйлч -

ыг дага - даг. Би хэлж, хийж буй зүйл - дээ
лэхийг сур - даг. Би Есүс да - хин и - рэх

Түү - ний адил хайр - ла - хыг хи - чээ - дэг. Бу -
өд - рийг ба - яр - тай - гаар хү - лээ - дэг. Би

© 2009 Жэнис Кэп Перри. Энэ дууг хувиараа, арилжааны бус зорил гоор,
сүм дээр болон гэр оронд ашиглахын тулд хуулбарлаж болно.
Энэ тэмдэглэл хуулбар бүр дээр байх ёстой.

руу сон-голт хий-хээр у - руу та-тагда - хад, Намуун зөө - лөн дуу
Түү - ний заа - сан зүйлс-ийг сана - хыг хичээ - дэг. Тэг - эхэд, А - риун

хоо - лойн шив-нээг сон - сохыг хи - чээ - дэг. “Бие би-еэ хайр - ла Е -
Сү - нс ми - ний бо - долд ин - гэж хэл - дэг:

сүс - ийн а - дил. Бүх зүйл-ээр - ээ эел - дэг байх - ыг хи -

чээ. Үйлс, бо - дол-доо зөө - лөн байж, хайр - аа - раа ханд, Эд -

гээр зүйл - сийг Е - сүс заа - сан.” _____ 2. Би сан.” _____

Нэр болон ИТГЭЛ НЭГТ ЭГЧ ДҮҮ ХОЁР

Хетер Вригли

Сүмийн сэтгүүлүүд

Мария Урсу, Диана Урсу нар эгч дүүс төдийгүй бас дотны найзууд ажээ. Диана 10-тай бол Мария өнгөрсөн наймдугаар сард 12 хүрчээ. Энэ хоёр охин Румынд амьдардаг бөгөөд тэндхийн Сүм 3000 орчим гишүүнтэй. Тэд сүмд явж, судар уншин, залбирснаар Есүс Христэд итгэх итгэлээ бат бөх болгодог ажээ.

“Би сүмд явснаар Бурханд итгэх итгэлтэй болсон” гэж Мария ярилаа. Тэр нэг өдөр шалгалт өгөхдөө Есүс Христийн нэрээр Тэнгэрлэг Эцэгт хандан залбирч, тусламж гуйжээ. Мария сайн дүн авахаараа Тэнгэрлэг Эцэг түүнд тусалсан юм шиг санагддаг гэнэ.

Итгэлтэй болоход нь Мормоны Ном түүнд тусалдаг гэж Диана хэллээ. “Би Мормоны Номыг өдөр бүр уншдаг. Тиймээс өдрийг сайхан өнгөрүүлдэг” гэж тэр ярив. Түүний дуртай судрын түүх бол Иосеф Смитийн түүх юм. “Иосефыг залбирахад Бурхан, Есүс Христ хоёр түүнд тусалсан” гэж тэр охин хэллээ. ■



ШОКОЛАД

Энэ хоёр эгчийн дуртай амттан бол шоколад: Мария, Диана хоёул шоколадтай бялуунд дуртай гэнэ.

ДУРТАЙ ДУУ НЬ
 Мария, Диана хоёр төгөлдөр хуур тоглох дуртай. Мариагийн дуртай дуу бол "Бие биенээ хайрла." Энэ бол бусад хүмүүсийг хайрлах тухай Есүсийн тушаал юм. Диана энэ дууг бараг төгс тоглох чадна. Харин төгсгөл нь их хэцүү гэж тэр ярив.



БИ АРИУН СҮМ ХАРАХ ДУРТАЙ

Мариа, Диана хоёр хэзээ нэгэн цагт ариун сүмд гэрлэхийг хүсдэг ажээ. Тэд Украины Киевийн Ариун сүмийн дүүрэгт амьдардаг.

Диана зохих насанд хүрмэгц нас барагсдын өмнөөс баптисм хийлгэхээр Украины Киевийн ариун сүмд явах болно. Мариа одоо ариун сүмд явах нас хүрчээ. Ариун сүм 500 бээр (805 км) хол оршдог.

ГЭР БҮЛ НЭГДҮГЭЭРТ

Мариа, Диана хоёр аав, ээждээ хайртай. "Биднийг өвдөхөд ээж тун сайн асардаг" гэж Мариа хэлэв. "Аав биднийг сургуульд хүргэж өгдөг" гэж Диана хэллээ.

ДУУЛАЛ

Дианагийн дуртай дуулал бол "Иудейн нутаг алс хол хээр талд" дуулал. Энэ дуулалд Есүс Христ төрсөн тухай гардаг. Румыны гишүүд Сүмийн дууллын ногоон номыг ашигладаг ажээ. "Имнури" гэдэг нь румын хэлээр "дуулал" гэсэн утгатай.





Энэ сэдвээр Арванхоёр
Төлөөлөгчийн Чуулгын
Ахлагч Ричард Г. Скотт
бодлоо хуваалцаж
байна.

Надад зориулсан ТЭНГЭРЛЭГ ЭЦЭГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ дагахын тулд би юу хийж чадах вэ?



Судруудыг судалж, аз жаргалын агуу
төлөвлөгөөний тухай мэд.



Өнгөрсөн үеийн болон өнөөгийн бошиглогчдын
дуу хоолойг сонс.



Ариун Сүнсний өдөөлт болж ирдэг дотоод
сэтгэлийн мэдрэмжүүдийг дага.



Хэрэг гарсан үед эцэг эх болон санваартны
удирдагчдаасаа зөвлөгөө, удирдамж хүс.

"The Joy of Living the Great Plan of Happiness," Ensign, 1996 оны 11-р сар, хуудас 75-аас авав.

САЙН МЭДЭЭНИЙ МИНИЙ ЖИШГҮҮД

Би Тэнгэрлэг Эцэгийн надад зориулсан төлөвлөгөөг дагана.

Би баптисмынхаа гэрээг санаж, Ариун Сүнснийг сонсоно.

Би зөвийг сонгоно. Буруу зүйл хийсэн үедээ
наманчилж болно гэдгийг би мэддэг.

Би Тэнгэрлэг Эцэгт, бусдад болон өөртөө үнэнч байна.

Би Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийн нэрийг
хүндэтгэлтэйгээр хэрэглэнэ. Би хараал хэлэхгүй, муухай үгс хэрэглэхгүй.

Би Хүндэтгэлийн өдөр Тэнгэрлэг Эцэг болон
Есүс Христтэй ойртуулахад туслах зүйлсийг хийнэ.

Би эцэг эхээ хүндэтгэн, гэр бүлээ бэхжүүлэхэд
өөрийн хувь нэмрээ оруулна.

Би сэтгэл санаа болон бие махбодоо ариун нандин,
цэвэр байлгаж, өөрт хортой зүйлсийг хүртэхгүй.

Би Тэнгэрлэг Эцэгтээ болон өөртөө хүндэтгэл үзүүлж даруухан хувцаслана.

Би зөвхөн Тэнгэрлэг Эцэгийн таалалд нийцэх зүйлсийг уншиж, үзнэ.

Би зөвхөн Тэнгэрлэг Эцэгийн таалалд нийцэх хөгжим сонсоно.

Би сайн найзуудыг эрэлхийлэх бөгөөд бусадтай эелдэг харьцана.

Би ариун сүмд орохын тулд мөн мөнхийн гэр бүлтэй болоход
өөрөөсөө хамаарах зүйлийг хийхийн тулд зохистой амьдарна.

БИ БУРХАНЫ ХҮҮХЭД

Тэнгэрлэг Эцэг надад хайртайг би Түүнд хайртай гэдгийг би мэддэг.

Би Тэнгэрлэг Эцэгт хандан хэзээ ч хаана ч залбирч болно.

Би Есүс Христийг дурсан санаж, түүнийг дагахыг хичээж байна.

Христийн Амилалтын баяр


Бодит түүхээс сэдэвлэв.





Христийн Амилалтын алхмууд

Есүс Христ цовдлогдоод амилахынхаа өмнөх өдрүүдэд онцгой газруудад чухал ажил хийсэн юм. Тэр хаана очиж, юу хийснийг мэдэхийн тулд мөрөөр нь дага.



2. Есүс Иерусалимд илжиг унан ирэв. Олон хүн Түүнийг харсандаа баяртай байлаа.


6. Христ амилжээ!

5. Есүс цовдлогдов.

1. Есүс Чидуний Уулан дээр хүмүүст заав.

3. Есүс ариун сүмд өвчтэй хүмүүсийг эдгээв.

4. Есүс Гетсеманий цэцэрлэгт Тэнгэрлэг Эцэгт хандан залбирч, бидний гэм нүглийн төлөө зовон шаналсан билээ.



Дэлхий даяарх удирдагчдын сургалтаас жинхэнэ өсөлтөнд хүрэх замыг тодруулж өглөө

Хеадар Витл Ригли

Сүмийн мэдээ ба үйл ажиллагаанууд

Сүмийн удирдагчид 2012 оны 2-р сарын Дэлхий даяарх удирдагчдын сургалтаар “жинхэнэ өсөлт”-ийн чухал болох мөн үүнийг хэрхэн амжилттай хэрэгжүүлэх талаар тайлбарласан.

Тэргүүн Зөвлөлийн Хоёрдугаар Зөвлөх Ерөнхийлөгч Диетер Ф.Угдорф, Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүд, Далын Ерөнхийлөгчийн зөвлөл болон Сүмийн Туслах бүлгүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлийнхөн дэлхий даяарх удирдагчидтай хамт энэхүү сургалтанд оролцсон юм.

“Сүмийн хэллэгэнд өсөлт гэдгийг шинэ гишүүн хэмээн тодорхойлж болно. Харин. . . *жинхэнэ өсөлт* гэдэг нь идэвхтэй гишүүдийн өсөлтийг тодорхойлдог” хэмээн Ерөнхийлөгч Угдорф тайлбарласан.

“Сайн мэдээний хувийн, насан туршийн хөрвөлт нь хувь хүн ба гэр бүлийн итгэлийг өсгөхөд жинхэнэ өсөлт гардаг” хэмээн Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч М.Рассел Баллард нэмж хэлсэн.

Өсөн нэмэгдсэн итгэлтэй байдалд өдөр тутмын залбирал, судраас суралцах, гэр бүлийн цуглаан, гэр бүл дэх хайр мөн Цагаатгалтай холбоотой хувийн туршлага зэрэг амархан хэмжигдэж болдоггүй зүйлсүүд ордог гэж Ерөнхийлөгч Угдорф өгүүлсэн.

Бид Есүс Христийн сайн мэдээний энгийн бөгөөд сайхан байдлыг өөрсдийн нарийн төлөвлөгөөний жагсаалтаар төвөгтэй болгох нь олонтаа. Гэсэн хэдий ч хэрэв бид сайн мэдээний зорилго юу вэ гэдэгт анхаарлаа хандуулах аваас ихэнх төөрөгдөл маань замхран одох болно.

Уг нэвтрүүлэг нь “яагаад” гэдэг асуултанд хариулах гол сургаал ба зарчмуудад чиглэсэн байв.

Сайн мэдээний зорилгийн талаарх зөв асуултууд нь биднийг энэ нь хэнд хамааралтай, энэ талаар юу хийх хэрэгтэй, хэзээ хийх хэрэгтэй, яагаад эдгээр зүйлийг хийх ёстой болон хэрхэн хийх ёстой гэдэг шийдлүүдэд чиглүүлэх болно гэж Ерөнхийлөгч Угдорф хэлсэн.

Төлөвлөгөөн дэх гэрлэлт ба гэр бүл

“Сүм бол гэр бүлүүдээс бүрддэг юм” хэмээн Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч Ерөнхийлөгч Бойд К.Пакер хэлсэн. Тойрог ба гадас хоёр нь холбоотой байдаг. Бид Сүм дэх жинхэнэ өсөлтийг гэр бүлүүдийн талаар ярилцахдаа олж харж чаддаг.

Тэрээр “нөхөр буюу эцэг хүн бүр гэр бүлдээ санваарын удирдагч нь байж, зөв шударга байдалд гэр бүлээ удирдах ёстой” гэж хэлсэн. Үүнтэй адилаар санваарын алба өөр өөр байдаг боловч бүх санваарын удирдагчид зүй зохистойгоор удирдах хэрэгтэй. Учир нь бүх санваар аттагч ижил эрхтэй (С ба Г 1:20-г үзнэ үү).

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Рассел М.Нелсон “Бүтээгчийн төлөвлөгөөний төвд байдаг Түүний хүүхдүүдийн мөнхийн хувь заяаны төлөө” гэр бүлийг хүчирхэгжүүлж, хамгаалахын тулд эхнэр, нөхөр ба эцэг, эхчүүд хайр, наманчлал болон залбирлын харилцааг үүсгэх хэрэгтэй гэж тэмдэглэн хэлсэн (“Тэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг” *Лиахона* ба *Ensign*, 2010 оны 11-р сар, 129).

Мөн тэрээр “зарим зүйлсийг хийгээгүй аваас Их Эзэний ирэлтээр бүх дэлхий бүрмөсөн устгагдах болно хэмээн ариун судруудад гурвантаа анхааруулсан байдаг” гэж хэлсэн. Эдгээр бүх анхааруулга нь ариун сүмийн ёслолоор лацдан холбуулаагүй гэр бүлүүдтэй холбогдсон байдаг. Эдгээр авралын ёслолгүйгээр Бурханы алдар сууг ойлгож чадахгүй.



Бурханы хүүхдүүдийн эцсийн зорилт болох үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралд хүрэхийн тулд бидний гэр орон, тойрог, гадас мөн Сүмд жинхэнэ өсөлт явагдаж байх ёстой.

Сайн мэдээг хэрэгжүүлэх нь

Жинхэнэ өсөлт ба хөрвөлт нь сайн мэдээг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлсэнээр ирдэг. Асуулт, хариултын ярилцлагаар Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Л.Том Перри, ахлагч Д.Тодд Кристофферсон нар ариун сүмийн гэрээнүүдийг хийж мөн сахих нь сайн мэдээг жинхэнэ ёсоор хэрэгжүүлж байгаа хэрэг мөн гэдгийг тайлбарласан. Гэрээнүүдэд дуулгавартай байх нь энгийн хүнийг аажмаар Гэгээнтэн болгон өөрчилж чаддаг.

Бусдад туслах нь сургаалийг хэрэгжүүлэх бас нэгэн чухал хэсэг юм. Гишүүд нь хувь хүн болон Сүмийн гишүүний үүднээс материаллаг ба сүнслэг хэрэгцээтэй тэдгээрийг аврахын тулд туслах үүрэгтэй.

Бид ядуус болон гачигдалтай хүмүүсийг халамжаахын тулд бусад шашны хүмүүс түүнчлэн үйлчлэл үзүүлдэг байгууллагуудтай нэгдэхдээ тээнгэлзэх ёсгүй хэмээн ахлагч Кристофферсон хэлсэн. Санваартны удирдагчид эдгээр үйл ажиллагаанд тэргүүлэн оролцох ёстой ба номлогчид болон гишүүд тэдэнд тусалж дэмжих үүрэгтэй.

Ярилцлагаар гэр бүлүүдэд үйлчлэх, Мелкизедек санваар атгагчдыг хүчирхэгжүүлэх болон залуучуудын итгэл, гэрчлэлийг өсгөхөд туслах зэрэг асуудлыг голлон авч үзлээ. Энэ ярилцлаганд Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Баллард, ахлагч Нейл Л.Андерсен, Далын ерөнхийлөгчийн

2012 оны 2-р сарын Дэлхий даяарх удирдагчдын сургалтын нэг хэсэг болсон ярилцлага дээр Арванхоёр Төлөөлөгчдийн Чуулгын ахлагч М.Рассел Баллард ярьсан.

2-р сарын Дэлхий даяарх удирдагчдын сургалтын үеэр Тэргүүн Зөвлөлийн Хоёрдугаар Зөвлөх Ерөнхийлөгч Диетер Ф.Угдорф “бидний хийх эхний зүйл бол ойлгох” гэж хэлсэн. Хоёрт ойлгосон зүйлээ үйлдэл болгох. . . . Бурханы үгийг сонссон атлаа амьдралдаа хэрэгжүүлэхгүй байх нь сайн зүйл биш ээ.

Тэрээр Сүмийн удирдагчдыг удирдагчдын нэвтрүүлгийн дараа, дуудлагаа хийх явцдаа гурван зүйлийг хийхийг хүссэн.

1. Хувь хүн болон зөвлөлийн гишүүний хувиар хүлээн авсан заавраа залбиралтайгаар тунгаан бодож, яагаад бусдад үйлчилдэг болохоо ойлгох.
2. Тунгаан бодож, ярилцсанаа дараа хийх зүйлсээ тодорхойлох. Авах арга хэмжээ нь байгуулага, тойрог, гадас, гэр бүл буюу хувь хүмүүсийн нөхцөл байдал, хэрэгцээнд тохирсон байна.
3. Дуудлага болон үүрэг хариуцлагынхаа дагуу хийхээр шийдсэн зүйлсийнхээ талаар зөвлөлийнхөө хурал бүр дээр авч хэлэлцэж байх.

зөвлөлийн ахлагч Роналд А.Расбанд, Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгч Элайн С.Далтон эгч, Хүүхдийн Хэсгийн ерөнхий ерөнхийлөгч Роземэри М.Виксом эгч нар оролцдоо.

Ахлагч Расбанд бүх удирдагчид гишүүдийг бүрэн идэвхтэй болгоход гар бие оролцох ёстой гэлээ. Мөн Ахлагч Андерсен залуучууд бусад залуучуудаа эргэж идэвхтэй болж, бат бэх итгэлтэй болоход нь илүү их оролцох хэрэгтэй гэдгийг онцлон тэмдэглэв.

Жинхэнэ өсөлтөнд хүрэх нь

Сайн мэдээг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлсэнээр жинхэнэ өсөлт ирдэг гэж Ерөнхийлөгч Угдорф цохон тэмдэглэсэн.

Эдгээр сэдвийг эргэцүүлэн бодохдоо та яагаад үйлчлэл хийдэг болохоо мөн хувь хүн бас зөвлөлийн гишүүний хувьд юу хийх ёстой вэ? гэдгээ өөрөөсөө асуух хэрэгтэй гэж тэр хэлсэн.

Илүү ихийг сур

Хувь хүмүүс уг нэвтрүүлгийг lds.org/study/other-addresses-н **Worldwide Leadership Training** уруу нэвтэрч олон хэл дээр үзэж, сонсож, хэвлэж мөн хуулбарлан авч болно. ■

Өгүүлэл ирүүлэх уриалга

Христийн мэндэлсний баярын танай ёс заншлын талаар *Лиахона* сэтгүүлийнхэн уншихыг хүсч байна.

- Танай гэр бүлийнхэн энэ баярыг хэрхэн тэмдэглэдэг вэ?
- Энэ баярыг тэмдэглэдэг тусгай ёс заншил байдаг уу?
- Өөрийгөө болон гэр бүлийнхнээ Аврагчид ойртуулах ямар уламжлалыг та сэдсэн бэ?
- Христийн мэндэлсний баярын талаарх ялангуяа уламжлалт зан заншилтай холбогдсон дурсамжаасаа бидэндтэй хуваалцана уу?

2012 оны 6-р сарын 1-ний дотор *Лиахона* сэтгүүл рүү liahona@ldschurch.org гэсэн хаягаар дурсамж болон саналаа илгээнэ үү. ■

BibleVideos.LDS.org вэб сайт бол дэлхийд барьсан бэлэг юм

2011 оны Христийн мэндэлсний баярт зориулсан онцгой цугларалтын үеэр Сүмийн удирдагчид Есүс Христийн амьдрал Ариун Библийн кино вэб хуудсыг дэлхийн хүмүүст өргөн барих бэлэг хэмээн танилцуулсан.

BibleVideos.Lds.org-д тэнгэр элчүүд Христийн төрөлтийг зөгнөн хэлсэн үеэс эхлээд Аврачийн Дахин Амилалт хүртэлх Христийн амьдралыг харуулсан богино хэмжээний кинонууд байдаг.

Онцгой цугларалтын үеэр Тэргүүн Зөвлөлийн Нэгдүгээр Зөвлөх Ерөнхийлөгч Хенри Б.Айринг уг вэб сайтын талаар зарласан.


“Эдгээр богино хэмжээний кинонууд нь судруудын дагуу хийгдсэн бөгөөд судруудтай адил амар амгаланг танд авчирдаг. Дэлхий ертөнцийг өөрчилсөн үйл явдлууд гардаг

эдгээр киног үзсэнээр танд итгэл болон Ариун Сүнсээр дамжин гайхалтай сэтгэгдэл төрөх болно.”

Кинонд ашигласан материалуудыг Гошен Ютагийн шинэ ХҮГ-н зураг авалтын студийн авсан зурагнуудаас ашигласан. Тэр студид 2011 оны 8-р сараас Шинэ Гэрээний судрын номын сангийн хөтөлбөр эхэлсэн юм.

Библийн Хаан Жеймсийн хувилбараас эш татан Христийн амьдралыг харуулсан 100 гаруй богино хэмжээний киног бүтээх болно.

Уг вэб сайтыг зөөврийн хэрэгслээр (гар утас мэт) англи хэлээр үзэх боломжтой (BibleVideos.Lds.org), испани хэлээр (videodelabiblia.org), португали хэлээр (videosdabiblia.org). Мөн iPad ашиглан Ариун Библийн түүхийг үзэх боломжтой боллоо. ■



Яваандаа Шинэ Гэрээн дэх Христийн амьдралыг харуулсан 100 гаруй богино хэмжээний кино "Ариун Библи дэх Есүс Христийн амьдрал кино" вэб сайтад тавигдах болно.

Ахлагч Кристофферсон, ахлагч Женсен нар Аргентиний Сүмийн гишүүдэд заав

2011 оны 11-р сарын 12-ны бямба гарагт Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Д.Тодд Кристофферсон болон Далын Ерөнхийлөгчийн зөвлөлийн ахлагч Жэй Э.Женсен нар Аргентиний Солтийн залуучууд, залуу насанд хүрэгчид, санваарын удирдагчид, номлогч болон гишүүдэд хандан үг хэлэв.

Мөн тэнд Өмнөд Америкийн өмнөд бүсийн ерөнхийлөгч ахлагч Мервин Б.Арнолд, түүний гэргий Девонна, Бүсийн далын ахлагч Рубен Спитал нар байв. Ахлагч Кристофферсоны эхнэр Кати болон ахлагч Женсены эхнэр Лона нар мөн уг цуглаанд оролцов.

Ахлагч Кристофферсон, ахлагч Женсен нарын оролцсон уг цуглаанд 1300 орчим залуучууд болон тэдний эцэг эхчүүд оролцов. Аргентин даяар 10,000 гаруй гишүүд 70-н гадасны төвд уг нэвтрүүлгийг үзсэн байна.

Өмнөд Америкийн өмнөд бүст ерөнхийлөгчөөр үйлчилж байсан ахлагч Женсен “хэрэв та нар хэлсэн зүйлсээс маань юу ч санахгүй байвал миний Бурханы үнэн бошиглогч хэмээн гэрчилдэг Ерөнхийлөгч Томас С.Монсоны хэлсэн ‘гаргах шийдвэрүүд нь хувь заяаг тодорхойлдог’ гэсэн үгийг санаарай” хэмээн хэлсэн.

Бидэнд шийдвэр гаргах сонгох эрх, эрх мэдэл байдаг. Тэрхүү шийдвэрүүдээрээ бид хувь заяагаа сонгодог.

Тэрээр согтуугаар жолоо бариад осолд орж хоёр хүний амийг авсан нэг найзынхаа тухай өгүүлсэн. Тэр залуу байхдаа номлолд явахын тулд гэрлэхээ хойшлуулж байсан тухайгаа найзынхаа түүхтэй харьцуулан ярьсан.

“Номлолоос буцаж ирээд бид ариун сүмд гэрлэсэн. Бид гэрээ хийсэн бөгөөд долоо хоног бүр үүнийгээ шинэчилдэг. Бид хувь заяагаа тодорхойлох шийдвэрийг гаргасан юм” гэж тэр яриу.

Дараагаар нь Кристофферсон эгч гэрээнүүдийг сахиснаар адислагддаг тухай гэрчлэлээ хуваалцаж, ахлагч Кристофферсон цуглааныг өндөрлөж үг хэлэв.

“Та нарт хэрэгтэй зүйл бол хайр ба итгэл юм. Бидний гэрлэлт, гэр бүл, ажил мэргэжилд итгэлтэй байх л тусалдаг” хэмээн ахлагч Кристофферсон хэлсэн.

Тушаалууд нь бидний амьдралыг чиглүүлж, хамгийн чухал зүйлийг олж авахад тусалдаг гэдгийг онцлон хэлэв.

Дараа нь тэрээр залуучууд болон тэдний эцэг эхчүүдэд *Залуучуудын бат бөх байдлын төлөө товхимол*

ЗУРГИЙГ ЖЕЙМС ДАДРУМПО



дээр байдаг зөвлөгөөнүүдийг дагах амлалт үүрэг авахыг зөвлөв.

“Эцэг эх нь түүнтэй нэг зарчмаар амьдардаг гэдгийг мэдсэнээр таны хүүхэд илүү их хүч чадлыг олох болно” гэж тэр хэлэв.

Бараг 50-н жилийн өмнө Аргентинд номлолд үйлчилж байсан ахлагч Кристофферсон Аргентиний гишүүдэд хайраа илэрхийлэн яриагаа өндөрлөв.

Ахлагч Кристофферсон, ахлагч Женсен нар Солтод байх хугацаандаа мөн орон нутгийн номлогчид болон ганц бие залуу насанд хүрэгчидтэй уулзаж Ах нарын хайрыг дамжуулав.

Өнөөгийн Төлөөлөгчдийн үйлчлэлийн тухай болон Бошиглогчид, Төлөөлөгчдийн хэлсэн үгсийг LDS.org-с уншина уу. ■

Ахлагч Кристофферсон, ахлагч Женсен нар 2011 оны 11-р сарын эхээр Аргентиний Ресистенсия Номлолын номлогч нар хандан үг хэлсэн.



Сүмийн 136 дахь ариун сүм болох Гватемалын Кесальтенанго ариун сүмийг 2011 оны 12-р сарын 11-нд Ерөнхийлөгч Диетер Ф.Угдорф онцгойлон адислав.

Гватемалын Кесальтенанго ариун сүмийг онцгойлон адислах ёслол болов

Гватемалын Кесальтенанго ариун сүмийг 2011 оны 12-р сарын 11 ням гарагт Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх Ерөнхийлөгч Диетер Ф.Угдорф онцгойлон адислав. Уг ариун сүмийн бүст харьяалагдах Сүмийн цугларагсад зориулан онцгойлон адислах ёслолыг шууд дамжуулан үзүүлсэн.

Бямба гарагт болсон залуучуудын дуу, бүжиг, түүх соёлоо харуулсан урлагийн үйл ажиллагааны үеэр Ерөнхийлөгч Угдорф “энэ ямар гайхалтай сайхан ариун сүм бэ” гэж хэлэв. Энэхүү ариун сүм яг эрдэнийн чулуу мэт гэрэлтэж байна. Энэ бол энэ орны энэ бүсийн үнэт эрдэнэ мөн.

Гватемалын Кесальтенанго ариун сүм нь Сүмийн 136 дахь харин Төв Америкийн 5 дахь ариун сүм юм. Уг ариун сүм нь ойролцоогоор 60,000 -н Хожмын Үеийн Гэгээнтнүүдэд үйлчлэх болно.

Бразилийн долоо дахь ариун сүмийн газрыг хөндөв

2011 оны 11-р сарын 15-нд Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Давид А.Беднар Бразилийн долоо дахь ариун сүм болох Бразилийн Форталеза ариун сүмийн газар хөндөх ёслолын ажиллагааг удирдав.

“Энд ирэх, энүүгээр алхах хүн бүрд уг ариун сүм найдвар, гэрэл ба Бурханд итгэх итгэлийн эх үндэс болох болно. Ариун сүм энд баригдаж байгаа учраас энэ хот улам сайжирч, өөрчлөгдөх болно” гэж ахлагч Беднар хэлэв.

Энэ ариун сүмийг Бразилийн Сеара Форталезагийн Авенида Сантос Думонтод барих болно. Ерөнхийлөгч Томас С.Монсон 2009 оны ерөнхий чуулганы үеэр Бразилийн Форталеза ариун сүмийг барина хэмээн зарласан юм. ■

Пуэрто Рикод болсон концертыг олон мянган хүн үзэв

2011 оны 12-р сарын 18-нд Кагуас хотын Пасео де лас Артедс болсон Христийн мэндэлсний баярын концертэнд Пуэрто Рикогийн 5 гадасны гишүүд оролцов. 85 орчим Сүмийн гишүүд, орон нутгийн 2500 гаруй хүмүүстэй хамт урлагийн тоглолт үзүүлэв.

Залуу насанд хүрэгчдийн шинэ байр нь Африкийн гурав дахь байр боллоо

2011 оны 11-р сарын 4-нд Өмнөд Африкийн Совето гадасны залуу насанд хүрэгчид уг шинэ байранд анхны үйл ажиллагаагаа хийлээ.

Ийм төв Европ даяар 140 гаруй байдаг бөгөөд АНУ-д цөөн хэд байдаг юм. Советогийн төв нь Африкийн гурав дахь төв бөгөөд үлдсэн хоёр нь Конгийн Ардчилсан Бүгд Найрамдах Улс болон Зимбабвед байдаг.

Өвөрмөц үйл ажиллагаа хүмүүсийг асуулт тавихад хүргэв

Хуйлдаг цаасыг анх 2011 оны 10-р сарын 9-нд Оросын Нижний Новгород хотын номлогч нар сэджээ.

Хотын хөдөлгөөн ихтэй гудамжинд 2 цагийн туршид 150 гаруй хүн өөрсдийн асуултыг бичиж ширээн дээр үлджээ. Хуйлдаг цаасан дээр нийт 84 асуулт бичсэн байв. Тэнд байсан номлогчдоос олон хүн өөрсдийн сонирхсон зүйлсээ асуусан байна.

Эдгээр болон бусад түүхийг news.lds.org-с уншина уу. ■

Хэрэгтэй луужин

Лиахона бол амьдралын маань чиглүүлэгч мөн. Үүнтэй байхад би хэзээ ч төөрөхгүй. Сүмийн сэтгүүлийг уншсан хүн бүр өөрт хэрэгтэй зүйлийг олж чадна гэдэгт би итгэдэг. Би Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгч бөгөөд хүүхдүүд сэтгүүл дээр гарсан хүүхдүүдийн түүхийг сонсох дуртайг би хардаг. Лиахона бол бидний амьдралд чухал хэрэгтэй луужин бөгөөд энэ нь биднийг Сатаны уруу таталтаас зайлсхийхэд тусалдаг.


Янина Ивановна Давиденко, Украин

Бусдын туршлагаас амар амгаланг олдог

Лиахона дээр гардаг захиас болон өгүүлэл нь надад маш их тусалдаг. Бидний амьдрал ачаалал ихтэй завгүй байдаг ч би үргэлж Лиахонагаас бусад гишүүдийн амьдралын туршлагаас өгүүлсэн өгүүллүүдийг уншдаг. Тэдгээр өгүүлэл нь надад сүнслэг амар амгалан байдлыг өгч, гэр бүлтэйгээ хамт Бурхан болон Есүс Христ рүү буцах хүслийг маань шинэчилдэг.

Жуан Карлос, Бразил

Санал зөвлөмжөө liahona@ldschurch.org хаягаар илгээнэ үү. Ирүүлсэн материалуудыг хэмжээ, тодорхой байдлын хувьд хянан засварлаж болно. ■



Энэ дугаарт гэр бүлийн үдэшт ашиглахуйц өгүүлэл, үйл ажиллагаанууд байгаа. Доор хоёр жишээ өгөгдсөн болно.



“Семинараас ирэх адислал” 20-р хуудас: уг өгүүллийг урьдчилан уншиж, бэлдээд гэр бүлдээ хэрхэн хэрэгжүүлэх талаар шийд. Хэрэв танайх семинарт явдаг хүүхэдтэй бол яагаад семинар түүнд чухал болохыг нь асуугаарай. Дараа нь “Амлагдсан адислалуудыг хүлээн авах нь” хэсгийг унш. Семинарын насанд хүрээгүй хүүхдүүдийг зохих насанд хүрээд семинарт явахад нь урамшуулан дэмж. Хэрэв танайд семинарын насны хүүхэд байхгүй бол өгүүллийг уншаад өнөөгийн залуучуудад семинарт явах нь яагаад чухал болох талаар ярилц.

“Бүгд Блекийг таньдаг” 42-р хуудас: Блекийн тухай түүхийг уншиж, дүгнэ. Шийдэхэд хэцүү асуудлаа хэрхэн шийдвэрлэсэн болон үр дүн нь ямар байсан тухай хуваалцахыг гэр бүлийн гишүүдээсээ хүс. Ерөнхийлөгч Томас С.Монсоны хэлсэн үгээс эш татан ярилцлагаа өндөрлө. ■

Энгийн, намуухан бас мартагдашгүй

Энэ бол хоёр охинтойгоо хийсэн мартагдашгүй гэр бүлийн цуглаан байв. Нэг охиныг маань Анжелика гэдэг тэр зургаан настай. Харин нөгөө охиныг маань Бетани гэдэг тэр дөрвөн настай. Нөхөр бид хоёр ихэд ядарсан тул сандал дээрээ шигдэн суугаад гэр бүлийн цуглаанаа яаж эхлэхээ мэдэхгүй байв. Гэтэл охидууд маань санаачлагыг гартаа авч бидэнд үүрэг даалгавар өгөв. Нөхөр маань хөгжим удирдаж, Бетани хөгжимдөж, би тоглоом буюу үйл ажиллагаа сэдэж, Анжелика хичээл заахаар болов.

Бетани “Би ариун сүм харах дуртай”-г (*Children’s Songbook* 95) сонгож бид хамтдаа дууллаа. Аав нь нээлтийн залбирал хийв. Дараа нь Анжелика Лиахона сэтгүүлийн хамгийн сүүлийн дугаарыг авч, хүүхдэд зориулсан хэсгээс нэг өгүүлэл сонголоо. Тэрээр сургууль дээрээ уншиж сурч байгаа тул өгүүллийг бидэнд уншиж өгөв. Гэр доторх уур амьсгал намуухан байлаа. Түүний уншиж байгаа зүйлийг үнэн гэдгийг Сүнс гэрчилж байсан.

Тэгээд бид хамтдаа тоглож, би хаалтын залбирал хийв. Хаалтын залбирал хийхдээ би Тэнгэрлэг Эцэгтээ Түүний Сүнсэнд мөн хоёр бяцхан сүнсээр гэр бүлийг маань адисалсанд талархахгүй байж чадахгүй байлаа. Бидний үүрэг бол тэднийг халамжилж, тэдэнд сайн мэдээг заах гэдгийг нөхөр бид хоёр мэддэг. Гэр бүлийн цуглааныг хийх нь тэр нандин үүргийн нэг хэсэг юм. ■

Силвиа Поуссин, Риоүнин



**Бишоп
Ричард К.Эйжли**

Тэргүүлэх Бишопын
Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх

ЦАГААТГАЛД НАЙДАХ НЬ

Итгэл найдвараа алдаж цөхөрсөн хүмүүстэй би тааралдаж байсан. Тэд наманчлалыг өөрт нь хэрэгтэй зүйл гэж боддоггүй, уучлалыг өөрт нь огт хамаагүй хэрэг гэж үздэг. Ийм хүмүүс Цагаатгалын ариусгагч хүчийг ойлгодоггүй. Эсвээс, тэд ойлгодог юмаа гэхэд Есүс Христ Гетсеманид болон загалмай дээр хэрхэн тарчлан зовсны утга учрыг мах цусандаа шингэтэл ойлгодоггүй. Бидний хэн нь ч гэсэн амьдралаа цэвэр ариун байлгах итгэл найдвараа алдвал, энэ нь Тэр бидний төлөө санаанд багтамгүй ихээр зовон шаналсныг үгүйсгэсэн хэрэг болно.

Хэдэн жилийн өмнө би нэгэн гадасны чуулганд оролцох үеэрээ номлолд үйлчлэх зохистой эсэхийг нь тодорхойлохоор 21 настай нэг залуутай ярилцлага хийж билээ. Харин одоо Ерөнхий эрх мэдэлтнүүд номлогч болох хүмүүстэй ярилцлага хийхээ больсон. Харин тэр ярилцлага ер бусын байдалтай болсон юм. Ярилцлага хийхээсээ өмнө нөгөө залуугийн тухай товч мэдээллийг уншаад, зүрх шимшрэн өвдөв. Тэр залуу гэм нүглийг үйлдэжээ. Номлогч болох залуутай ийм мэдээлэл дээр үндэслэн ярилцлага хийнэ үү гэж надаас хүссэний учрыг би олж ядан байлаа. Тэр залууг номлогчоор батлахыг санал болгох нь ерөөсөө байж болно гэж үү?

Чуулганы бямба гарагийн үдээс хойших хуралдааны дараа ярилцлага хийхээр гадасны ерөнхийлөгчийн өрөөнд орлоо. Түр хүлээж суутал нүдэнд дулаахан, царайлаг аятайхан залуу орж ирэв. Тэр залуу надтай ярилцах хүсэлтэй байгаа нь илт харагдаж байлаа. Харин би болохоор гэм нүгэлд сүрхий орооцолдсон залуутай ярилцлага хийх гэж байдаг. Яана даа гэж бодож суулаа. Тэгтэл нөгөө залуу өөрийгөө танилцуулав. Тэр бол ярилцлага хийхээр миний хүлээж байсан залуу байлаа.

Итгэл найдвар нь зөвхөн мэдлэг, гэрчлэл дээр төдийгүй бас бид Цагаатгалыг амьдралдаа бодитой үйл хэрэг болгох явдал дээр тулгуурлах ёстой.

“Ямар учраас би тантай ярилцлага хийж байгааг мэдэх үү?” гэсэн ганцхан асуултыг л би түүнээс асууж билээ.

Тэр залуу туулсан амьдралаа тоочив. Тэгээд алдаагаа засахын тулд юу хийсэн болон сэтгэл санааны ямар хэцүү зовлон шаналал туулснаа ярьж эхлэв. Тэр Цагаатгал болон түүний хязгааргүй хүчний тухай яриад, гэрчлэлээ хэлж, Аврагчид хайртайгаа илэрхийлэв. Тэгээд нөгөөх залуу, “Гетсемани дахь Аврагчийн зовлон шаналал, загалмай дээрх Түүний золиослол бүр над шиг хүнийг ч аврахад хангалттай хүчтэй байсанд би итгэдэг” гэж билээ.

Миний бие түүний даруу зан болон Сүнсээр нөлөөлөгдөн, “Би таныг Есүс Христын төлөөлөгчөөр үйлчлүүлэхээр санал болгоно” гэж хэлээд, харин “Танаас ганцхан зүйлийг л хүсье. Сүмийн хэмжээнд хамгийн шилдэг номлогч болоорой. Ингээд л болоо” гэж билээ.

Гурав, дөрвөн сарын дараа Эйжли эгч бид хоёр номлогчийн бэлтгэлийн төв дээр үг хэллээ. Онцгой цугларалтын төгсгөлд би номлогчидтой уулзаж байгаад нэгэн танил нүүрийг олж харлаа.

“Та намайг санаж байна уу?” гэж нөгөө залуу асуув.


Би жаахан ичсэнээ, “Уучлаарай. Таньдаг юм шиг хэрнээ санадаггүй ээ” гэв.

Тэгтэл нөгөөх залуу, “Би хэн бэ гэдгээ танд хэлье л дээ. Би бол номлогчийн бэлтгэлийн төвийн хамгийн шилдэг номлогч байна” гэв. Би ч түүнд итгэсэн.


Тэр залуугийн итгэл найдвар зөвхөн Цагаатгалын тухай мэдлэг болон гэрчлэл дээр төдийгүй бас энэхүү Цагаатгал хувь хүний амьдралтай хүйн холбоотой гэдэгт тулгуурласан байлаа. Цагаатгал чухам өөрт нь зориулагдсаныг тэр ойлгосон ажээ! Цагаатгалын хүч болон бүх зүйл байхгүй эсвээс найдваргүй болсон юм шиг санагдсан үед Цагаатгалын өгдөг хүч чадлыг тэр мэддэг болжээ. ■

2008 оны 11-р сарын 4-нд Бригам Янгийн Их Сургууль дээр болсон онцгой цугларалт дээр хэлсэн үгнээс Англи хэл дээрх бүрэн эхийг speeches.byu.edu-гээс үзнэ үү.

Энэ жил *Лиахонагийн* олон дугаарт Мормоны Номын судрын баатруудын цуврал зургууд нийтлэгдэх болно. Судрын баатруудын дүрсийг бат бөх бөгөөд ашиглахад хялбар болгохын тулд хайчилж аван, хатуу цаас, жижигхэн цаасан уут юм уу гар хийцийн савхан дээр наа. Цуврал бүрийг дугуй юм уу цаасан уутанд эдгээр баатруудын тухай судрын түүх хаана байдгийг өгүүлсэн тэгш өнцөгтийн хамт хийж хадгал.



Алма



Амюлек



Зиезром

Алма, Амюлек хоёр аммонайхачуудад номлосон нь

Алма 8–14



Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Давид А.Беднар: “Та бид ядарч туйлдсан үедээ ‘хэн ч намайг ойлгохгүй юм. Хэн ч миний зовлонг мэдэхгүй’ хэмээн цөхөрч дуу алддаг. Бурханы хүү бидний ачаа дарамтыг биеэрээ мэдэрч, үүрсэн учраас хэнээс ч илүүтэйгээр биднийг төгс мэддэг бөгөөд ойлгодог. Тэрбээр энэхүү ачаа дарамтын төлөөсийг бүрэн төлж, өөрөө үүрдэг болохоор биднийг төгс ойлгож, бидний амьдралын олон үе шатанд нигүүлслийн мутраа сунгадаг билээ. Тэрбээр чухамдаа бидний дэргэд гүйж ирэн, биднийг сэтгэл санаагаар өргөн дэмжиж, хүч чадал өгч чадна” хэмээн бичжээ. “Цагаатгал ба бидний амьдрал дахь аян,” х. 12-г үз.